



**САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛЬ**  
**САНХҮҮ УДИРДЛАГЫН МАСТЕРЫН ХӨТӨЛБӨР**

**Цагаануул**  
**Ган-Очирын АМАРБАЯСГАЛАН**

**Амардалай**  
**Батсуурийн БАЯРМАА**

**Бөөгүүд**  
**Түмэндэмбэрэлийн ЖАВЗАНДУЛАМ**

**Монгол Улсын төсөв ба салбарын ДНБ-ий шинжилгээ**



**Мэргэжлийн индекс**  
**E04120101**

**Санхүүгийн удирдлагын**  
**Мастерын зэрэг горилсон судалгааны ажил**

**Удирдсан**  
**Т.Оюунгэрэл /Ph.D/**  
**Б.Мөнхзаяа /Ph.D/**



**САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛЬ**  
**САНХҮҮ УДИРДЛАГЫН МАСТЕРЫН ХӨТӨЛБӨР**



**Цагаануул**  
**Ган-Очирын АМАРБАЯСГАЛАН**

**Амардалай**  
**Батсуурийн Баярмаа**

**Бөөгүүд**  
**Түмэндэмбэрэлийн ЖАВЗАНДУЛАМ**

**Монгол Улсын төсөв ба салбарын ДНБ-ий шинжилгээ**



Мэргэжлийн индекс  
E04120101

Санхүүгийн удирдлагын  
Мастерын зэрэг горилсон судалгааны ажил

Удирдагч: ..... Т.Оюунгэрэл /Ph.D/

..... Б.Мөнхзаяа /Ph.D/

Зөвлөх: .....

Шүүмж: .....

## **ГАРЧГИЙН ТОВЬЁОГ**

МЭДЭГДЭХ ХУУДАС .....	i
ТАЛАРХАЛ.....	ii
ТОВЧ ХУРААНГУЙ.....	iii
ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ .....	iv
ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ .....	v
ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ .....	vi
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ .....	vii
УДИРТГАЛ.....	1
<b>I БҮЛЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ХАМААРАЛ ОНОЛ, АРГА ЗҮЙН СУДАЛГАА .....</b>	<b>3</b>
1.1 Сэдвийн судлагдсан байдал.....	3
Дотоодод судлагдсан байдал.....	3
Гадаадад судлагдсан байдал.....	4
1.2 Эдийн засгийн өсөлт, түүнд нөлөөлөх хүчин зүйлс.....	9
1.3 Улсын төсөв ба эдийн засгийн хамаарлыг тодорхойлох онол, арга зүй.....	12
1.3.1 Төсвийн ангилал ба тогтвортой байдлын шалгуур үзүүлэлт .....	13
1.3.2 Улсын төсөв, эдийн засгийн өсөлтийн загварын харьцуулсан судалгаа .....	13
Нэгдүгээр бүлгийн дүгнэлт .....	16
<b>II БҮЛЭГ. УЛСЫН ТӨСӨВ, ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ .....</b>	<b>17</b>
2.1 Улсын нэгдсэн төсвийн өнөөгийн байдал.....	17
2.1.1 Улсын нэгдсэн төсвийн орлого ба тусламжийн дүн.....	17
2.1.2 Улсын нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэлийн дүн.....	18
2.1.3 Төсвийн тэнцлийн өнөөгийн байдал.....	20
2.2 МУ-ын эдийн засгийн өсөлт болон салбарын зарцуулалтын өнөөгийн байдал.....	22
2.3 МУ-н төсвөөс санхүүждэг салбаруудад олон улсын байгууллагуудаас хийсэн шинжилгээний нэгтгэл.....	26
2.3.1 Хөдөлмөрийн салбарын төсвийн шинжилгээ .....	27
2.3.2 Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын төсвийн шинжилгээ .....	28

2.3.3 Боловсролын салбарын төсвийн шинжилгээ .....	31
2.3.4 Хүнс хөдөө аж ахуйн салбарын төсвийн шинжилгээ .....	31
Хоёрдугаар бүлгийн дүгнэлт .....	32
III БҮЛЭГ. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ .....	34
3.1 Судалгааны дизайн, үе шат .....	34
3.2 Судалгааны өгөгдөл, шинжилгээний аргачлал .....	35
Гуравдугаар бүлгийн дүгнэлт .....	38
IV БҮЛЭГ. ЭМПИРИК СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ БА ҮР ДҮН .....	39
4.1 Төсвийн шалгуур үзүүлэлтээр шинжлэх нь .....	39
4.1.1 Шалгуур үзүүлэлт 1: Тэнцвэржүүлсэн орлого (Дэлхийн зах зээл дээрх зэсийн үнэ) .....	39
4.1.2 Шалгуур үзүүлэлт 2: Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл .....	39
4.1.3 Шалгуур үзүүлэлт 3: Зарлагын хязгаарлалт .....	40
4.1.4 Шалгуур үзүүлэлт 4: Засгийн газрын нийт өр, зээлийн баталгааны түвшин ..	40
4.2 Төсвийн зарлага ба ДНБ хамаарлын шинжилгээ .....	42
4.3 Салбарын ДНБ, зарлагын шинжилгээ (төсвийн нийт зарлага ба ДНБ-д эзлэх хувиар) .....	46
4.3.1. Батлан хамгаалах салбарын зарлага болон ДНБ-д эзлэх хувь .....	47
4.3.2 Тээврийн салбарын зарлага болон ДНБ-д эзлэх хувь .....	47
4.3.3 Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн салбарын зарлага болон ДНБ-д эзлэх хувь .....	48
4.3.4 Барилгын салбарын зарлага болон ДНБ-д эзлэх хувь .....	49
4.3.5 Боловсролын салбарын зарлага болон ДНБ-д эзлэх хувь .....	49
4.3.6 Уул уурхайн салбарын зарлага болон ДНБ-д эзлэх хувь .....	50
4.3.7 Эрчим хүчний салбарын зарлага болон ДНБ-д эзлэх хувь .....	51
4.3.8 Нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн салбарын зарлага болон ДНБ-д эзлэх хувь .....	51
4.3.9 Аялал жуулчлалын салбарын зарлага болон ДНБ-д эзлэх хувь .....	52
4.4 Алсын хараа 2050 тогтвортой хөгжлийн зорилт ба гүйцэтгэл /Салбараар/ .....	53

4.5 ДНБ-д эзлэх Засгийн газрын зардлын хувийг улс орнуудын орлогын түвшний ангилалаар харьцуулсан шинжилгээ .....	55
4.6 ДНБ-салбарын ангилал ба бусад голлох хүчин зүйлсийн шинжилгээ.....	57
4.6.1 Шугаман регрессийн шинжилгээ.....	57
4.6.2 Олон хүчин зүйлсийн регрессийн шинжилгээ .....	60
Шинжилгээний үр дүнгүүд.....	65
ДҮГНЭЛТ.....	69
САНАЛ ЗӨВЛӨМЖ.....	72
НОМ ЗҮЙ .....	i
ХАВСРАЛТ.....	i

## МЭДЭГДЭХ ХУУДАС

Энэхүү судалгааны ажил нь судлаачдын өөрийн бүтээл болохыг баталж байна. Энэхүү бүтээл нь СЭЗИС-ийн оюуны өмч болох бөгөөд тус сургуулийн номын сан судалгааны ажлыг нийтийн хүртээл болгохыг зөвшөөрч байна.

Магистрантын нэр:

Г.Амарбаясгалан

Магистрантын нэр:

Б.Баярмаа

Магистрантын нэр:

Т.Жавзандулам

Огноо: 2023/05/10

## ТАЛАРХАЛ

“Монгол Улсын төсөв ба салбарын ДНБ-ий шинжилгээ” сэдэвт судалгааны ажлыг Т.Оюунгэрэл (Ph.D), Б.Мөнхзаяа (Ph.D) багш нараар удирдуулсан магистрант Г.Амарбаясгалан, Б.Баярмаа, Т.Жавзандулам нарын баг хийж гүйцэтгэлээ.

Мастерын судалгааны ажилд үнэтэй зөвлөмжүүдийг өгч удирдсан, судалгаа шинжилгээ боловсруулах арга зүй, ажлын стандартын шаардлага болон уялдаа холбоог сайжруулахад алхам бүрт чиглүүлж байсан Т.Оюунгэрэл(Ph.D), Б.Мөнхзаяа(Ph.D), багш нартаа болон СЭЗИС-ийн мастерын хөтөлбөрийн хамт олонд, санал зөвлөмж, шүүмж бичсэн багш нартаа, тусалж дэмжсэн гэр бүлдээ багийн гишүүдийн зүгээс гүн талархал илэрхийлж цаашдын эрдмийн ажилд нь өндөр амжилт, эрүүл энх, сайн сайхныг хүсье.

Энэхүү судалгааны ажлыг бичигдэхэд нөлөөлсөн бүх шалтгаан, нөхцлүүдэд баярлалаа

## ТОВЧ ХУРААНГУЙ

Монгол улсын төсвөөс санхүүждэг салбаруудад олон улсын байгууллагуудаас хийсэн шинжилгээний нэгтгэл дүнгээр салбарын бодлогын зорилтууд болон төсвийн зарцуулалт хооронд уялдаагүй гэсэн дүгнэлтүүд гарсан байна. Засгийн газрын урсгал зардлыг хуваарилахдаа салбаруудын бодлогын зорилго, зорилттой нь уялдуулахгүй, нийгмийн халамж зэрэгт үр ашиггүй зарцуулах нь төсвийн тэнцлийн алдагдалд оруулах, эдийн засгийн өсөлтийг сааруулах, төсвийн зарцуулалтын гол зорилго болох ажилгүйдлийг бууруулах болон ажил эрхлэлтийг дэмжихэд чиглэхгүй байна.

Төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувь нь 2018 онд 29%, 2019 онд 31%, 2020 онд 37%, 2021 онд 36%, 2022 онд 34% болж тасралтгүй өсөлттэй байгаа нь ирээдүйд эдийн засаг төсөвт үзүүлэх ачааллыг салбараар дүгнэх асуудал тулгамдаж байна.

Монгол улсын өнөөгийн байдлыг Дэлхийн банкны мэдээллээс шинжилж үзэхэд Засгийн газрын зарцуулалт ДНБ-д эзлэх түвшин нь 33 хувь байгаа нь 2020 оны байдлаар орлогын түвшнээр ойролцоо орнуудаас даруй 7.5 хувиар өндөр, дундаас дээгүүр орлоготой орнуудтай харьцуулахад 2.3 хувиар өндөр буюу төсвийн зарцуулалтыг өөрийн эдийн засгийн чадавхи, боломжоос хэтэрсэн зардалтай байгааг харуулж байна.

Эмпирик шинжилгээний хэсэгт 1991-2022 оны макро эдийн засгийн болон төсвийн зарлага, ДНБ-ий мэдээлэлд тулгуурлан шинжилж *1.Төсвийн тусгай шаардлагын шалгуур үзүүлэлт, 2. Төсвийн зарлага ба ДНБ хамаарал, 3. Салбарын ДНБ төсвийн зарлага, 4. Алсын хараа-2050 тогтвортой хөгжлийн зорилт ба салбарын гүйцэтгэл, 5. ДНБ-д эзлэх ЗГ-ын зардлын хувийг улс орнуудын орлогын түвшний ангилалаар шинжлэх, 6.Салбарын ангилалыг шугаман болон олон хүчин зүйлийн регрессийн загвараар үнэллээ.*

Сүүлийн 20 жилийн хугацаанд буюу 2001-2022 онуудад ДНБ-ий нэрлэсэн дүнгээрээ өсөж жилийн өсөлтийн хувь 19.0% -иар нэмэгдэж байгаа ч, инфляцийн нөлөөг тооцсон бодит дүнгээр жилийн өсөлтийн хувь 6.1% байна. Өнгөрсөн хугацаанд төсвийн зардлын өсөлтийн хувь жилд дунджаар 19.9% өсөж байсан нь эдийн засгийн өсөлтийг дэмжихгүй байна. Төсвийн зарцуулалт болон салбарын өсөлтийн хооронд сөрөг хамаарал ажиглагдсан. Энэ нь төсвийн зарлага үр ашиггүй байгааг харуулж байна. Салбарыг үнэлсэн индикаторууд нь статистикийн хувьд ач холбогдолтой гарсан ба онолын судалгааны хувьд үр дүнтэй нийцтэй байна.

Судалгаанаас Засгийн газрын зардлын дүнг батлахдаа салбарт оруулсан зардал, салбарын ДНБ-ий харьцаа үзүүлэлтийг эдийн засгийн засгийн үр ашиг бүхий байдлаар нөлөөллийг тооцох нь тохиромжтой гэсэн үр дүн гарсан ба эндээс салбарын бодлого, төсөв уялдаатай байх нь эдийн засгийн өсөлтийг урт хугацаанд дэмжих нэн тэргүүний асуудал гэдгийг харуулж байна.

**Түлхүүр үгс:** Улсын төсвийн зардал, ДНБ, салбарын ДНБ, Эдийн засгийн өсөлт



## ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Панел өгөгдөл ашиглан төсвийн зарлага ба эдийн засгийн өсөлтийн шинжилгээг хийсэн судалгаануудын харьцуулалт .....	14
Хүснэгт 2. Эдийн засгийн өсөлтийн шинжилгээг хугацааны цуваа ашиглан хийсэн судалгааны харьцуулалт .....	15
Хүснэгт 3. Улсын нэгдсэн төсвийн орлого ба тусламжийн дүн (тэрбум төгрөг) .....	18
Хүснэгт 4. Улсын нэгдсэн төсвийн зарлагын үзүүлэлт (тэрбум төгрөг) .....	19
Хүснэгт 5. Засгийн газрын тэнцвэржүүлсэн тэнцэл, ДНБ-ий үзүүлэлт .....	21
Хүснэгт 6. Засгийн газрын өрийн үзүүлэлт .....	22
Хүснэгт 7. Улсын төсвийн зарлага ба ДНБ /салбараар, тэрбум төгрөг/.....	24
Хүснэгт 8. Хөдөлмөрийн салбарын орц, гарцын үр дүн.....	28
Хүснэгт 9. БОАЖЯ-ны салбарт хэрэгжиж буй Гадаадын зээл, тусламжийн төслүүд (2022) .....	29
Хүснэгт 10. БОАЖ-ын салбарт хэрэгжиж буй Гадаадын зээл, тусламжийн төслүүд (2022) .....	30
Хүснэгт 11. Шалгуур үзүүлэлт 1-ийн хангасан байдал .....	39
Хүснэгт 12. Шалгуур үзүүлэлт 2-ийн хангасан байдал .....	39
Хүснэгт 13. Шалгуур үзүүлэлт 3-ийн хангасан байдал .....	40
Хүснэгт 14. Шалгуур үзүүлэлт 4-ийн хангасан байдал .....	41
Хүснэгт 15. Төсвийн тусгай шаардлагыг хангасан байдал .....	42
Хүснэгт 16. Салбар тус бүрээр ДНБ ба төсвийн зарлага .....	46
Хүснэгт 17. “АЛСЫН ХАРАА-2050” Үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин .....	53
Хүснэгт 18. Хөдөө аж ахуйн салбарын судалгаанд ашиглаж буй тоон өгөгдөл .....	60
Хүснэгт 19. Хөдөө аж ахуйн салбарын регрессийн үнэлгээ01 .....	61
Хүснэгт 20. Хөдөө аж ахуйн салбарын регрессийн үнэлгээ02 .....	61
Хүснэгт 21. Хөдөө аж ахуйн салбарын регрессийн үнэлгээ03 .....	61
Хүснэгт 22. Хөдөө аж ахуйн салбарын регрессийн үнэлгээ04 .....	61
Хүснэгт 23. Хөдөлмөр,нийгмийн хамгааллын салбарын судалгаанд ашиглаж буй тоон өгөгдөл.....	62
Хүснэгт 24. Хөдөлмөр,нийгмийн хамгааллын салбарын регрессийн үнэлгээ .....	62
Хүснэгт 25. Уул уурхайн салбарын судалгаанд ашиглаж буй тоон өгөгдөл.....	63
Хүснэгт 26. Уул уурхайн салбарын регрессийн үнэлгээ .....	63
Хүснэгт 27. Боловсролын салбарын судалгаанд ашиглаж буй тоон өгөгдөл.....	64
Хүснэгт 28. Боловсролын салбарын регрессийн үнэлгээ .....	64

Хүснэгт 29. Аялал жуулчлалын салбарын судалгаанд ашиглаж буй тоон өгөгдөл.....	65
Хүснэгт 30. Аялал жуулчлалын салбарын регрессийн үнэлгээ .....	65

## **ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ**

Зураг 1. ДНБ-ийг тооцох аргачлал.....	10
Зураг 2. ДНБ эцсийн ашиглалтын аргаар илэрхийсэн орчил.....	10
Зураг 3. Монгол улсын төсвийн бүтэц .....	17
Зураг 4. Улсын нэгдсэн төсвийн орлого, тусламжийн дүн.....	18
Зураг 5. Улсын нэгдсэн төсвийн зардлын бүтэц .....	19
Зураг 6. Монгол улсын нэгдсэн төсвийн орлого, зардал ба тэнцэл /2000-2022/.....	20
Зураг 7. Эдийн засгийн өсөлт болон төсвийн тэнцлийн хамаарал /2000-2021/.....	21
Зураг 8. ДНБ-д эзлэх Засгийн газрын зардлын хувь хэмжээ.....	22
Зураг 9. Сүүлийн 10 жилийн ДНБ болон Төсвийн зарлагын дүн/салбараар, их наяд төг/ .....	25
Зураг 10. ДНБ голлох салбаруудын эзлэх дундаж хувь (2012-2021) .....	25
Зураг 11. Монгол улсын төсвийн зардлын салбаруудад хуваарилалт (2012-2022).....	26
Зураг 12.Төсвийн ерөнхийлөн захирагчид өгсөн дүгнэлт.....	27
Зураг 13. Судалгааны дизайн.....	34
Зураг 14. Судалгааны үе шат.....	35
Зураг 15. Нэрлэсэн ДНБ болон ДНБ-ий өсөлтийн хувь .....	43
Зураг 16. БДНБ болон Инфляцийн түвшин .....	43
Зураг 17. НДНБ, төсвийн зарлагын өсөлтийн хувь.....	44
Зураг 18. БДНБ, төсвийн зарлагын өсөлтийн хувь .....	45
Зураг 19. Монгол улсын нэг хүнд ногдох ДНБ(ам.доллар) .....	45
Зураг 20. Батлан хамгаалах салбарын ДНБ ба төсвийн зарлагын үзүүлэлт.....	47
Зураг 21. Зам тээврийн салбарын ДНБ ба төсвийн зарлагын үзүүлэлт .....	48
Зураг 22. Хүнс хөдөө аж ахуйн салбарын ДНБ ба төсвийн зарлагын үзүүлэлт.....	48
Зураг 23. Барилгын салбарын ДНБ ба төсвийн зарлагын үзүүлэлт.....	49
Зураг 24. Боловсролын салбарын ДНБ ба төсвийн зарлагын үзүүлэлт .....	50
Зураг 25. Уул уурхайн салбарын ДНБ ба төсвийн зарлагын үзүүлэлт.....	50
Зураг 26. Эрчим хүчний салбарын ДНБ ба төсвийн зарлагын үзүүлэлт .....	51
Зураг 27. Нийгмийн хамгааллын салбарын ДНБ ба төсвийн зарлагын үзүүлэлт .....	52

Зураг 28. Аялал жуулчлалын салбарын ДНБ ба төсвийн зарлагын үзүүлэлт .....	52
Зураг 29. Уул уурхайн салбарын ДНБ-д эзлэх хувь, зорилтот түвшин.....	53
Зураг 30. Боловсруулах үйлдвэрийн салбарын ДНБ-д эзлэх хувь, зорилтот түвшин .....	54
Зураг 31. Тээврийн салбарын ДНБ-д эзлэх хувь, зорилтот түвшин.....	54
Зураг 32. Батлан хамгаалахын салбар дахь төсвийн зардлын ДНБ-д эзлэх хувь (улс орнуудын орлогын ангиллаар).....	55
Зураг 33. Хөдөө аж ахуй салбар дахь төсвийн зардлын ДНБ-д эзлэх хувь (улс орнуудын орлогын ангиллаар).....	56
Зураг 34. Эрүүл мэндийн салбар дахь төсвийн зардлын ДНБ-д эзлэх хувь (улс орнуудын орлогын ангиллаар).....	56
Зураг 35. Боловсролын салбар дахь төсвийн зардлын ДНБ-д эзлэх хувь (улс орнуудын орлогын ангиллаар).....	57
Зураг 36. Шугаман регрессийн шинжилгээ.....	57

## **ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ**

Хавсралт 1. Хөдөө аж ахуйн салбарын үнэлгээ.....	i
Хавсралт 2. Хөдөлмөр нийгмийн хамгааллын салбарын үнэлгээ .....	i
Хавсралт 3. Уул уурхайн салбарын үнэлгээ .....	ii
Хавсралт 4. Боловсролын салбарын үнэлгээ .....	ii
Хавсралт 5. Монгол улсын ДНБ, Төсвийн зарлагын дүн 2001-2022он (тэрбум төг).....	iii
Хавсралт 6. Төсвийн нийт зарлага болон ДНБ-д эзлэх хувь (салбараар) .....	iii
Хавсралт 7. Бодит ДНБ-ий дүн, БДНБ-ий өсөлтийн хувь, Инфляцийн нөлөө (2000-2022) .....	iv
Хавсралт 8. Төсвийн зарлага болон ДНБ-салбарын өсөлтийн хувь 2010-2021.....	iv

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
БДНБ	Бодит Дотоодын нийт бүтээгдэхүүн
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилт
ОУ	Олон улс
МУ	Монгол улс
УИХ	Улсын их хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
СЯ	Сангийн яам
УУХҮЯ	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
ХХАХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХНХЯ	Хөдөлмөр нийгмийн хамгаалалын яам
БОАЖЯ	Байгаль орчин аялал жуулчлалын яам
ҮСХ	Үндэсний статистикийн хороо

## УДИРТГАЛ

Төсвийн зарлага ба ДНБ-ний хамаарал нь төсвийн цар хүрээг хэмжих үзүүлэлт бөгөөд төсвийн зардлыг нийгэм эдийн засгийг сэргээхэд зарцуулах нь чухал юм. Төсвийн зарлага ба ДНБ-ий хооронд тодорхой харилцан хамаарал байдаг бөгөөд энэ нь тухайн улсын эдийн засгийн байдлыг илэрхийлэхээс гадна тухайн улсын үндэсний хүч чадал, баялгийг тусгаж чадна гэж үздэг. Өөрөөр хэлбэл ДНБ-ий өөрчлөлт нь тухайн үеийн эдийн засгийн хөгжлийн нөхцөл байдлыг илэрхийлдэг (Zhang, 2022).

Төсвийн орлого болон төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувь нь эдийн засгийн үр өгөөжийн чухал үзүүлэлт болж чаддаг. Үндэсний үйлдвэрлэлийн үнэ цэнийг хуваарилах үйл явцад төсвийн оролцоог төсвийн зарлагад тусгах шаардлагатай, учир нь төсвийн зарлага нь хөрөнгө хаашаа хэр их урсаж байгааг бодитоор харуулдаг. Иймээс төсвийн санхүүгийн зарлага нь нийгмийн нөхөн үйлдвэрлэлд чухал нөлөө үзүүлдэг. Үүний зэрэгцээ, төсвийн зарлага нь макро эдийн засгийг зохицуулах үүрэгтэй (Wang, 2021).

Дэлхийн өрсөлдөх чадварын төвийн зүгээс “Дэлхийн дахины өрсөлдөх чадварын тайлан, 2022”-нд Монгол улс өрсөлдөх чадварын индексээрээ судалгаанд харьцуулах боломжтой, сонгогдсон дэлхийн 63 орноос 61-д эрэмблэгдэж Ази, Номхон далайн бүс нутагт өрсөлдөх чадвараар Монгол Улс хамгийн сул байна. Засгийн газрын үргүй зардлаараа 53 дугаар байранд орсон зэргээс дүгнэж үзэхэд дэлхийн бусад улс оронтой харьцуулахад манай төсвийн зардал үр ашиг муутай, Засгийн газрын өндөр зардалтай буюу **өөрийн эдийн засгийн чадавхи, боломжоос хэтэрсэн зардалтай** байна.

Сүүлийн 2001-2022 онуудад ДНБ-ий нэрлэсэн дүнгээрээ өсөж, жилийн өсөлтийн хувь 19.0% -иар нэмэгдсэн боловч инфляцийн нөлөөг тооцсон бодит дүнгээр жилийн өсөлтийн хувь 6.1% байна. Өнгөрсөн хугацаанд төсвийн зардлын өсөлтийн хувь жилд дунджаар 19.9% өсөж байсан нь эдийн засгийн өсөлтийг дэмжихгүй байна.

Улсын төсвийн зардал нь иргэдийн аюулгүй амьдрах боломжийг хангах үндсэн зорилгоос гадна эдийн засгийг өсгөхөд чиглэсэн байдаг. Эдийн засгийн онол, эрдэмтдийн дэвшүүлсэн үзэл баримтлаар улсын төсвийн зардал нь эдийн засгийн өсөлтөд нөлөөлөх боломжтой гэж өгүүлсэн ба хөгжиж буй орнуудын хувьд төсвийн зардлаас хамаарч эдийн засгийн өсөлт нь тодорхойлогддог гэж үздэг. Түүнчлэн манай улсын төсвийн тэнцэл жил бүр алдагдалтай эдийн засгийн хямрал нүүрлэж байгаа нь төсвөөс зардал хуваарилахдаа салбаруудын эдийн засгийн өгөөжтэй нь уялдуулахгүй байна. Салбарт төсвийн зардлыг хуваарилахдаа тухайн салбарын бодлогын зорилттой уялдуулах, эргэх холбоог хангах нь эдийн засгийн харилцааг дэмжихэд эерэг нөлөө үзүүлэх бүрэн боломжтой юм.

Өнөөгийн нөхцөл байдал нь эдийн засгийн хөгжилд **буурах дарамт** үзүүлсээр байгаа бөгөөд үүний нэг шалтгаан нь төсвийн зарлагын өсөлтийн хурд буурахгүй, ДНБ-ий өсөлтийн хурд түүнээс давж нэмэгдээгүй байна. Энэ үндэслэлээр энэхүү судалгааны ажлыг хийсэн бөгөөд үүний шалтгааныг олж тогтоох зорилго дэвшүүлсэн.

Ингэхдээ эдийн засгийн өнөөгийн байдалд шинжилгээ хийн, төсвийн зардлаас **салбарт хуваарилсан хөрөнгө оруулалт үр дүнтэй байгаа эсэхийг** тодорхойлсноор эдийн

засагт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулж болно. Монгол улсын төсөв салбарын хөгжлийн бодлоготой уялдаагүй зарцуулагддаг байж болзошгүй гэсэн таамаглалыг дэвшүүлсэн юм. Тиймээс, улсын төсвийн зардлыг эдийн засгийн өсөлтөд хувь нэмэр оруулах боломжтой газруудад (салбаруудад) хуваарилах үндэслэл нь эмпирик байдлаар тодорхойлогдсон байх шаардлагатай байна.

Сүүлийн жилүүдэд хийсэн судалгааны ажлуудыг харьцуулан үзвэл корреляцийн шинжилгээ, регрессийн шинжилгээ, SYS-GMM загвар, OLS, SVAR загваруудыг ашигласан байна. Уг судалгаанд Монгол улсын эдийн засагт нөлөөлөх нөлөөллийг төсвийн зарцуулалт болон салбарын ДНБ-ийг харьцуулан шинжлэх байдлаар шугаман болон шугаман бус загварын регрессийн загвараар үнэлгээ хийхийг зорилоо.

Судалгааны ажлын бүтэцлэгдсэн байдал, бүлгүүдийн агуулгыг товчхон дурдвал:

1-р бүлгийн хүрээнд: Судалгааны ажлын онол арга зүй, улсын төсвийн салбарын шинжилгээний аргачлал, хувьсагчдын талаар эрдэмтэн судлаачдын байр суурь, хандлагыг харуулсан бөгөөд Кейнсийн онол, Harrod-Domar-ийн өсөлтийн загвар, Вагнерийн хуулийн үзэл баримтлалыг тусгасан.

2-р бүлгийн хүрээнд: Улсын төсөв болон эдийн засгийн өсөлтийн байдлыг 2001-2022 оны байдлаар судалсан. Манай улсын хөгжлийн урт хугацааны бодлогын баримт бичигт **“Эдийн засаг”-ДНБ 6.1 дахин нэмэгдэж нэг хүнд оногдох ДНБ 3.6 дахин өсөж, 15,000 ам.долларт хүрч, дэлхийн өндөр хөгжилтэй орнуудын босгыг давна**” (Алсын хараа 2050) хэмээн зорилгоо тодорхойлсон. Энэ зорилгын хүрээнд авч хэрэгжүүлэх нэн тулгамдсан асуудлуудын нэг нь төсвийн зардал ба салбарын өсөлт хоорондын өнөөгийн байдал болон ирээдүйн чиг хандлагыг эмпирик байдлаар тодорхойлох юм гэж үзсэн.

3-р бүлгийн хүрээнд: 1,2-р бүлгийн агуулга тус бүр хэрхэн уялдаж байгааг тодруулбал төсвийн хөрөнгө оруулалтууд үр дүнтэй байгаа эсэхийг нарийвчлан судлах зорилгоор Судалгааны дизайн, үе шат, аргачлалыг тодорхойлсон.

4-р бүлгийн хүрээнд: Судалгааны зорилгын хүрээнд Эмпирик шинжилгээг 6 чиглэлээр хийж шинжилгээний үр дүнг нэгтгэж дүгнэлт хийн, санал зөвлөмж боловсруулсан болно.

Судалгааны ерөнхий үр дүнд: Салбаруудын бодлогын зорилтуудтай төсвийн зарцуулалт хооронд уялдаагүй. Тухайлбал уул уурхай болон бусад салбараас олсон орлогоо баялаг бүтээх салбарт бус нийгмийн халамжийн салбарт ихээр оруулдаг. Энэ нь цаашдаа эдийн засгийн өсөлтийг дэмжихгүй, төсвийн зарцуулалтын гол зорилго болох ажилгүйдлийг бууруулах, ажил эрхлэлтийг дэмжих зорилгодоо чиглэдэггүй байна.

Судалгааг нэгтгэн дүгнэвэл манай улс эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдалд хүргэсэн хүндрэлтэй хүчин зүйлсээ илрүүлж, сайжруулах арга замыг эрэлхийлэх хэрэгцээ шаардлага бий болсныг харуулж байна.

## I БҮЛЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ХАМААРАЛ ОНОЛ, АРГА ЗҮЙН СУДАЛГАА

Энэхүү бүлэгт улсын төсөв түүний ангилал болон дотоодын нийт бүтээгдхүүний үндсэн ойлголтыг авч үзэхээс гадна зардал болон эдийн засгийн өсөлт хоорондын холбоо хамаарлыг тайлбарладаг онолуудыг авч үзнэ.

### 1.1 Сэдвийн судлагдсан байдал

Судалгааны ажлын хүрээнд улсын нэгдсэн төсвийн зардал, эдийн засгийн өсөлтийн холбоо хамаарлын талаар дараах судалгааны ажлууд хийгдсэн байна.

#### Дотоодод судлагдсан байдал

Дотоод судлагдсан байдалд Монгол улсын хэмжээнд төсвийн бодлого, төсвийн тогтвортой байдалтай холбоотой хийгдсэн судалгааны ажлууд багтах ба үүнд судалгааны байгууллагууд, эрдэмтэн судлаачдын хийсэн судалгааны ажлууд багтаж байна.

**Судлаач Б.Пүрэв-Очир** “Монгол улсын 2005 оны төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлд хийсэн мэргэжлийн шинжилгээ” Судалгаанд улсын төсвийн 2005 оны төлөвлөлт, гүйцэтгэлийн гэсэн нэртэй боловч шинжилгээний агуулга нь манай улсын төсөв, санхүүгийн өнгөрсөн гурван жилийг хамарсан, татвар, хөрөнгө оруулалтын зэрэг зарим гол чиглэлд 1990 ээд оноос хойшхи урт хугацааны төлөв байдлыг задлан шинжилсэн, загварчилсан, сайн төсөвлөлтийг хөгжүүлэх талаар бодлогын холбогдолтой зарим асуудлыг хөндөж зөвлөмж болгосноороо онцлог юм. Уг шинжилгээ нь төсвийн макро төвшнийг хамарсны сацуу боловсрол, соёл, шинжлэх ухаан, байгаль орчин, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын зэрэг засгийн газрын төсвийн томоохон багц бүхий гол зарим салбаруудыг хамарч дүгнэлт, зөвлөмж гаргасан байна (Пүрэв-Очир, 2006).

**Судлаач А.Батпүрэв** “Төсвийн бодлогын макро эдийн засгийн нөлөөллийн шинжилгээ” 2013 оны судалгаанд SVAR загварыг ашиглан төсвийн бодлогын макро эдийн засгийн нөлөөллийг авч үзсэн бөгөөд бүтээгдэхүүн үйлчилгээний зах зээл буюу ДНБ-ий бүрдэлт, мөнгөний зах зээл, мөн хөдөлмөрийн зах зээл дээр төсөв ба сонирхож буй хувьсагчдын хамаарлыг шинжилснээр төсвийн зарлага нь макро эдийн засагт ямар сүвгаар, хэрхэн нөлөөлж буйг тодорхойлсон. Загварт төсвийн зарлага, орлого, өрхийн хэрэглээ, хувийн хөрөнгө оруулалт, ДНБ-ий өсөлт, мөнгөний нийлүүлэлт инфляци, валютын ханш, ажилгүйдлийн хувь, дундаж цалин гэсэн хувьсагчдыг хамруулан авч үзсэн байна. (А.Батпүрэв, 2013).

**Судлаач Ч.Наранчимэг** “Төсөв ба хөдөө аж ахуйн тулгамдсан асуудлууд” судалгаанд Монгол улсын төсөв, хөдөө аж ахуйн тулгамдсан асуудлын уялдаа болон төсвийн орлого зарлагын төлөвлөлт хэрхэн нөлөөлөх, өнгөрсөн жилүүдийн гүйцэтгэлийн үр нөлөөг авч үзсэн байна. Хөдөө аж ахуйн салбар нь 1990 оны сүүлээр ДНБ-ий 30-иас дээш хувийг эзэлж, 2004 он хүртэл ДНБ-ий ихэнх хувийг эзэлж байсан ба

уул уурхайн салбар хөгжсөнөөр үзүүлэлт буурсан. Мөн дотоод эх үүсвэрээс олгох зээлийн хэмжээ өмнөх оноос эрс бага төлөгдсөн нь ХАА-нь бүтээгдэхүүний зах зээлийг тэлэх, ажлын байрыг нэмэгдүүлэлтэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй гэж дүгнэсэн байна (Ч.Наранчимэг, 2018).

**Судлаач Д.Гэрэлмаа** “Төсөв ба боловсрол, шинжлэх ухааны салбарын тулгамдсан асуудал” 2018 оны төсвийн төсөл болон боловсрол шинжлэх ухааны салбарт тулгамдаж буй асуудлуудыг авч үзсэн. Тухайлбал, 2018 оны байдлаар сургуулийн өмнөх боловсролд нийт боловсролд зарцуулж урсгал зардлын 28 хувь, ерөнхий боловсролд 56 хувь, 6 хувийг соёл урлагийн, үлдэх 10 хувийг бусад 6 хөтөлбөрт зарцуулсан байна. Манай улсын ДНБ-д эзлэх боловсролын салбарын зардлын хэмжээ 2010 оноос хойш 5.4-6.5 хувийн үзүүлэлттэй. Харин 2018 оны байдлаар 2.7 хувь байгаа нь олон улсын жишигтэй харьцуулахад 6 хувиар бага байна. Боловсролын санхүүжилтийн бодлого хэрэгжихдээ тэгш байдлыг хангахад биш, тэгш бус байдлыг аажмаар нэмэгдүүлж болзошгүй гэж дүгнэж болохоор байна гэж дүгнэсэн байна. (Төсөв ба боловсрол, шинжлэх ухааны салбарын тулгамдсан, 2018).

**Судлаач Л.Даваажаргал** Төсвийн бодлого эдийн засгийн өсөлтийг дэмждэг үү? Төсвийн бодлого эдийн засгийн өсөлтийн хамаарлын VAT(vector autoregression) болон SVAR загвар ашиглан судалсан. Тодруулбал засгийн газрын өрийн хэмжээний төсвийн бодлогын үр нөлөө , эдийн засагт хэрхэн нөлөөлж байгааг харуулсан. Мөн төсвийн тэнцэл болон эдийн засгийн өсөлтийг харьцуулахад сөрөг хамаардаг. Улсын нэгдсэн төсөвт урсгал зардлын хэмжээ тогтмол 70 хувиас дээш эзэлдэг зэрэг үзүүлэлтүүдийг харьцуулсан. Судалгааны үр дүнгээс манай улсын төсвийн алдагдал нэмэгдэх нь эдийн засгийн өсөлтийг сааруулах (төсвийн алдагдал 10 хувиар нэмэгдэхэд ДНБ-ий өсөлт 3 нэгжээр буурч байна), ханш сулруулах, бодлогын хүүг өсгөх нөлөөтэй болох нь харагдлаа. (Л.Даваажаргал, 2019).

## Гадаадад судлагдсан байдал

Гадаад судлагдсан байдлын хувьд улсын төсвийн зардал, дотоодын нийт бүтээгдэхүүн, эдийн засгийн өсөлтөд нөлөөтэй холбоотой хийгдсэн судалгааны ажлууд багтах ба үүнд олон улсын судалгааны байгууллагууд, судлаачдын судалгааны ажлууд багтаж байна.

**Jianhui Zhang** Судалгаа нь Хятадын ДНБ -ийн дараагийн таван жилийг таамаглал дэвшүүлэх мөн засгийн газрын зардлын оновчтой түвшинг илэрхийлэх аргыг тодорхойлсон. Судалгаанд 1998-2019 оны хугацааны цуваа шинжилгээгээр ДНБ болон төсвийн зарцуулалтын тоон мэдээллийг ашигласан. Үр дүнд засгийн газрын зардлын өсөлт нь ДНБ-ий өсөлтөд 81 хувийн хамааралтай гэж дүгнэсэн бөгөөд 2007 оноос хойш Хятад улсын голлох салбарт зарцуулсан дүнг ДНБ-р тооцож үзвэл боловсролын салбарт 15 хувь, газар тариалан ойжуулалтад 10 хувь, ажил эрхлэлтэд 12 хувь, Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн салбарт 12 хувийг тус бүр тогтмол зарцуулсан байна (Jianhui, 2022)



**Судлаач Yaying Liu** Судлаач Yaying Liu төсвийн зарцуулалт болон эдийн засгийн хөгжлийн хамаарлын эмперик судалгааг SYS-GMM үнэлгээний арга зүй ашиглан Хятад улсын жишээн дээр 2007-2017 оны панел өгөгдлийн судалгаа хийсэн байна. Эдийн засгийн хөгжлийн үзүүлэлтийг нэг хүнд ногдох ДНБ-ээр авсан бол хамааран хувьсагчаар муж тус бүрийн төсвийн зардлыг салбар бүрээр харьцуулан судалсан. Үр дүнд төсвийн зарцуулалт нэг нэгжээр өсөхөд байгаль хамгааллын эдийн засгийн хөгжил 0.45 нэгжээр, ажил эрхлэлт, нийгмийн хамгаалалын хөгжлийг 0.29 нэгжээр тус тус нэмэгдүүлдэг бол шинжлэх ухаан, соёл, боловсрол, эрүүл мэндийн салбарын өсөлт 0.21 нэгжээр нэмэгддэг байна (Liu, 2020).

**Chi Gong нарын** судалгаанд Хятадын ногоон эдийн засгийн өсөлт, ДНБ болон төсвийн зарцуулалтын бүтцийн хамаарлыг судалсан. Ингэхдээ 30 мужийн 14 жилийн нийт 408 ажиглалтын утга дээр панел шинжилгээ хийсэн. Үр дүнд төсвийн зарцуулалт, нэг хүнд ногдох тогтмол капиталын өсөлт нь ДНБ болон ногоон эдийн засагт өндөр ач холбогдолтойгоор эерэг нөлөөлдөг. Харин гадаадын шууд хөрөнгө оруулалт, мужийн байгалийн баялаг ногоон эдийн засагт сөрөг нөлөөтэй (Wan C. G., 2022)

**Yuchen Song нарын** судалгаанд хятадын мужуудын 2008-2018 оны хоорондын панел өгөгдөлд үндэслэн төсвийн төвлөрлийн саармагжилтын нөлөөлөл болон бүс нутгийн инновац, аж үйлдвэрийн бүтцийн гажуудлыг судалсан. Төсвийн зарцуулалтын төвлөрлөөр тухайн мужийн нэг хүнд ногдох төсвийн зарцуулалтыг нийт улсын хэмжээний нэг хүнд ногдох төсвийн зарцуулалтын харьцаагаар төлөөлүүлэн авч үзсэн. Бусад хамааран хувьсагчаар мөн гадаадын шууд хөрөнгө оруулалт, санхүүгийн, хөгжлийн, төсвийн орлого, нээлттэй байдлын түвшин зэрэг хувьсагч авсан. Үр дүнд төсвийн төвлөрөл саармагжих нь аж үйлдвэрийн боломжит чиглэлд хөгжихөд саад болдог. Гэсэн хэдий ч бүс нутгийн инновацийг нэмэгдүүлж, аж үйлдвэржилтийн гажуудлыг бууруулдаг байна (Yuchen Song, 2023).

**Junjun Chen** Судалгаанд тогтмол нөлөөллийн регрессийн (fixed effect model) үнэлгээний арга зүйгээр Хятадын 29 мужийн 2007-2017 оны хоорондын панел датанд шинжилгээ хийсэн. Тухайн мужид зарцуулж буй төсвийн зардал мужийн хөгжилтэй эерэг хамааралтай үр дүн гарсан. Мөн Хятадын зүүн бүс нутгуудад төсвийн хэмжээ, эдийн засгийн өсөлт хамаарал ач холбогдолгүй бол баруун болон төвийн бүсээр эерэг ач холбогдолтой үр дүнгүүд гарсан байна (Chen, 2018).

**Agung Suwandaru нарын** судалгаанд боловсролын салбарт оруулж буй төсвийн зардлын эдийн засгийн өсөлтөд үзүүлж буй нөлөөллийг Индонезийн жишээн дээр судалсан. Хүний нөөцийг нэмэгдүүлэх нь тухайн улсын эдийн засагт нөлөөлдөг гэж үзсэн тул Кобб-Дуглас үйлдвэрлэлийн функцийг онолыг ашиглан 1988-2018 оны тоон мэдээлэлд шинжилгээ хийсэн. 2000 оноос хойш Индонезийн эдийн засгийн дундаж өсөлт 4.6% байсан. Засгийн газраас боловсролыг ач холбогдлын түвшингээр дээгүүр авч үздэг бөгөөд нийт төсвийн зарцуулалтын 20%-оос багагүй хувийг тус салбарт зарцуулдаг байна. Эконометрик шинжилгээнээс боловсролд оруулсан засгийн газрын зардал нь урт хугацаандаа эерэг, богино хугацаандаа сөрөг хамааралтай үр дүн гарсан байна (Agung Suwandaru, 2021).

**Gabor Kustasi** Gabor Kustasi нарын судалгаанд засгийн газрын хөрөнгө оруулалтын салбарын ангилалаар ДНБ-ий өсөлтийн хоорондын хамаарлыг Европын холбооны 25 улсын жишээн дээр GMM, OLS, FEP арга зүй ашиглан судалсан. Үүнд: ДНБ-ий бүрдэлд хамаарал нь нийтийн үйлчилгээ (-), батлан хамгаалах (-), байгаль орчин (+), өрх гэрүүд (-), эрүүл мэнд (+), соёл (-), боловсрол (+), нийгмийн даатгал (-) сөрөг нөлөөлдөг тус тус үр дүнгүүд гарсан. Эерэг нөлөөлж буй боловсрол, эрүүл мэндийн салбарууд эдийн засагт хоцрогдолтой буюу урт хугацаандаа нөлөөлдөг байна. Мөн дээрх 25 улсын дүнгээр ДНБ-д эзлэх төсвийн зардлаас зарцуулах дундаж хувь нь тухайлбал нийтийн үйлчилгээ (6.82%), батлан хамгаалах (1.39%), байгаль орчин (0.71%), өрх (0.82%), эрүүл мэнд(5.85%), соёл(1.5%), боловсрол (5.19%), нийгмийн даатгал (15.92%) гэсэн хувиар зарцуулдаг байна (Gábor Kutasi, 2020).

**Alexander Klemm** нарын судалгаанд Европын 18 орны төсвийн бодлогын эдийн засгийн өсөлтөд үзүүлэх нөлөөллийг 1998-2011 оны жишээн дээр судалсан. Тус судалгаанд эдийн засгийн бодит өсөлтөд төсвийн зарлагын хамаарлаар хувьсагч тодорхойлсон. Төсвийн зарлагыг тодорхойлохдоо хөрөнгө оруулалт(+), хэрэглээ(+), татаас(-), төрийн албан хаагч (-) зэрэг хувьсагчдыг авсан бол төсвийн орлогыг тодорхойлогчдоор өрхийн татвар(+), аж ахуй нэгжийн татвар(+), нийгмийн даатгалын орлого(-), шууд бус татвар(+), зэрэг хувьсагчдыг авч үзсэн. Мөн тухай үеийн хууль тогтоомжуудтай харьцуулан шинжилсэн. Ерөнхийдөө үр дүн нь зарлагад суурилсан зохицуулалт нь орлогод суурилсан зохицуулалтаас бага хор хөнөөлтэй болохыг харуулж байна. Зарлагын бууралтын дүнд засгийн газрын хөрөнгө оруулалт, хэрэглээний бууралт нь эдийн засгийн өсөлтийг бууруулдаг. Харин орлого талаасаа шууд бус татварын нэмэгдэл онцгой сөрөг нөлөө үзүүлж байна (Klemm, 2014).

**Muritala Taiwo** судалгаандаа засгийн газрын зардлын ДНБ-д нөлөөлөх нөлөөллийг Нигерийн (1970-2008) жишээн дээр судалсан. Үр дүнд засгийн газрын зардал ДНБ-ий эерэг хамаарлыг тодорхойлсон буюу капиталын зардал 1% -ийн өсөлт ДНБ-ийг 0.46% нэмэгдүүлдэг бол урсгал зардал 0.57% өсгөдөг гэсэн үр дүн гарсан (Taiwo, 2011).

**Alberto** нарын судалгаанд OECD-ийн орнуудын 1970-2007 хоорондын төсвийн бодлогын байр суурь, татварын урамшуулын системийг харьцуулах байдлаар судалсан. Судалгаанд ДНБ-ий өсөлтийг нийт өр, өрийн өөрчлөлт, төсвийн алдагдал, төрийн ажиллагсдын цалингийн зардал, урсгал зардал, татаас, засгийн газрын хөрөнгө оруулалт, шууд бус татвар, аж ахуй нэгжийн орлогын татвар, нийгмийн даатгалын зардал зэрэг хүчин зүйлийг авч хамааруулан авч үзсэн. Төсвийн зохицуулалтын хувьд зарлагаа танах, татвар нэмэхгүй байх зэрэг нь татварын хувь хэмжээг өсгөхөөс илүүтэй улсын төсвийн татварын орлогыг нэмэгдүүлдэг. Энэ нь гадаад өр болон ДНБ-ий харьцааг бууруулдаг байна. Түүнчлэн татварын орлогоо нэмэгдүүлэхээс илүү зарцуулалтад анхаарах нь төсвийн алдагдлыг бууруулдаг зэрэг товч үр дүнгүүд гарсан (Alberto F. Alesina, 2009).

Судлаач **Roberto Perotti** OECD-ийн 5 орны (Америк, Дани, Их Британи, Канад, Австрали) жишээн төсвийн бодлогын үр нөлөөг улсын инфляци болон бодлогын хүү зэрэгтэй авторегрессын загвар ашиглан судалсан. Үр дүнд нь: 1) Сангийн бодлогын ДНБ-д үзүүлэх

нөлөө бага байх хандлагатай. 2) Татварын бууралт нь зардлыг нэмэгдүүлэхээс илүү хурдан, үр дүнтэй ажилладаг гэсэн нотолгоо байхгүй. 3) ДНБ болон түүний бүрэлдхүүн хэсэгт засгийн газрын зардлын шок, татварын бууралтын нөлөө цаг хугацааны явцад мэдэгдэхүйц суларсан. 1980 оноос хойших хугацаанд эдгээр нөлөөлөл, ялангуяа хувийн хөрөнгө оруулалтад голчлон сөрөг нөлөө үзүүлсэн. 4) Зөвхөн 1980 оноос хойшхи хугацаанд засгийн газрын зарцуулалт урт зээлийн хүүнд эерэг нөлөө үзүүлсэн. 5) Үнийн уян хатан байдал засгийн газрын зардалд ихэвчлэн бага хэмжээний нөлөө үзүүлдэг. 6) 1980 оноос хойшхи ДНБ-ний хэлбэлзлийн бууралтад шокын хэлбэлзлийн бууралт, бодлогын дамжуулах механизмын өөрчлөлт хоёулаа нөлөөлсөн зэрэг үр дүнгүүдийг онцолсон (Roberto, 2004).

**Masoom Fouladi Masoom Fouladi** судалгаанд засгийн газрын зардал нь ДНБ болон ажил эрхлэлтэд үзүүлэх нөлөөг CGE загвараар Иран улсын 1970 оноос хойш хэрэгжүүлсэн бодлогын үр нөлөөг судалсан. Тодруулбал төсвийн зарлагын үр ашиг нь зардлын төрлөөс хамаарна гэж үзсэн. Засгийн газрын зардлыг зарцуулалт болон хөрөнгө оруулалтын зардал гэсэн хоёр ангилалд хуваадаг нь хөдөө аж ахуй, байгалийн хий, газрын тос, барилга, аж үйлдвэр, ашигт малтмал, үйлчилгээ гэсэн таван салбарт хөрөнгө оруулалтын зардлыг авч үзсэн. Засгийн газрын хэрэглээний зардлыг нэмэгдүүлэх нь үйлдвэрлэл, ажил эрхлэлт, хөрөнгө оруулалтыг бууруулахад хүргэдэг. Засгийн газрын хөрөнгө оруулалтын зардал нь аль салбарт зарцуулахаас хамаарч эдийн засагт өөр өөр нөлөө үзүүлдэг байна (Fouladi, 2010).

Судлаач **Tasnia Symoom** Өмнөд Азийн дөрвөн улсын төсвийн бодлогын эдийн засгийн өсөлтөд хэрхэн нөлөөлж байгаа тухай 1980- 2016 оны Бангладеш, Энэтхэг, Пакистан, Шри Ланка гэсэн дөрвөн улсын жишээг судалсан. Ингэхдээ алдаа засварлагч загвар (ECM) болон авторегресс тархсан хоцрогдол (ARDL) загварыг авч үзсэн. Мөн тогтмол нөлөөлөл ба санамсаргүй үр нөлөөний тооцоологч ашиглан panel өгөгдөлд шинжилгээ хийсэн. Эмпирик үр дүнгээс харахад Засгийн газрын зардал болон татварын орлого нь эдгээр Өмнөд Азийн орнуудын ДНБ-ий бодит өсөлтөд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэхгүй гэж дүгнэсэн. Түүнчлэн бодит хөрөнгө оруулалт нь эдгээр орнуудын ДНБ-ий бодит өсөлттэй эерэг хамааралтай байдаг (Symoom, 2018).

**Ethan Ilzetzki нар** (2012) Засгийн газрын төсвийн зарлага, улс орны хөгжлийн түвшин, ханшийн дэглэм, худалдаанд нээлттэй байдал, улсын нийтийн өр зэрэгт макро түвшиний нөлөөллийг судалсан. Үүнд : Дэлхийн 44 орны засгийн газрын зардлын улирлын мэдээллийн багцад үндэслэн судалсан. Товч үр дүнд (i) засгийн газрын зардлын өсөлтийн үр нөлөө нь хөгжиж буй орнуудынхаас аж үйлдвэрийн салбарт илүү их байгааг тодорхойлсон ; (ii) урьдчилан тогтоосон ханшийн дагуу ажилладаг эдийн засагт төсвийн үржүүлэгч харьцангуй өндөр, харин уян хатан ханшаар ажилладаг эдийн засагт тэгтэй тэнцүү байна; (iii) нээлттэй эдийн засагтай орнуудын төсвийн үржүүлэгчид хаалттай орнуудынхаас бага байна. (iv) өндөр өртэй орнуудын төсвийн үржүүлэгч сөрөг байна гэсэн үр дүн тус тус гарсан (Ilzetzki, 2012).

**Гадаадад судлагдсан байдлыг авч үзвэл:** Хятад улсын судлагдсан жишээн дээр боловсрол, хөдөө аж ахуй, ойн аж ахуй, ус ашиглалт, нийгмийн хамгаалал хөдөлмөр эрхлэлт зэрэг салбаруудад засгийн газрын зардлыг харьцуулан харуулсан мөн эдгээр салбаруудын эдийн засгийн өсөлтийг төсвийн зарлагатай нь харьцуулсан байна. Гол дүгнэлт нь хөгжиж байгаа орнууд боловсролын салбарт оруулах төсвийн зарцуулалтын хувь жилд тогтмол 20%-оос багагүй байдаг. Энэ нь урт хугацаандаа эдийн засгийн өсөлтийг бий болгодог. (Agung Suwandaru, 2021) Европын холбооны 25 улсын хувьд төсвийн зарцуулалтыг салбараар шинжлэн ДНБ-д нөлөөлөх нөлөөллийг авч үзсэн. Үүнд: Нийтийн үйлчилгээ, Батлан хамгаалах, Байгаль орчин, Эрүүл мэнд, Соёл, Боловсрол, нийгмийн даатгал зэрэг салбарууд юм. (Gábor Kutasi, 2020) Мөн OECD-ийн гишүүн орнуудын жишээн дээр нийт өр, өрийн өөрчлөлт, төсвийн алдагдал, төрийн цалингийн зардал, урсгал зардал, татаас, засгийн газрын хөрөнгө оруулалт, шууд бус татвар, аж ахуй нэгжийн татвар, нийгмийн даатгалын зардал зэрэг зардлын ангилалын салбарт үзүүлэх эдийн засгийн нөлөөллийг судалсан байна. (Alberto Alesina, 2008).

Гадаад судлагдсан байдлаас дүгнэхэд төсвийн зарлагын өнөөгийн байдал, эдийн засагт үзүүлэх нөлөөллийг сүүлийн жилүүдэд эрчимтэй судалсан бөгөөд ДНБ-д эзлэх төсвийн зарлагын харьцаа үзүүлэлтийг тооцож, салбарын өсөлтийг ОУ-ын жишиг түвшинтэй харьцуулан дүгнэсэн ажлууд хийгджээ. Харин Монгол улсын төсөв, түүний гүйцэтгэлд хийсэн олон улсын байгууллага, эрдэмтэн судлаачдын судалгааны ажил, эрдэм шинжилгээний өгүүлэл олон байгаа боловч салбаруудын төсвийн зарлага ба дотоодын нийт бүтээгдэхүүний (ДНБ) хамаарлын талаар хийгдсэн судалгааны ажил байхгүй байна.

### **Судалгааны зорилго**

Монгол улсын төсвийн зарлага, эдийн засгийн өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийн, төсвийн зардлын эдийн засагт үзүүлэх нөлөөллийг тооцож, төсвийн хөрөнгө оруулалтууд үр дүнтэй байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх, сайжруулах санал зөвлөмж боловсруулахад судалгааны ажлын зорилго оршино.

### **Судалгааны зорилтууд**

1. Монгол улсын төсвийн өнөөгийн байдлыг судалж, төсвийн алдагдал, эдийн засгийн өсөлтийг тодорхойлох
2. Эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдлыг тоон өгөгдөлд суурилж дүгнэх
3. Сэдвийн судлагдсан байдлын судалгаа хийх
4. Төсвийн төлөвлөлтийн тогтвортой байдлын шалгуур үзүүлэлтийг төсвийн гүйцэтгэлээр дүгнэх
5. Монгол улсын төсвөөс санхүүждэг салбаруудад олон улсын байгууллагуудаас хийсэн шинжилгээний нэгтгэлийг судлах
6. Төсвийн макро эдийн засагт үзүүлэх нөлөөллийг тооцох аргуудыг холбогдох салбаруудад харьцуулан судлах, хувьсагч хүчин зүйлсээ тодорхойлох
7. Төсвийн зарлага ба ДНБ-ий тодорхой харилцан хамаарлыг тодорхойлох
8. “Алсын хараа-2050”-тогтвортой хөгжлийн зорилтын хүрээнд салбаруудын хүрэх түвшин, эдийн засагт үзүүлэх нөлөөг авч үзэх

9. ДНБ-д эзлэх төсвийн зарцуулалтын хувийг голлох салбаруудад бусад улс орнуудтай харьцуулан шинжлэх
10. Судалгааны үр дүнг нэгтгэн дүгнэх, санал зөвлөмж боловсруулах

## Судалгааны хамрах хүрээ

Засгийн газрын урсгал зардал болон салбарын ДНБ, улсын эдийн засгийн өсөлтөд үзүүлэх нөлөөллийг 1991-2022 оны өгөгдөлд тулгуурлан шинжилнэ.

### 1.2 Эдийн засгийн өсөлт, түүнд нөлөөлөх хүчин зүйлс

**Эдийн засгийн өсөлт:** Эдийн засгийн өсөлт гэж эдийн засаг дахь бараа, үйлчилгээг үйлдвэрлэх хүчин чадал нэмэгдэх (буурах) явдлыг хэлнэ (ҮСХ, 2022). Өсөлтийг үнэн зөв бодитой гаргахын тулд инфляцийн нөлөөг хасч тооцох буюу бодит ДНБ-ий өсөлтөөр илэрхийлнэ. Эдийн засгийн эерэг өндөр өсөлт нь дотоодын хөрөнгө оруулалтын хэмжээг ихэсгэх, үндэсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, амьжиргааны түвшинг дээшлүүлэх, татварын орлогыг нэмэгдүүлж засгийн газрын алдагдлыг бууруулах, улмаар шинээр ажлын байр бий болгох замаар ажилгүйдэл, ядуурлыг бууруулахад чухал үүрэг гүйцэтгэдэг байна (МонголБанк, 2018). Монгол улсын эдийн засгийн өсөлт 2011 онд оргил үе буюу 17.3%-д хүрч байсан бол 2016 онд эдийн засгийн хүндрэлээс шалтгаалан 1.6% хүртэл буурч, 2011-2017 онуудын хооронд дунджаар 8.2% орчим байсан байна. Түүнчлэн 2018-2020 онуудад жилд 6% орчим, 2021 онд 1.4%, 2022 оны 4.8%-ийн өсөлт үзүүлсэн байна.


Эдийн засгийн өсөлт бол бодит ДНБ-ий өсөлтөөр хэмжигдсэн үйлдвэрлэлийн боломжуудын тогтвортой тэлэлт юм. Олон жилийн турш хадгалагдсан эдийн засгийн хурдтай өсөлт нь ядуу үндэстэнг баян болгон өөрчилж чадна. Хонконг, Өмнөд Солонгос, Тайвань, Азийн зарим оронууд ийм өсөлтийн жишээ юм. Эдийн засгийн удаан өсөлт, эсвэл бүр өсөлтгүй байх нь улс үндэстэнг туйлын ядуу болгох аюултай (МонголБанк, 2018).

**ДНБ-ий тодорхойлолт:** Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) нь тухайн улс орны нутаг дэвсгэр дээр тодорхой хугацаанд үйлдвэрлэж бий болгосон эцсийн бараа, үйлчилгээний зах зээлийн үнэлгээний нийт мөнгөн дүн юм (ҮСХ, 2022).

Анх АНУ-ын эдийн засагч Симон Кузнец 1934 онд тухайн үеийн эдийн засгийн хямралын явц, үр дүнг тооцон гаргах зорилгоор үндэсний орлогыг бүртгэх аргыг танилцуулсан нь эдийн засгийн уг хэмжүүрийг бий болгосон байна. Тэрээр энэхүү нээлтээрээ 1971 онд “Нобелийн шагнал” хүртсэн юм (ҮСХ, 2022).

Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) нь тухайн улсын эдийн засгийн хэмжээ болон эрүүл байдлыг (энгийн, халалт, хүндрэл, хямрал) илэрхийлдэг гол үзүүлэлтүүдийн нэг бөгөөд бусад улсуудтай эдийн засгийн байдлаа харьцуулах цаг хугацааны хэмжигдэхүүн юм. ДНБ-ийг бараа үйлчилгээний нийт зардлаар болон бараа үйлчилгээг үйлдвэрлэж олсон нийт орлогоор хэмжиж болох бөгөөд дараах үндсэн гурван аргачлалаар тооцдог. Үүнд:

Зураг 1. ДНБ-ийг тооцох аргачлал



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

**Үйлдвэрлэлийн арга:** Нийт үйлдвэрлэлээс завсрын хэрэглээг хасч, нэмэгдэл өртгийн нийлбэр дүнгээр тооцно.

**Эцсийн ашиглалтын арга:** Эцсийн хэрэглээ, хөрөнгийн нийт хуримтлал, цэвэр экспортын (экспорт-импортын зөрүү) нийлбэрээр тооцно.

**Орлогын арга:** Хөдөлмөрийн хөлс, үндсэн хөрөнгийн хэрэглээ буюу элэгдэл, үйлдвэрлэл, импортын цэвэр татвар, үйл ажиллагааны цэвэр ашиг, холимог орлого зэргийн нийлбэрээр тооцно (Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, 2022).

Ихэнх улсууд ДНБ-ийг үйлдвэрлэлийн болон эцсийн ашиглалтын аргаар улирлаар, жилээр тооцдог бөгөөд татварын дарамт, далд эдийн засгийн үйл ажиллагаа зэрэг хүчин зүйлсээс шалтгаалан орлогын аргаар тооцоход хүндрэл үүсдэг байна.

Зураг 2. ДНБ эцсийн ашиглалтын аргаар илэрхийсэн орчил



Эх сурвалж: (Michael Parkinson, 2006)

Эдийн засгийн тооцоо судалгаанд эцсийн ашиглалтын аргыг ихэвчлэн ашигладаг бөгөөд энэ нь дараах байдлаар илэрхийлэгдэнэ.

Томъёо 1: ДНБ эцсийн ашиглалтын аргаар тооцох:

$$\mathbf{GDP=Y= C+G+I+(X-M)}$$

*Y-Дотоодын нийт бүтээгдэхүүн,*

*C-хувийн секторын эцсийн хэрэглээ,*

*G-Засгийн газрын нийт зардал,*

*I-хөрөнгө оруулалт буюу капитал тоног төхөөрөмж,*

*бараа материал болон орон сууцанд зарцуулсан нийт хөрөнгийн дүн.*

*(X-M)-цэвэр экспортын дүн,*

*X-экспортын хэмжээ,*

*M-импортын хэмжээ*

### **Нэрлэсэн ба бодит ДНБ**

**Нэрлэсэн ДНБ** нь өнөөгийн зах зээлийн үнээр илэрхийлэгдсэн бүх бараа, үйлчилгээний нийлбэрийг хэлнэ. Үүнд инфляци буюу дефляциас шалтгаалсан тухайн жилийн зах зээлийн үнийн өөрчлөлтүүд агуулагддаг (ҮСХ, 2022).

**Бодит ДНБ** нь үйлдвэрлэгдсэн бүх бараа, үйлчилгээний тогтмол үнээрх нийлбэр буюу тухайн жилд тус улсын нутаг дэвсгэр дээр үйлдвэрлэгдсэн бараа, үйлчилгээний өртгийг өмнөх жилүүдийн (суурь он) үнээр илэрхийлснийг хэлдэг (ҮСХ, 2022).

Бодит ДНБ нь тухайн оны үнээр илэрхийлэгддэг бөгөөд инфляци, импортын бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг оруулж тооцоогүй тул нэрлэсэн ДНБ-ээс хэмжээ нь доогуур, хэлбэлзэл нь харьцангуй бага байна. Эдийн засгийн тооцоо, судалгаанд бодит ДНБ-ийг дараах томъёогоор тооцдог.

Томъёо 2: БДНБ тооцох:

$$\mathbf{RGDP = NGDP / GDP deflator}$$

*RGDP Бодит ДНБ,*

*NGDP Нэрлэсэн ДНБ,*

*GDP deflator ДНБ-ий дефлятор*

**ДНБ-ий дефлятор** нь эдийн засгийн дундаж үнийн түвшний өөрчлөлтийг тусгадаг тул эдийн засагчид болон бодлого боловсруулагчид инфляцийн хэмжүүр болгон хэрэглэдэг байна (ҮСХ, 2022).

**Инфляци** Бүтээгдэхүүн үйлчилгээний үнийн ерөнхий түвшин өсөх үзэгдлийг инфляци гэнэ. Үнийн ерөнхий түвшин гэдэг нь тодорхой нэг бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийн

түвшин биш харин маш олон нэр төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээний дундаж үнийн түвшинг илэрхийлнэ (ҮСХ, 2022).

Эдийн засгийн өсөлтийн түвшинг бодит ДНБ-ий жилийн өөрчлөлтийн хувиар илэрхийлдэг.

Уг өсөлтийг хувиар тооцоолоход доорх томъёог ашигладаг.

Томъёо 3: Бодит ДНБ-ий өсөлтийн хувь

$$\text{Бодит ДНБ-ий өсөлтийн хувь} = \frac{\text{Тухайн оны бодит ДНБ} - \text{Өмнөх оны бодит ДНБ}}{\text{Өмнөх оны бодит ДНБ}} * 100$$

Бодит ДНБ-ий өсөлтийн түвшин нийт эдийн засаг хэр хурдтай өргөжиж байгааг илэрхийлдэг бөгөөд улс үндэстнүүдийн хоорондын эдийн засгийн тэнцвэрт гарч болох өөрчлөлтийг илэрхийлдэг чухал хэмжүүр юм. Гэвч энэ хэмжигдэхүүн нь амжиргааны түвшний өөрчлөлтийг харуулдаггүй.

Амьжиргааны түвшин нэг хүнд ноогдох бодит ДНБ-ээс хамаардаг. Бодит ДНБ-ийг хүн амын тоонд харьцуулж тооцдог (Паркин, 2006).

### 1.3 Улсын төсөв ба эдийн засгийн хамаарлыг тодорхойлох онол, арга зүй

Эдийн засгийн өсөлтийн онол нь хөдөлмөрийн бүтээмжийн өсөлт, хүн амын өсөлтийн нөлөөн дээр суурилан хөгжсөн. Кейнсийн онол, Harrod-Domar-ийн өсөлтийн загвар, Wagner-н хууль гэсэн 3 онолыг авч үзлээ.

#### ❖ Кейнсийн онол

1936 онд Жон Мэйнард Кейнс (1883-1946) “Хөдөлмөр эрхлэлт, хүү, мөнгөний өрөнхий тэнцвэр” бүтээлээ нийтэлсэн. Кейнсийн макро эдийн засгийн үзэл баримтлалын дагуу **төсвийн зарлага нь эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөөтэй** (Паркин, 2006).

#### ❖ Harrod-Domar Өсөлтийн загвар

Энэ загвар нь капиталын давхар үүргийг онцолдог. Тодруулбал капитал нь бүтээмжийн чадавхи болон үр дүнтэй эрэлтийг үүсгэдэг. Энэ загвар нь үндэсний орлого капитал болон хөдөлмөрөөс хамаарахыг зорьдог. Тиймээс капитал нь зөвхөн дотоод болон гаднаас авч болох өсөлтийн хүчин зүйл юм. Капиталын өсөлт нь капитал болон түүний ашиглалтын хэмжээнээс хамаардаг учир капиталын өсөлтийн хувийн уналттай байдаг нь бүтээгдэхүүний нийт хэмжээний уналттай холбоотой. **Тиймээс капиталд гарч буй төсвийн зардал эргээд эдийн засгийн өсөлтөд нөлөө үзүүлэх боломжтой** гэж үздэг (Паркин, 2006).

#### ❖ Wagner-н хууль

Адольф Вагнерын дурьдсанаар улсын төсвийн зарлага нь үндэсний орлогын өсөлтөөр тодорхойлогдох дотоод хүчин зүйл юм. Иймээс үндэсний орлого нь төсвийн зардлыг бий болгодог. Төсвийн зардлын өсөлт нь үйлдвэржилтийн өргөжилт болон эдийн засгийн



хөгжүүлэлт гэсэн 2 үндсэн функцтэй гэж үзжээ. **Үйлдвэржилтийн үйл явцад нэг хүнд ногдох бодит орлого нэмэгдэж үүгээр дамжуулан төсвийн зардлын хэмжээг ихэсгэх боломжтой гэж Вагнер тэмдэглэжээ (Паркин, 2006).**

### **1.3.1 Төсвийн ангилал ба тогтвортой байдлын шалгуур үзүүлэлт**

Монгол улсын төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6-р зүйл, төсвийн тухай шаардлагад заасны дагуу төсвийн орлогыг төлөвлөхдөө дараах шалгуур үзүүлэлтийг тавьдаг (УИХ, 2010).

1. Тэнцвэржүүлсэн орлого (Дэлхийн зах зээл дээрх зэсийн үнэ) (УИХ, 2010);

2. Тэнцвэржүүлсэн орлогоор тооцсон тэнцэл (Алдагдал/ашиг  $<GDP*2\%$ )

*Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байх (УИХ, 2010);*

3. Зарлагын хязгаарлалт ( $g < gGDP$ ) /эрдэс баялгийн бус/ эсвэл  $g < gmin/gdp-12year$

*Тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь нь тухайн жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн хувь, тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн дунджийн аль ихээс хэтрэхгүй байх (УИХ, 2010);*

4. Засгийн газрын нийт өр, зээлийн баталгаа  $<GDP*60\%$

*Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 60 хувиас хэтрэхгүй байх (УИХ, 2010);*

### **1.3.2 Улсын төсөв, эдийн засгийн өсөлтийн загварын харьцуулсан судалгаа**

Төсвийн зарцуулалт эдийн засгийн өсөлтийн хамаарлыг судалсан судалгаануудад засгийн газрын зардлын хэмжээ нь эдийн засгийн өсөлтөд нөлөө үзүүлдэг эсхийг тодорхойлсон байдаг. Улсын төсвийн эдийн засагт үзүүлэх нөлөөллийг тодорхойлох шинжилгээнүүдийг харьцуулан үзвэл панел болон хугацааны цувааны өгөгдөл ашиглан хийжээ.

Панел өгөгдөл ашиглан хийсэн судалгааны ажлууд нь регрессийн шинжилгээ ба VAR, GMM, CGE, OLS загваруудыг ашигласан ба тухайн улс орны хөгжлийн түвшнээс хамааран хувьсагчид нь ялгаатай байна (Хүснэгт 1-ийг үзнэ үү).

Хүснэгт 1. Панел өгөгдөл ашиглан төсвийн зарлага ба эдийн засгийн өсөлтийн шинжилгээг хийсэн судалгаануудын харьцуулалт

№	Хамрах хүрээ	Судлаачийн нэр	Ашигласан загвар	Хяналтын хувьсагчид
1	Хятадын 30 муж 2007-2017 он	(Chi Gong Yizi Wan, 2022)	SYS-GMM үнэлгээ	Төсвийн зардал, 1 хүнд ногдох ДНБ, Хөдөлмөрийн бүтээмж/Бодит ДНБ, Инфляци, Ажил эрхлэлтийн түвшин
2	Хятадын 30 муж 2007-2017 он	(Yaying Liu, 2021)	SYS-GMM үнэлгээ	Төсвийн зарлага, Эдийн засгийн өсөлт
3	Хятад 2008- 2018он	(Yuchen Song, Jingshu Ma, Shuai Guan and Yongfu Liu, 2022)	Регрессийн шинжилгээ	Төсвийн зардал, Төсвийн орлого, Гадаадын шууд хөрөнгө оруулалт,
4	Европын холбооны 25 улс 1996-2017	(Gabor Kustasi, 2020)	GMM, OLS	Нийгмийн халамж, Төсвийн зарлага, ДНБ-ий өсөлт
5	ОСЕД орнууд 1970-2007	(Alberto Alesina and Silvia Ardagna, 2008)	VAR, Регрессийн шинжилгээ	Төсвийн бодлого, урсгал зардал, татварын орлого, хүүний түвшин, Нийт өрийн түвшин, ДНБ-ий өсөлт, төсвийн алдагдал, Ажилгүйдлийн түвшин
6	Иран 1970-2010	(Masoom Fouladi Masoom Fouladi, 2010)	VAR, CGE	ЗГ-ын зардал, салбарын эдийн засгийн өсөлт, хөрөнгө оруулалт

Сүүлийн жилүүдэд хийсэн судалгааны ажлуудыг харьцуулан үзвэл корреляцийн шинжилгээ, регрессийн шинжилгээ, SYS-GMM загвар, OLS, SVAR загваруудыг ашигласан байна (Хүснэгт 2-ыг үзнэ үү).

Хүснэгт 2. Эдийн засгийн өсөлтийн шинжилгээг хугацааны цуваа ашиглан хийсэн судалгааны харьцуулалт

№	Хамрах хүрээ	Судлаачийн нэр	Ашигласан загвар	Хувьсагчид
1	Хятадын 1998-2019 он	(Jianhui Zhang, 2022)	Корреляци, регрессийн шинжилгээ	Төсвийн орлого /ДНБ, Төсвийн зарлагын үржүүлэгч, Засгийн газрын зардал, ДНБ
2	Хятадын 30 муж 2007-2017 он	(Junjun Chen, 2020)	Регрессийн шинжилгээ	Төсвийн зарлага, Эдийн засгийн өсөлт
3	Индонез 1988-2018 он	(Agung Suwandaru, Thamer Alghamdi, Nurwanto Nurwanto, 2021)	Кобб-Дугласс үйлдвэрлэлийн функцын онол	Төсвийн зардлаас боловсролын салбарт 20%-ийн зардал, Эдийн засгийн өсөлт, Хүний нөөц
4	Европын холбооны 18 улс 1998-2011	(Maria Grazia Attinasi and Alexander Klemm, 2014)	Динамик шугаман, шугаман бус хамаарлын шинжилгээ	Төсвийн зарлага, Эдийн засгийн өсөлт, Хөрөнгө оруулалт, хэрэглээ, татаас, төрийн албан хаагч, Эдийн засгийн салбарууд
5	Нигер 1970-2008	(Muritala Taiwo, 2011)	OLS	Засгийн газрын урсгал зардал, ДНБ
6	ОСЕД 5 орон 1980-2004	(Roberto Perotti, 2004)	Регрессийн шинжилгээ	Сангийн бодлогын нөлөө, Татварын бодлого, Засгийн газрын зардал
7	Өмнөд Азийн 4 улс 1980-2016 он	(Tasnia Symoom, 2018)	ECM, ARDL	ЗГ-ын зардал, ДНБ-ий бодит өсөлтийн хувь
8	Дэлхийн 44 орон 2012 он	(Ethan Ilzetki нар, 2012)	SVAR, VAR	Засгийн газрын үржүүлэгч=ДНБ/ЗГ-н төсвийн зардал

Засгийн газрын зардлын эдийн засагт үзүүлэх нөлөөг тодорхойлох дээрх судалгааны ажлуудын шинжилгээний хэсэгт авч үзсэн хувьсагчдыг харьцуулан авч үзвэл улсын төсөв, гадаад болон дотоод хөрөнгө оруулалт, хөдөлмөрийн бүтээмж, ажил эрхлэлтийн түвшин, эдийн засгийн салбарууд зэрэг байна. Дээрх судалгааны ажлуудад ОУВС-ийн судалгааг онолын суурь загвар болгон тооцоолол хийсэн ажлууд олон байгаа ба мэдээлэл ба загварын хувьд хувьд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн арга зүйг ашигласан байна.

Уг судалгаанд Монгол улсын эдийн засагт нөлөөлөх нөлөөллийг төсвийн зарцуулалт болон салбарын ДНБ-ийг харьцуулан шинжлэх байдлаар шугаман болон олон хүчин зүйлийн загварын регрессийн загвараар үнэлгээ хийхийг зорилоо. Үүнд: Улсын төсвөөс санхүүждэг салбаруудын голлох төлөөлөлөөр **Боловсрол, Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн үйлчилгээ, Байгаль орчин, Батлан хамгаалах, Уул уурхай, Хөдөө аж ахуйн салбар** зэрэг байна.

## Нэгдүгээр бүлгийн дүгнэлт

Энэ бүлэг нь судалгааны ажлын хүрээнд хэрэглэгдэх онол арга зүй, улсын төсвийн салбарын шинжилгээний аргачлал, хувьсагчдын талаар эрдэмтэн судлаачдын байр суурь, хандлагыг харуулсан бөгөөд эдгээр нь судалгааны арга зүй болон эмпирик шинжилгээний хэсгийн үндэслэл болж байна.

Дэлхийд улсын нэгдсэн төсвийн зардлын эдийн засгийн өсөлтөд үзүүлэх нөлөөг тайлбарлах онолууд байдаг. Кейнсийн макро эдийн засгийн үзэл баримтлалын дагуу үзвэл төсвийн зарлага нь эдийн засгийн өсөлтөд эерэг хувь нэмэр оруулах боломжтой бол чиглэлээ өөрчилвөл сөргөөр ч нөлөөлөх боломжтой тухай өгүүлсэн байна.

Harrod-Domar-ийн өсөлтийн загварт капиталд гарч буй төсвийн зардал өсөх тусам эдийн засаг өсөх боломжтой гэж тайлбарласан бол, Вагнер нь аж үйлдвэржиж буй улс орон буюу хөгжиж буй орнуудын төсвийн зардал нь нэг хүнд ногдох бодит орлоготой салшгүй холбоотой гэж үзжээ.

Засгийн газрын зардлын эдийн засагт үзүүлэх нөлөөг тодорхойлох гадаад судалгааны ажлуудын шинжилгээний хэсэгт авч үзсэн хувьсагчдыг харьцуулан авч үзвэл улсын төсөв, гадаад болон дотоод хөрөнгө оруулалт, хөдөлмөрийн бүтээмж, ажил эрхлэлтийн түвшин, эдийн засгийн салбарууд зэрэг байна. Судалгааны ажлуудад ОУВС-ийн судалгааг онолын суурь загвар болгон тооцоолол хийсэн бөгөөд мэдээлэл ба загварын хувьд хувьд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн арга зүйг ашигласан байна.

Монгол улсын эдийн засагт нөлөөлөх нөлөөллийг төсвийн зарцуулалт болон салбарын ДНБ-ийг харьцуулан шинжлэх байдлаар шугаман болон олон хүчин зүйлийн загварын регрессийн загвараар үнэлгээ хийхийг зорилоо. Салбаруудын голлох төлөөлөлөөр Боловсрол, Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн үйлчилгээ, Байгаль орчин, Батлан хамгаалах, Уул уурхай, Хөдөө аж ахуйн салбар зэрэг байна.

## II БҮЛЭГ. УЛСЫН ТӨСӨВ, ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Энэхүү бүлэгтээ Монгол улсын нэгдсэн төсвийн өнөөгийн байдал, төсвийн бодит гүйцэтгэл ямар байгаа талаар болон макро эдийн засгийн өнөөгийн байдлыг авч үзэх юм.

### 2.1 Улсын нэгдсэн төсвийн өнөөгийн байдал

Улсын төсвийг бүтцээр нь авч үзвэл, Төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлогыг 1. Урсгал орлого (Татварын ба татварын бус) 2.Хөрөнгийн орлого, 3.Тусламжийн орлого гэж ангилдаг. Улсын төсвийн урсгал орлого нь цэвэр дотоод эх үүсвэрээс бүрдэх бөгөөд тусламжийн орлого нь гадаад орон, олон улсын байгууллагын буцалтгүй тусламжийн орлогоос бүрддэг. Улсын төсвийн нийт зарлагыг 1. Урсгал заардал, 2. Хөрөнгийн зардал, 3. Эргэн төлөгдөх цэвэр зээл гэж ангилдаг байна.

Зураг 3. Монгол улсын төсвийн бүтэц

№	Улсын төсөв	Ангилал	Тайлбар
1	Тэнцвэржүүлсэн нийт орлого	· Урсгал орлого (Татварын орлого, Татварын бус орлого)	Цэвэр дотоод эх үүсвэрээс бүрдэнэ. Татварын орлогод орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэл, хураамж, өмчийн татвар, дотоодын бараа үйлчилгээний татвар, гадаад худалдааны татварын орлого болон бусад татвар орно. Татварын бус орлогод төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг, хүү, торгуулийн орлого, түрээсийн орлого болон татварын бус орлого орлогоуд
		· Хөрөнгийн орлого	
		· Тусламжийн орлого (Гадаад орон, ОУ байгууллагын буцалтгүй тусламж )	
2	Улсын төсвийн нийт зарлага	· Урсгал зардал	Бараа үйлчилгээний зардал, зээлийн үйлчилгээний төлбөр, татаас ба урсгал шилжүүлгээс урсгал зардал бүрдэнэ.
		· Хөрөнгийн зардал	
		· Эргэн төлөгдөх цэвэр зээл	

Эх сурвалж: : Үндэсний статистикийн хороо

Төсвийн ангиллыг төсвийн орлого, төсвийн зардлын ангиллаар авч үзье.

#### 2.1.1 Улсын нэгдсэн төсвийн орлого ба тусламжийн дүн


Төсвийн нийт орлогын хэмжээ 2022 оны жилийн эцсийн байдлаар өмнөх оны мөн үеэс 20.2 хувиар өсөж 17,2 их наяд төгрөгт хүрчээ. Үүнд татварын орлого өмнөх 2021 оноос 37.8 хувиар өсөж 15,568.0 тэрбум төгрөгт, татварын бус орлого 15.5 хувиар өсөж 1,630.2 тэрбум төгрөгт тус тус хүрсэн байна (Хүснэгт 3. болон Зураг 4.).

Хүснэгт 3. Улсын нэгдсэн төсвийн орлого ба тусламжийн дүн (тэрбум төгрөг)

Үзүүлэлт	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022
<b>Макро эдийн засгийн үзүүлэлт</b>								
ДНБ	23,150.4	23,942.9	28,010.7	32,582.6	37,839.2	37,453.3	43,555.5	52,867.4
<b>Төсвийн орлогын үзүүлэлт</b>								
Нийт орлого ба тусламжийн дүн	5,983.40	5,835.0	7,958.3	10,172.8	12,040.3	10,444.1	14,306.4	17,198.5
Өсөлтийн хувь		-2.5% ↑	36.4% ↑	27.8% ↑	18.4% →	-13.3% ↓	37.0% ↑	20.2% →
Нийт орлого ба тусламжийн ДНБ-д эзлэх хувь	25.8%	24.4% ↓	28.4% ↑	31.2% ↑	31.8% ↑	27.9% ↓	32.8% ↑	32.5% ↑
Татварын орлого	5,119.0	4,951.0	6,315.1	8,227.8	9,813.2	8,511.6	11,299.9	15,568.3
Өсөлтийн хувь		-3.3% ↑	27.6% ↑	30.3% ↑	19.3% →	-13.3% ↓	32.8% ↑	37.8% ↑
Татварын бус орлого	862.1	884.1	959.7	1,117.3	1,092.3	952.2	1,411.5	1,630.2
Өсөлтийн хувь		2.6% →	8.6% →	16.4% ↓	-2.2% ↓	-12.8% ↓	48.2% ↑	15.5% →

Эх сурвалж: : УСХ, Судалгааны багийн тооцоолол

Зураг 4. Улсын нэгдсэн төсвийн орлого, тусламжийн дүн



Эх сурвалж: УСХ, Судалгааны багийн тооцоолол

2.1.2 Улсын нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэлийн дүн


Төсвийн нийт зарлага 2022 оны жилийн эцсийн байдлаар өмнөх оны мөн үеэс 16.3 хувиар өсөж 18,2 их наяд төгрөг зарцуулагдсан байна. Улсын нэгдсэн төсвийн зардлын гүйцэтгэл 2010-2021 онуудад 96-120 хувьтай байсан бол 2022 онд 96.5 хувь байгаа нь өмнөх жилүүдийн гүйцэтгэл хувьтай ойролцоо байна (Хүснэгт 4. болон Зураг 5.).

#### Хүснэгт 4. Улсын нэгдсэн төсвийн зарлагын үзүүлэлт (тэрбум төгрөг)

Үзүүлэлт	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022
<b>Макро эдийн засгийн үзүүлэлт</b>								
ДНБ	23,150.4	23,942.9	28,010.7	32,582.6	37,839.2	37,453.3	43,555.5	52,867.4
<b>Төсвийн зарлагын үзүүлэлт</b>								
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн*	7,138.0	9,495.3	9,017.3	9,317.2	11,661.7	13,904.2	15,630.4	18,177.8
Өсөлтийн хувь		33.0% ↓	-5.0% ↓	3.3% ↑	25.2% ↑	19.2% →	12.4% ↑	16.3% ↑
Нийт зарлага ба цэвэр зээлийн ДНБ-д эзлэх хувь	31%	40%	32%	29%	31%	37%	36%	34%
Урсгал зарлага	5,718.37	6,613.8	7,043.2	7,350.3	8,228.6	10,828.9	12,804.0	14,212.2
Өсөлтийн хувь		15.7% ↓	6.5% ↓	4.4% ↓	11.9% ↑	31.6% →	18.2% ↓	11.0% ↓
Хөрөнгийн зардал	1,396.70	2,360.2	1,658.1	1,680.4	3,016.7	3,034.2	2,982.2	3,813.1
Өсөлтийн хувь		69.0% ↓	-29.7% ↓	1.3% ↑	79.5% ↓	0.6% ↓	-1.7% →	27.9% ↓
Эргэж төлөгдөх цэвэр зээл	22.90	521.31	316.02	286.45	416.40	41.10	(155.77)	152.50
Өсөлтийн хувь		2176.9% ↑	-39.4% ↑	-9.4% ↑	45.4% ↑	-90.1% ↓	-479.0% →	-197.9% ↓
Урсгал зарлагын нийт зарлагад эзлэх хувь	80%	70% →	78% ↑	79% ↓	71% →	78% ↑	82% ↑	82%

Эх сурвалж: : ҮСХ, Судалгааны багийн тооцоолол

#### Зураг 5. Улсын нэгдсэн төсвийн зардлын бүтэц



Эх сурвалж: : ҮСХ, Судалгааны багийн тооцоолол

Төсвийн нийт зарлагын хэмжээ 2022 оны жилийн эцсийн байдлаар өмнөх оны мөн үеэс 16.3 хувиар өсөж 18,178 тэрбум төгрөгт хүрчээ. Үүний 78.2 хувь буюу 14,212 тэрбум төгрөгийг урсгал зардалд, 20.9 хувь буюу 3,813 тэрбум төгрөгийг хөрөнгийн зардалд, 0.9 хувь буюу 153 тэрбум төгрөгийг эргэн төлөгдөх цэвэр зээл төлөхөд зарцуулсан байна.

## Хөрөнгийн зардал


Монгол улсын Засгийн газрын зардлын бүтцийг *Зураг 5-с* харвал 2000 оноос хойш төсвийн зардлын бүтцэд бараг өөрчлөлт гараагүй буюу урсгал зардал 80 гаруй хувийг (хөрөнгийн зардал 20 орчим хувь) эзэлж иржээ. Ийнхүү төсвийн зарлагад **урсгал зардлууд ихэнх хувийг эзэлж байгаа** нь эдийн засгийн бүтцийн өөрчлөлтөд чиглэсэн төсвийн хөрөнгө оруулалт хийгдэж, ажилгүйдлыг бууруулах, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх тал дээр анхаарахгүй байгааг илтгэж байна (*Зураг 5*). Графикаас харахад улсын төсвийн хөрөнгийн зардлын гүйцэтгэлийн хувь нь харьцангуй хэлбэлзэл багатай байна.

### 2.1.3 Төсвийн тэнцлийн өнөөгийн байдал

Төсвийн зарлагын 80 гаруй хувь эзэлж байгаа урсгал зардал эдийн засагт ямар үр нөлөөтэй вэ? гэсэн асуулт тулгарна. Иймд төсвийн орлого, зардал төсвийн тэнцлийн хамаарлыг харьцуулан авч үзлээ.

Төсвийн тэнцлийн ДНБ-д эзлэх хувийн үзүүлэлт 2016 онд (-15.3%), 2017 онд (-6.2%), 2020 онд (-12%), 2021 онд (-6.7%) тус тус байна.

*Зураг 6. Монгол улсын нэгдсэн төсвийн орлого, зардал ба тэнцэл /2000-2022/*



*Эх сурвалж: УСХ, Судалгааны багийн тооцоолол*

Монгол улсын ДНБ-д улсын төсвийн зарцуулалт өндөр хувь эзэлдгийг (Хүснэгт 4, *Зураг б*) харуулж байна. Гэсэн хэдий ч тус хувийг тодорхойлсон оновчтой түвшин гэж байдаггүй бөгөөд энэ хувь нь тухайн улсын онцлог нөхцөл байдлаас хамаардаг гэж үздэг.



## Хүснэгт 5. Засгийн газрын тэнцвэржүүлсэн тэнцэл, ДНБ-ий үзүүлэлт


Үзүүлэлт	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022
<b>Макро эдийн засгийн үзүүлэлт</b>								
ДНБ	23,150.4	23,942.9	28,010.7	32,582.6	37,839.2	37,453.3	43,555.5	52,867.4
ДНБ өсөлтийн хувь	↓ 2.4%	↓ 1.5%	⇒ 5.6%	⇒ 7.7%	⇒ 5.6%	↓ -4.6%	↓ 1.4%	↑ 21.4%
<b>Засгийн газрын тэнцвэржүүлсэн тэнцэл</b>								
Төсвийн тэнцэл (тэнцвэржүүлсэн орлогоор тооцсон)	(1,156.91)	(3,660.29)	(1,742.46)	27.86	(756.19)	(4,440.51)	(2,919.01)	(979.30)
Өсөлтийн хувь		↑ 216.4%	↑ -52.4%	↑ -101.6%	↓ -2814.3%	↑ 487.2%	↑ -34.3%	↑ -66.5%
Төсвийн тэнцэлийн ДНБ-д эзлэх хувь		↓ -15.3%	⇒ -6.2%	↑ 0.1%	↑ -2.0%	↓ -11.9%	⇒ -6.7%	↑ -1.9%

Эх сурвалж: : УСХ, Судалгааны багийн тооцоолол

Иймд төсвийн тэнцэл болон эдийн засгийн өсөлтийн харьцуулалтыг Зураг 7-д авч үзсэн. Тус үзүүлэлтэд төсвийн зардал нэмэгдэхийн хэрээр улсын тэнцэл алдагдал үүсч, үүнийгээ дагаад мөн эдийн засгийн өсөлт саардгийг харуулж байна.

Зураг 7-д харуулснаар 2009 оноос хойш төлбөрийн тэнцлийн алдагдал гаарсан бөгөөд үүнтэй зэрэгцэн ДНБ-ний өсөлт мөн саарсан. 2017-2019 онуудад төсвийн алдагдал буурсан үзүүлэлт нь ОУВС-ийн өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрт хамрагдсан цаг хугацаа юм.

Зураг 7. Эдийн засгийн өсөлт болон төсвийн тэнцлийн хамаарал /2000-2021/



Эх сурвалж: : УСХ, Судалгааны багийн тооцоолол

Төсвийн төлбөрийн тэнцлийн алдагдлын дийлэнх хувийг зээлээр санхүүжүүлдэг бөгөөд 2015-2022 оны нийт засгийн газрын өрийн тоон мэдээллийг товчоор харууллаа. (Хүснэгт 6)

## Хүснэгт 6. Засгийн газрын өрийн үзүүлэлт

Үзүүлэлт	2016	2017	2018	2019	2020	2021	2022
<b>Макро эдийн засгийн үзүүлэлт</b>							
ДНБ	23,942.9	28,010.7	32,582.6	37,839.2	37,453.3	43,555.5	52,867.4
<b>Засгийн газрын өрийн үзүүлэлт</b>							
Засгийн газрын нийт өр	22,280.1	22,751.6	22,367.0	24,199.7	27,898.6	26,918.2	33,149.1
Өсөлтийн хувь	54.0%	2.1%	-1.7%	8.2%	15.3%	-3.5%	23.1%
Засгийн газрын дотоод өр	5,796.0	3,461.9	1,564.7	1,399.6	1,136.6	657.3	749.1
Өсөлтийн хувь	63.7%	-40.3%	-54.8%	-10.6%	-18.8%	-42.2%	14.0%
Засгийн газрын гадаад өр	12,363.8	16,857.8	18,865.6	20,728.1	24,851.4	24,693.3	32,400.0
Засгийн газрын нийт өрийн үйлчилгээний төлбөр	2,229.7	5,337.9	3,761.3	1,464.4	3,509.0	5,037.4	4,209.2
Өсөлтийн хувь		139.4%	-29.5%	-61.1%	139.6%	43.6%	-16.4%
Төсвийн орлогод эзлэх хувь	38.2%	67.1%	37.0%	12.2%	32.7%	39.6%	24.5%
Төсвийн зарлагад эзлэх хувь	23.5%	59.2%	40.4%	12.6%	24.1%	24.1%	23.2%
ЗГ-ийн нийт өр төлбөрийн ДНБ-д эзлэх хувь	9.3%	19.6%	11.7%	4.0%	9.1%	11.7%	8.0%

Эх сурвалж: : УСХ, Судалгааны багийн тооцоолол


Орлогын түвшинээр адил улс орнуудтай харьцуулахад Монгол улсын төсвийн зарцуулалт өндөр байгаа тул төсвийн зардлыг бүтцээр нь нарийвчлан авч үзэх шаардлагатай гэж харагдаж байна. Иймд улсын нэгдсэн төсвийн зардлыг (Зураг 5) бүтцийн хувьд авч үзэхэд:

2000 оноос хойш урсгал зардал ойролцоогоор 75%-аас дээш хувь, хөрөнгийн зардал тогтмол 19% -иас дээш эргэж төлөгдөх цэвэр зээл тогтмол 6%- ийн хооронд байна. Энэ нь абсолют дүнгээрээ буюу 2021 оны байдлаар урсгал зардал 12.8 их наяд төг, хөрөнгийн зардал 3.0 их наяд, эргэн төлөгдөх цэвэр зээл 0.2 тэрбум төг тус тус байна.

### 2.2 МУ-ын эдийн засгийн өсөлт болон салбарын зарцуулалтын өнөөгийн байдал

Улсын төсвийн зардалд 80 орчим хувийг эзэлдэг урсгал зардал эдийн засагт ямар үр нөлөөтэй вэ? гэсэн асуулт тулгарна. Иймд ДНБ болон төсвийн зардлын хамаарлыг харьцуулан авч үзлээ.

Зураг 8. ДНБ-д эзлэх Засгийн газрын зардлын хувь хэмжээ



Эх сурвалж: Дэлхийн банк, Судалгааны багийн тооцоолол

Энд: *Зураг 8-д* Улс орнуудын ДНБ-д эзлэх засгийн газрын зардлын хувийг сүүлийн 3 жилээр гаргасан байна. Дэлхийн улс орнуудыг орлогын түвшингээр нь бага, бага дунд, дундаж, дундаас дээд, өндөр гэж ангилдаг бөгөөд Монгол улсын хувьд бага дунд орлоготой ангилалд хамаардаг. Гэвч ДНБ-д эзлэх Засгийн газрын зардлын хувь нь өндөр орлоготой орны түвшинд буюу төсвийн зардал өндөртэй байна.

**Засгийн газрын зардлын хэмжээ нь тухайн улсын орлогын түвшнээс ихээхэн хамаардаг бөгөөд манай улсын Засгийн газрын зардлын хэмжээ дундаж орлоготой улсуудынхтай ойролцоо байдаг байна.**

**Дэлхийн банкны тоон мэдээллийг ашиглан улс орнуудын орлогын түвшнээр нь засгийн газрын зардлыг харьцуулахад 2020 оны байдлаар Монгол улсын ДНБ-д эзлэх Засгийн газрын зарцуулалтын хувь нь адил ангиллын орлоготой орнуудаас 7.5 хувиар өндөр, дундаас дээгүүр орлоготой орнуудаас дунджаар 2.3 хувиар илүү байна. Харин өндөр орлоготой орнуудын дунджаас 6.1 хувиар бага байна.**

Төсвийн нийт зарлага буюу засгийн газрын зардлын хэмжээ нь өр зээлээр эсвэл тусламжаар санхүүжүүлээгүй тохиолдолд тухайн улсын ДНБ буюу орлогоос шууд хамааралтай юм. 2012-2021 жилийн үзүүлэлтээс харахад манай улсын нэгдсэн төсвийн тэнцлийн алдагдал нь ДНБ-ий өсөлтийг дагадаг буюу эерэг хамааралтай байна.

Төсвийн тэнцлийн алдагдалд шууд нөлөөлөгч төсвийн зарлагыг ангилалаар авч үзвэл:

Монгол улсын хувьд улсын төсвийн 3 ангилал байдаг. Үүнд:

- ❖ Эдийн засгийн ангилал
- ❖ Ерөнхийлөн захирагчийн ангилал
- ❖ Улсын зарлагын салбарын ангилал

Эдийн засгийн ангилалын хүрээнд Монгол улс нь урсгал зардал, хөрөнгийн зардал, эргэн төлөгдөх цэвэр зээл гэж ангилдаг.

Ерөнхийлөн захирагчийн ангилалаар 2012 онд нийт 42 төсвийн ерөнхийлөн захирагчид төсөв хуваарилагдан гүйцэтгэл гардаг байсан бол 2021 онд 32 салбарын төсвийн ерөнхийлөн захирагчид төсөв хувиарлагдсан байна.

Улсын зарлагын салбарын ангилал дараах байдалтай байдаг байна.

- Батлан хамгаалах
- Байгаль орчин аялал жуулчлал
- Зам тээвэр
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр
- Барилга, хот байгуулалт
- Боловсрол, соёл, шинжлэх ухаан
- Уул уурхай
- Эрчим хүч
- Хөдөлмөр, нийгэм хамгаалал

2021 оны жилийн эцсийн байдлаар Монгол улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 65%-ийг голлох салбар 35%-ийг бусад салбарууд бүрдүүлж байна.

Ийнхүү улсын нийт ДНБ бүрэлдхүүнд салбарууд 2010 оноос хойш 65%-ийг бүрдүүлж байгаа нь салбарууд цаашид эдийн засагт үзүүлэх өсөлтийг нэмэгдүүлж эсвэл бууруулж болзошгүй байна. Тиймээс дотоодын нийт бүтээгдэхүүний өнөөгийн байдлыг салбарын ангилалаар судлав.

Салбаруудаар ДНБ-ийг бүрдүүлж байгаа хувь хэмжээ болон төсвийн зарлагын хувь хэмжээний зэрэгцүүлсэн дүнг харуулав. (Хүснэгт 7)


Хүснэгт 7. Улсын төсвийн зарлага ба ДНБ /салбараар, тэрбум төгрөг/

Тайлант он	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	Нийт дүн	Төсвийн зардал	ДНБ-д эзлэх %
ДНБ /нийт/	13,173.76	16,688.42	19,174.24	23,150.39	23,942.87	28,010.71	32,582.63	37,839.23	37,453.28	43,018.60	275,034.12		
Төсвийн урсгал зардал /нийт /	4,339.15	4,561.70	5,149.03	4,553.69	6,643.76	6,846.68	6,919.96	8,901.63	10,712.28	12,297.54	70,925.41	д эзлэх %	
Салбарын урсгал зардал	3,089.12	2,970.55	3,411.05	2,734.63	4,168.62	4,264.75	4,418.97	5,156.76	5,994.97	7,673.73	43,883.15	61.9%	16%
Байгаль орчин, аялал жуулчлалын салбар	82.54	66.54	59.62	54.30	49.08	65.69	82.24	90.91	132.50	148.45	831.87	1.2%	0.3%
Барилга, хот байгуулалтын салбар	84.34	89.80	178.04	36.04	65.84	79.93	99.45	155.48	161.37	202.25	1,152.56	1.6%	0.4%
Батлан хамгаалахын салбар	154.25	157.67	191.09	200.45	206.75	213.48	217.96	250.32	268.94	276.94	2,137.85	3.0%	0.8%
Боловсролын салбар	891.86	936.50	1,190.09	1,000.71	1,222.24	1,213.71	1,422.82	1,737.76	1,552.98	1,652.01	12,820.70	18.1%	4.7%
Зам тээврийн салбар	446.55	509.27	341.89	224.42	981.73	632.33	376.30	235.57	253.96	268.20	4,270.22	6.0%	1.6%
Уул уурхайн салбар	15.39	20.06	20.89	15.70	16.42	28.34	25.01	35.50	34.64	36.25	248.20	0.3%	0.1%
Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн	146.50	147.89	150.93	95.53	136.49	148.44	130.23	161.89	328.41	181.39	1,627.70	2.3%	0.6%
Хүн амын хөгжил, нийгмийн хамгаалалын салбар	666.87	490.08	534.67	493.37	730.74	1,095.55	1,206.82	1,561.20	2,229.81	3,780.96	12,790.06	18.0%	4.7%
Эрүүл мэндийн салбар	425.02	415.82	579.74	581.85	657.48	674.39	721.88	823.03	986.91	1,061.30	6,927.42	9.8%	2.5%
Эрчим хүчний салбар	175.81	136.91	164.10	32.26	101.86	112.88	136.25	105.08	45.46	65.98	1,076.58	1.5%	0.4%

Эх сурвалж: УСХ, Судалгааны багийн тооцоолол

2012-2021 оны зарцуулалтыг салбаруудаар судалж үзэхэд Боловсролын салбарт 18 хувийг нийт 12,821,0 тэрбум төгрөг, Хөдөлмөр нийгмийн хамгааллын салбарт 18 хувийг 12,790.1 тэрбум төгрөг, Зам тээврийн салбарт 6 хувийг 4,270.2 тэрбум төгрөг, эрүүл мэндийн салбарт 9.8 хувийг 6,927.2 тэрбум төгрөг тус тус зарцуулсан байна. (Хүснэгт 7) Сүүлийн 10 жилийн хугацаанд төсвийн нийт урсгал зардлаас салбаруудад хувиарласан зардал 70.93 их наяд төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Үүнд: Төсвийн зарлагаас салбаруудад зарцуулсан урсгал зардал 43.74 их наяд төгрөг буюу нийт дүнд 61.9 хувийг эзэлж байгаа бол эдгээр 10 салбарын ДНБ-д эзлэх төсвийн зарлагын хэмжээ нь 16 хувь байна. Өнгөрсөн 10 жилд Эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, боловсролын салбаруудад төсвийн зарцуулалт хамгийн өндөр дүнтэй буюу эрүүл мэнд, нийгмийн хамгааллын салбарт 19.72 их наяд төгрөг, боловсролын салбарт 12.82 их наяд төгрөг зарцуулсан бол, хамгийн бага зардлыг аялал жуулчлалын салбарт 0.83 их наяд төгрөг, уул уурхайн салбарт 0.25 их наяд төгрөг тус тус зарцуулжээ. (Зураг 9)


Зураг 9. Сүүлийн 10 жилийн ДНБ болон Төсвийн зарлагын дүн/салбараар, их наяд төг/



Эх сурвалж: ҮСХ, Судалгааны багийн тооцоолол


Үүнд: ДНБ-ий бүрэлдхүүнд эрүүл мэнд нийгмийн хамгаалах (2%), боловсрол (4%), уул уурхай (21%) хүнс хөдөө аж ахуй (12%) барилга (4%), зам тээвэр (5%) бөөний болон жижиглэн худалдааны үйлчилгээ (11%), байгаль орчин, аялал жуулчлал (1%), төрийн удирдлага ба батлан хамгаалах (5%) эдгээр голлох салбарууд 65%-ийг эзэлж, бусад салбарууд 35% -ийг эзэлж байна. (Зураг 10)

Зураг 10. ДНБ голлох салбаруудын эзлэх дундаж хувь (2012-2021)



Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, 2022

Зураг 11. Монгол улсын төсвийн зардлын салбаруудад хуваарилалт (2012-2022)



Эх сурвалж: ҮСХ, Судалгааны багийн тооцоолол

Зураг 11-д төсвийн нийт зардлаас салбарт зарцуулсан зарлагын дүнг өсөлтийн хувиар илэрхийлбэл хуваарласан мөнгөн дүн нь 2012-2021 онд боловсролын салбарт 23.1%-13.4% болж буурсан, нийгмийн хамгаалал халамжийн салбарт 12.8%-30.7% болж өссөн байна.

### 2.3 МУ-н төсвөөс санхүүждэг салбаруудад олон улсын байгууллагуудаас хийсэн шинжилгээний нэгтгэл


Тогтвортой хөгжлийн үндсэн зорилго (ТХЗ) бол хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх, иргэдийн амьжиргааг дээшлүүлэхэд оршино. Энэ зорилгод хүрэх хамгийн чухал арга зам нь уг ТХЗ-ыг Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050” болон салбарын бодлоготой нягт уялдуулах явдал юм (Тогтвортойхөгжил2030, 2021).

Энэ хэсэгт НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх төсөл болон Европын холбоо (ЕХ)-оос гаргасан тайлангуудад 2021 онд Боловсрол, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр, Байгаль орчин, аялал жуулчлал, Хөдөлмөрийн салбарт тус тус төсвийн зарлагын шинжилгээ хийн дүгнэлт, зөвлөмжийг гаргасан байна.

Олон улсын байгууллагуудын тайлангуудад нь төсөл хөтөлбөрүүдийн үр дүн ба төсөв уялдаагүй зориулалт зарцуулалт хангалтгүй гэсэн дүгнэлтүүдийг нэгтгэн гаргаж нотолгоог хийсэн байна. Тухайлбал:

Төсвийн ерөнхийлөн захирагчид өгсөн дүгнэлтийг (Зураг 12) нэгдсэн байдлаар харуулав.

Зураг 12.Төсвийн ерөнхийлөн захирагчид өгсөн дүгнэлт



Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

### 2.3.1 Хөдөлмөрийн салбарын төсвийн шинжилгээ

Хөдөлмөрийн салбарын зарлага нь төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хяналт, тайлагналын шатанд ТХЗ-2030, Алсын Хараа-2050 болон бусад бодлогын баримт бичгүүдэд туссан зорилт, шалгуур үзүүлэлт, үр дүнтэйгээ уялдахгүй байна. Энэ талаар аливаа гүйцэтгэлийн аудит, хяналт, шинжилгээ, үнэлгээ төдийлөн хийгдээгүй байна. Тухайлбал, УАГ-аас Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын сайдын багцад 2017 онд хийсэн аудитын тайланд хөтөлбөрийн хэрэгжилт, хүрсэн үр дүнд товч танилцуулгыг хийсэн боловч “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрсэн үр дүн, үндсэн үзүүлэлтийн талаар ямар нэг дүгнэлт, тайлбар хийгээгүй байна. УИХ төсвийн хэлэлцүүлгийн шатанд

төсвийн зарлагыг хөтөлбөр, түүний үр дүнтэй уялдуулан авч үзэж, хэлэлцдэг эсэх нь тодорхойгүй байна. Хөдөлмөр эрхлэлтийн салбараас дараах хувьсагчдыг сонгон авч хоорондын хамаарлыг гаргасан (Г.Цэвээндорж, 2021).

Хөдөлмөр эрхлэлтийн салбарын төсвийн зарлага нь төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах зориулалтаар олгож буй санхүүжилтийг “**орц**”, жил бүрийн Төсвийн тухай хуулийн Хавсралт 1-т заасан хөдөлмөр эрхлэлтийн салбарын үр дүнгийн үзүүлэлтийг “**гарц**” гэж тооцон тус салбарын зарлагын үр дүнгийн шинжилгээгээр тодорхойлсон.

Хүснэгт 8. Хөдөлмөрийн салбарын орц, гарцын үр дүн

№	Хувьсагч	Хамаарал	Тайлбар
1	Ажилгүйдлийн түвшин, нийт зардал	(-0.56)	Урвуу хамааралтай
2	Хөдөлмөр эрхлэлтийн түвшин, нийт зардал	(-0.06)	Бага хэмжээгээр урвуу хамааралтай
3	Шинээр бий болсон ажлын байрны тоо, нийт зардал	0.46	Эерэг хамааралтай

Эх сурвалж: СЯ, ХХҮЕГ

Хөдөлмөр эрхлэлтийн салбарын нийт зарлага болон ажилгүйдлийн түвшин хоорондын хамаарлын коэффициент нь (-0.56) буюу урвуу хамааралтай, өөрөөр хэлбэл хөдөлмөрийн салбарт олгож буй төсвийн санхүүжилт нэмэгдэхэд ажилгүйдлийн түвшин буурсан байна. Хөдөлмөрийн салбарын зарлага болон хөдөлмөр эрхлэлтийн түвшин хоорондын хамаарлын коэффициент нь (-0.06) буюу бага хэмжээгээр урвуу хамааралтай байна. “Шинээр бий болсон ажлын байр” төсөв хоорондын хамаарлын коэффициент нь 0.46 буюу эерэг хамааралтай байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн нийт төсвийн санхүүжилтийн өсөлтийн хурднаас шинээр бий болсон ажлын байрны өсөлтийн хурд бага байна. Эндээс хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд зориулан зарцуулсан хөрөнгийн **үр ашиг хангалтгүй** гэж дүгнэж болохоор байна (Г.Цэвээндорж, 2021).

### 2.3.2 Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын төсвийн шинжилгээ

Байгаль орчин, аялал жуулчлалын салбарт хийсэн шинжилгээний хүрээнд төсвийн сүүлийн 5 жилийн статистик мэдээлэлд үндэслэн төсвийг орлого, урсгал зардал, төсвийн хөрөнгө оруулалт тус бүрээр харьцуулах замаар зардлын хандлагыг тодорхойлох арга аргачлалыг ашигласан байна. Хандлагыг тодорхойлохдоо байгаль орчны чиглэлээр зарцуулж буй төсвийн хэмжээг ДНБ-д харьцуулан харснаар тухайн улсын байгаль орчныг хамгаалах санаачилга, оролцоог харж болно. Мөн гадаадын тусламжаар энэ салбарт орж ирж буй хөрөнгийн бүртгэлжилтийг сайжруулах, нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн мэдээнд тусгах шаардлагатай байна (Тогтвортойхөгжил2030, 2021).

Байгаль орчин, аялал жуулчлалын салбарт гадаадын тусламжаар орж ирж буй хөрөнгийн бүртгэлжилтийг сайжруулах, нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн мэдээнд тусгах



шаардлагатай. Эдийн засгийн өсөлт, инфляц, төгрөг ханшийн өөрчлөлт зэргийг харгалзан тусгай хамгаалалттай газар нутагт үзүүлэх ажил үйчилгээний төлбөрийг нэмэгдүүлэх, төр-хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрийг байгаль орчин, аялал жуулчлалын салбарт зохистой хэмжээнд хуулийн хүрээнд нэвтрүүлэх шаардлагатай байна. БОАЖЯ-ны зарим чиг үүргийг хувийн хэвшилд шилжүүлэх, төсвийн хувьд бие даасан аж ахуйн тооцоот байгууллагуудыг байгуулж, төсөвт ирэх дарамтыг бууруулах боломжийг эрэлхийлэх гэж дүгнэжээ (Тогтвортойхөгжил2030, 2021).

БОАЖЯ-ны веб хуудсанд мэдээлснээр одоогоор манай улсад хэрэгжиж буй олон улсын байгууллагууд болон Олон улсын гэрээ, конвенцын дагуу хамтран ажилладаг байгууллагуудаас хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн төслүүд өргөн хүрээтэй байна.

Хүснэгт 9. БОАЖЯ-ны салбарт хэрэгжиж буй Гадаадын зээл, тусламжийн төслүүд (2022)

Д/д	Төслийн нэр	Санхүүжүүлэгч байгууллага	Хэрэгжих хугацаа	Нийт санхүүжилт
<b>Ногоон хөгжил, ногоон эдийн засаг</b>				
1	“Хог хаягдал ба Уур амьсгалын өөрчлөлт” бүсийн төсөл	Германы Засгийн газар, НҮБ-ын БОХ	2017. 07 2022.07	0.34 сая ам.дол
2	“Биологийн олон янз байдлын санхүүжилтийн санаачлага” BIOFIN	ХБНГ У-ын Засгийн газар, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр	2020-2022	0.13 сая ам.дол
<b>Байгалийн нөөцийн тогтвортой менежмент</b>				
3	“Химийн хорт болон аюултай бодисын менежментийг сайжруулах нь” төсөл	Азийн хөгжлийн банк	2020-2022	0.75 сая ам.дол
4	Алтын бичил уурхайд мөнгөн усны хэрэглээг зогсооход оруулах хувь нэмэр Бүсийн төсөл (Филиппин, Монгол)	Даян дэлхийн байгаль орчны сан	2019-2023	11.7 сая ам дол
5	Монголын унаган байгалийн хүлцэл ба тогтворжилтыг хангах нь төсөл	Даян дэлхийн байгаль орчны сан	2019-2026	7.9 сая ам дол
6	“Мазаалайн амьдрах орчныг тэтгэх нь” төсөл	БНХАУ-ын ЗГ	2019-2022	1 сая ам дол
7	Монгол орны усны засаглалыг бэхжүүлэхэд шинэлэг арга хэлбэрийг хэрэгжүүлэх нь төсөл	Азийн хөгжлийн банк, Ядуурлыг бууруулах Японы сан	2019-2022	1 сая ам дол
8	Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх нь	Азийн Хөгжлийн Банк	2019-2023	38 сая ам доллар
<b>Ойн бодлого, менежмент</b>				
9	Монгол-Солонгосын “Ногоон хэрэм” төсөл	БНСУ-ын Ойн ерөнхий газар	2016.07. 2022.07.	9 сая ам доллар
10	Монгол Улсын Замын үүдийн нутаг дэвсгэр дээрх хуурай газраас үүдэлтэй Шороон болон элсэн шуургын нөлөөг сааруулах, урьдчилан сэргийлэх төсөл	НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенц	2020-2022	0.5 сая ам доллар

Эх сурвалж: Байгаль орчин, аялал жуулчлалын яам

Хүснэгт 10. БОАЖ-ын салбарт хэрэгжиж буй Гадаадын зээл, тусламжийн төслүүд (2022)

Д/д	Төслийн нэр	Санхүүжүүлэгч байгууллага	Хэрэгжих хугацаа	Нийт санхүүжилт
<b>Биологийн аюулгүй байдлыг хангах, химийн хорт болон аюултай бодисын бодлого, зохицуулалт</b>				
11	“Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” 1-3 дугаар үе шат, NO 2012 65 511 төсөл	ХБНГУ-ын Засгийн газар, Сэргээн босголтын зээлийн банкны буцалтгүй тусламж	2015.05-2021.12 2020.03-2027	1-р үе шат: 15.3 сая евро. 2,3-р үе шат: 32.8 сая евро
12	Тусгай хамгаалалттай газар нутгуудад дэмжлэг үзүүлэх замаар экосистемийг хадгалан хамгаалахад хувь нэмэр оруулах нь төсөл; (SPACES)	ХБНГУ-ын Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яам	2019/03-2022/02	4.5 сая евро
13	Парисын хэлэлцээрийн хүрээнд Монгол Улсын оруулах Үндэсний хувь нэмрийн (NDC) хэрэгжилт, мониторингийн ил тод байдлыг сайжруулахад хөдөө аж ахуй, газар ашиглалтын салбарын чадавхыг бэхжүүлэх	Даян дэлхийн байгаль орчны сан	2019-2022	0.85 сая ам доллар
14	“Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төлөвлөлтийн процессыг боловсронгуй болгох үндэсний чадавхыг бэхжүүлэх” төсөл	Буцалтгүй тусламж Уур амьсгалын ногоон сан НҮБ-ын БОХ-ын буцалтгүй тусламж	2019-2021	2.8 сая ам доллар
15	НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенцийн хэрэгжилтийн Үндэсний дөрөвдүгээр тайлан, Хүлэмжийн хийн ялгаралт, шингээлтийн нэмэлт хоёрдугаар тайлан боловсруулах	НҮБ-ын ХХ-ын Буцалтгүй тусламж	2020-2021	0.9 сая ам.доллар
16	Монгол улсад үндэсний хүлэмжийн хийн тооллого тооцоо хийх тогтвортой бүтцийн орчинг бий болгож, хүлэмжийн хийн тооллого тооцоог хийг чадавхийг бэхжүүлэх нь төсөл	Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага /Жайка/	2016-2021	5 сая иен
17	Хамтарсан кредит олгох механизм	Япон улсын Засгийн газар	2013-2030	15 сая иен
18	"Монгол Улсад Монреалийн протоколыг хэрэгжүүлэх, удирдлага, зохион байгуулалтыг бэхжүүлэх нь" 11-р үе	НҮБ-ын Байгаль Орчны Хөтөлбөрийн Буцалтгүй тусламж	2018-2021	0.085 сая ам доллар

Эх сурвалж: Байгаль орчин, аялал жуулчлалын яам

Япон, Хонконг зэрэг өндөр хөгжилтэй орнууд байгаль хамгаалал болон энэ талын судалгаа шинжилгээнд олон талын ач холбогдол өгч ДНБ-ний 1.4%-2% хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг үндэсний төсвөөс зарцуулж байгаа бол Казахстан, Украин зэрэг орон жилд энэ чиглэлээр ДНБ-ий 0.5%-тай тэнцэх хэмжээний зардлыг хуваарилан зарцуулдаг байна. 2018 онд Монгол Улс ДНБ-ний 0.57%, 2020 онд 0.41%, 2021 онд 0.39%-тай тэнцэх хэмжээний зардлыг хүрээлэн буй орчин, байгаль хамгааллын чиглэлээр зарцуулж байна. Манай улсын энэ салбарын төсвийн сүүлийн 5 жилийн дунджаас харахад 81.2%-ийг урсгал зардал эзэлж байгаа нь энэ салбарт хөрөнгө оруулалтын шинжтэй арга хэмжээ харьцангуй бага байна (Тогтвортойхөгжил2030, 2021).

### 2.3.3 Боловсролын салбарын төсвийн шинжилгээ

Боловсролын салбарт хичээл, сургалтад хэрэгтэй бараа, үйлчилгээний төсвийг зарцуулах **гол субъект нь багш** гэдэг концепцийг практик болгох хэрэгтэй байна. Багшид хичээлээ заахдаа багшлахуйн ямар загвар (Instructional design) ашиглахаас хамааран хэрэгцээтэй материал, тоног төхөөрөмж, хэрэгсэл, мэргэжлийн зочин, эксперт, аялал хийх боломж нь байнга бэлэн байдаг бол хангалттай байдлын зарчим илүү сайн биелнэ (С.Эрдэмчимэг, 2021).

Энэ салбарын тогтвортой хөгжлийн зорилт болох 10 үзүүлэлтийг хөтөлбөрөөр ангилж үзвэл сургуулийн өмнөх боловсролтой холбоотой 2, ерөнхий боловсролтой холбоотой 1, насан туршийн боловсролтой холбоотой 3, бүх түвшинд хамааралтай 4 үзүүлэлт байна. Тогтвортой хөгжлийн 10 зорилгоос зургаа нь “Алсын хараа 2050”-тай ямар нэг хэмжээгээр уялдаатай байв. Үндэсний бодлого ТХЗ-той нийцтэй бол хэрэгжих магадлал нь өндөр юм (С.Эрдэмчимэг, 2021).

ОУ-ын байгууллагуудын судлаачид энэхүү төслийн шинжилгээний хэсэгт симуляциар шинжилгээ хийхэд боловсролын салбарын ахиц, дэвшлийн өнөөгийн хурдаар ТХЗ-д ч, үндэсний урт хугацааны зорилгод ч бүрэн хүрэхээргүй үр дүн гарчээ. 2030 онд хүрэх тогтвортой хөгжлийн зорилгод хамгийн хол байгаа үзүүлэлт нь багш нарыг тэтгэлэгт хамруулах, насанд хүрсэн хүм амд мэдээлэл харилцаа холбооны ур чадвар эзэмшүүлэх, бүх шатны сургалтын жендэрийн тэгш байдлыг хангах шалгуур байна. Боловсролын үр дүнг хамран сургалтаар гэхээсээ илүү төгсөлтийг нэмэгдүүлэх, сургууль завсардалтыг арилгах, олон улсын үнэлгээнд орох зэрэг эцсийн үр дүнгээр хэмжихээр болж байгаа тул бүх шатанд мөшгих судалгаа тогтмол хийх хэрэгтэйг олон улсын байгууллагуудын шинжилгээний дүн харуулж байна.

Манай улстай Хэрэглээний үнийн индекс (ХҮИ) ойролцоо Тунис улс 2020 онд боловсролын салбарт ДНБ-ний 6.6 хувийг зарцуулсан бол боловсролоор тэргүүлэгчид дэлхийн дунджаас өндөр хувийг боловсролд зарцуулдаг байна. 2020 онд боловсролын салбарын ДНБ-д эзлэх хувь Финлянд 7.15, Эстони 5.48, Өмнөд Солонгос 5.06 байсан бол Монгол улс 4.71, дэлхийн дундаж 4.89 тус тус байжээ (С.Эрдэмчимэг, 2021)..

### 2.3.4 Хүнс хөдөө аж ахуйн салбарын төсвийн шинжилгээ

Европын Холбооноос үзүүлж буй “Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслийг 2021 оноос эхлүүлээд байна (Б.Ганболд, 2021).

Хөдөө аж ахуйн салбарын төсвийн зарлагын бүтцийг эдийн засгийн ангилалаар авч үзвэл 2020 оны байдлаар нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 347.9 тэрбум төгрөг байгаа бөгөөд үүний 307.8 тэрбум төгрөг буюу 88.5 хувийг урсгал зардал, 20.5 тэрбум төгрөг буюу 5.6 хувийг хөрөнгийн зардал эзэлж байна. Тухайлбал 2011 онд урсгал зардал салбарын нийт төсвийн зардлын 17.9 хувийг эзэлж байсан бол 2020 онд 88.5 хувийг эзэлж, ихээхэн хэлбэлзэлтэй явж ирсэн нь харагдаж байна. 2020 онд урсгал шилжүүлгийн хэмжээ

нэмэгдсэн нь УИХ, Засгийн газрын тогтоолоор малчдын орлого болон үндэсний үйлдвэрүүдийг дэмжих зорилгоор ноолуурын зах зээлийн суурь үнэ дээр 1 кг тутамд 20000 /хорин мянга/ төгрөгийг буюу нийт 175.4 тэрбум төгрөгийн урамшууллыг малчин, мал бүхий иргэдэд мөнгөн шилжүүлэг хэлбэрээр олгосонтой холбоотой (Б.Ганболд, 2021).

ОУ-ын байгууллагуудын судлаачид төслийн хүрээнд хийгдсэн судалгаанд ХАА-н салбарын 1 ажиллагчид ногдох төсвийн зарлага ба хөдөлмөрийн бүтээмжийн хамаарлыг корреляцаар тооцон тодорхой түвшний эерэг хамааралтай бөгөөд шугаман хамаарлыг детерминацийн коэффициентээр ( $r^2$ ) шинжлэхэд шугаман хамаарал сул гэсэн үр дүнг тус тус гаргасан байна.

Судлаачид энэ салбарын төслийн судалгааны цаашдын үзэл баримтлалыг “ХАА-н салбарын урамшууллын тогтолцоонд үнэлгээ хийж, түүний зорилго, зорилтыг илүү тодорхой чиглэсэн үр дүнд хүргэх, хөдөө аж ахуйн салбарын бодлого, зохицуулалтад зах зээлийн механизмийг үр дүнтэй ашиглах нь зүйтэй. Мөн шалгуур үзүүлэлтүүдийг сонгохдоо гарцын биш илүү үр дүнгийн үзүүлэлтийг сонгох, аль болох хэмжиж болохуйц тооны болон чанарын шалгуур үзүүлэлтийг эрэмбэлж авч үзэх нь зүйтэй” гэж илэрхийлсэн байсан учир эмпирик шинжилгээний хэсэгт энэ чиг хандлагын аргачлалыг ашигласан болно.

### **Хоёрдугаар бүлгийн дүгнэлт**

Энэхүү бүлгийн хүрээнд төсвийн өнөөгийн байдал болон эдийн засгийн өнөөгийн байдлыг 2001-2021 оны байдлаар судалсан.

Засгийн газрын бүтцийн өөрчлөлттэй холбоотойгоор салбарын төсөв нь нэг багцаас өөр нэг багцад нийлэлт, шилжилт явагдаж 2012 онд 42 төсвийн ерөнхийлөн захирагчаар төсөв хувиарладаг байсан бол 2021 оноос 32 төсвийн ерөнхийлөн захирагчаар төсөв хувиарлагдаж зарцуулалт гарч байна.

2020 оны байдлаар Монгол улсын ДНБ-д эзлэх Засгийн газрын зардлын харьцаа 33 хувьд хүрээд байна. Энэ нь адил ангиллын орлоготой орнуудаас 7.5 хувиар өндөр байна (WorldBank.org, 2021). Улсын төсвийн нийт зардлаас 2012-2021 онд салбарт зарцуулсан зарлагын дүнг хувиар илэрхийлбэл зарцуулсан мөнгөн дүн нь боловсролын салбарт 23.1%-13.4% болж буурсан, нийгмийн хамгаалал халамжийн салбарт 12.8%-30.7% болж өссөн байна.

2010-2022 онуудын дундаж үзүүлэлтээр Монгол улсын нийт дотоодын нийт бүтээгдэхүүний 65%-ийг голлох салбарын ДНБ эзэлж, бусад салбарууд 35%-ийг бүрдүүлж байна. Ийнхүү улсын нийт ДНБ бүрэлдхүүнд салбарууд 2010 оноос хойш 65 %-ийг бүрдүүлж байгаа нь салбарууд цаашид эдийн засагт үзүүлэх өсөлтийг нэмэгдүүлж эсвэл бууруулж болзошгүй байна. ДНБ-ий бүрэлдхүүнд эрүүл мэнд нийгмийн хамгаалах (2%), боловсрол (4%), уул уурхай (21%) хүнс хөдөө аж ахуй (12%) барилга (4%), зам тээвэр (5%) бөөний болон жижиглэн худалдааны үйлчилгээ (11%), байгаль орчин, аялал жуулчлал (1%), төрийн удирдлага ба батлан хамгаалах (5%) эдгээр голлох салбарууд

65%-ийг эзэлж, бусад салбарууд 35% -ийг эзэлж байна. Тиймээс дотоодын нийт бүтээгдэхүүний өнөөгийн байдлыг салбарын ангилалаар судлах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулахдаа нягтлан бодох бүртгэлийн хандлагаар дүгнэлтээ тайлагнаж байгаа ч эдийн засгийн хөгжилд үзүүлэх нөлөөллийн өгөөжийн хандлагыг орхигдуулж байна.

Манай улсын хөгжлийн урт хугацааны бодлогын баримт бичигт “**Эдийн засаг**”-ДНБ 6.1 дахин нэмэгдэж нэг хүнд оногдох ДНБ 3.6 дахин өсөж, 15,000 ам.долларт хүрч, дэлхийн өндөр хөгжилтэй орнуудын босгыг давна” (Алсын хараа 2050) хэмээн зорилгоо тодорхойлсон. Энэ зорилгын хүрээнд авч хэрэгжүүлэх нэн тулгамдсан асуудлуудын нэг нь төсвийн зардал ба салбарын өсөлт хоорондын өнөөгийн байдал болон ирээдүйн чиг хандлагыг эмпирик байдлаар тодорхойлох юм гэж 2-р бүлгийг дүгнэж байна.

### III БҮЛЭГ. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

#### Судалгааны үндэслэл

ОУ-ын байгууллагуудын тайлангуудад төсөл хөтөлбөрүүдийн үр дүн ба төсөв уялдаагүй, зориулалт зарцуулалт хангалтгүй гэсэн дүгнэлүүдийг гаргасан байдаг. Тухайлбал уул уурхай болон бусад салбараас олсон орлогоо баялаг бүтээх салбарт бус нийгмийн халамж, хамгааллын салбарт ихээр оруулдаг. Энэ нь цаашдаа эдийн засгийн өсөлтийг дэмжихгүй, зарцуулалтын гол зорилго болох ажилгүйдлийг бууруулах, ажил эрхлэлтийг дэмжих зорилгодоо чиглэхгүй байгааг судлаачид дүгнэдэг. Иймд салбаруудад төсвийн зарцуулалт хувиарлахдаа илүү үр дүнд чиглэсэн байдлаар буюу эдийн засагт чухал байр суурь гүйцэтгэдэг салбаруудад үр ашгаар нь эрэмбэлэх шаардлагатай байна.


Монгол улсын төсвийн зарлага, эдийн засгийн өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийн, төсвийн зардлыг эдийн засагт үзүүлэх нөлөөллийг тооцож, төсвийн хөрөнгө оруулалтууд үр дүнтэй байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх, сайжруулах санал зөвлөмж боловсруулахад судалгааны ажлын зорилго оршино.

#### 3.1 Судалгааны дизайн, үе шат

Зураг13-т судалгааны онолын тоймоос үндэслэн дараах асуудлыг дэвшүүлсэн:

1. Монгол улсын хувьд төсөв оновчтой хувиарлалтай байгаа эсэх,
2. Монгол улсын ДНБ, төсвийн хамаарал ямар байдаг вэ?
3. Салбарын ДНБ нь зарлагын хувьтай харьцуулахад хэр хэмжээтэй байдаг вэ?
4. Улс орнуудын зарлагын хувиарлалт Монгол улстай харьцуулахад ямар байдаг вэ?
5. Төсөв болон ДНБ -ийн хооронд статистикийн хувьд ямар хамааралтай байдаг вэ? зэрэг асуудлуудыг тус тус дэвшүүлсэн. Дээрх асуудлыг *Зураг13*-т харууллаа.

Зураг 13. Судалгааны дизайн




Эх сурвалж: Судалгааны багийн тооцоолол

Зураг 13-д дэвшүүлсэн асуудлуудыг дараах шинжилгээний 5 аргаар шинжилсэн.

1. Төсвийн шалгуур үзүүлэлтийн шинжилгээ
2. Төсвийн зарлага ба салбарын ДНБ хамаарлын шинжилгээ
3. Салбарын ДНБ ба зарлагын шинжилгээ (эзлэх хувиар)
4. Алсын хараа 2050-ийн зорилт ба гүйцэтгэл
5. Улс орнуудын орлогын түвшний ангилалын харьцуулсан шинжилгээ
6. ДНБ, салбарын ангилал бусад голлох хүчин зүйлийн шинжилгээ зэрэг аргуудаар тус тус шинжилсэн байдлаар *Зураг 14*-т судалгааны үе шат бүрээр схемчлэн харууллаа.

Зураг 14. Судалгааны үе шат



Эх сурвалж: Судалгааны багийн тооцоолол

### 3.2 Судалгааны өгөгдөл, шинжилгээний аргачлал

Судалгаанд илэрхийлэх гэж буй өгөгдлийн онцлог болон хүртээмжтэй байдлаас хамааран 1991-2022, 2000-2022, 2015-2022 оны хугацааны интервалын тоон үзүүлэлтийг ҮСХ -ний мэдээллийн нэгдсэн сангаас авсан.

#### 3.2.1. Төсвийн шалгуур үзүүлэлтийн шинжилгээний аргачлал

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн (6.1.Төсөвт дараахь тусгай шаардлагууд нэгэн зэрэг хангагдсан байна) дагуу 4 шалгуур үзүүлэлтээр 2015-2022 оны төсвийн гүйцэтгэл тус бүрд шинжилгээ хийсэн. Үүнд:

Шалгуур үзүүлэлт 1: Улсын төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг хэрхэн төсөвлөдөг вэ?

Шалгуур үзүүлэлт 2: Тэнцвэржүүлсэн орлогоор тооцсон тэнцэл нь гүйцэтгэлийн хувиа хангаж байна уу?

*Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байх;*

*(Алдагдал/ашиг < GDP\*2%)*

Шалгуур үзүүлэлт 3: Төсвийн зарлагын өсөлтийн хувь байвал зохих түвшиндээ байна уу?

*Тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь нь тухайн жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн хувь, тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн дунджийн аль ихээс хэтрэхгүй байх;*

*Зарлагын хязгаарлалт ( $g < gGDP$ ) /эрдэс баялгийн бус/ эсвэл  $g < gmin/gdp-12year$*

Шалгуур үзүүлэлт 4: Засгийн газрын нийт өр, зээлийн баталгаа зохистой түвшинд байна уу?

*Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 60 хувиас хэтрэхгүй байгаа эсэх;*

*Засгийн газрын нийт өр, зээлийн баталгаа < GDP\*60%*

### **3.2.2 Улсын төсвийн зарлага ба нийт ДНБ, тэдгээрийн өсөлтийн хувиар хийсэн хамаарлын шинжилгээний аргачлал**

Энэхүү аргачиллаар Монгол улсын эдийн засгийн өсөлтийн төлөв байдлыг харахын тулд нэрлэсэн ДНБ, бодит ДНБ, ДНБ-ий өсөлтийн хувийг нэрлэсэн ба бодит дүнгээр, улсын төсвийн зарлага, төсвийн зарлагын өсөлтийн хувь түүнчлэн 2001-2022 оны хуанлийн жилүүдэд ДНБ-д эзлэх төсвийн зарлагын өсөлтийн хувь гэсэн эдийн засгийн зургаан үзүүлэлтийг сонгож шинжилгээ хийсэн.

### **3.2.3 Салбарын ДНБ, төсвийн зардлын шинжилгээний аргачлал**

Энэхүү шинжилгээгээр 2012-2021 онуудад МУ-ын засгийн газраас салбаруудад хуваарилсан зардал нь төсвийн нийт зардалд хэдэн хувийг эзэлж байгаа мөн эдгээр салбарууд нь ДНБ-ий хэдэн хувийг бүрдүүлж байна гэдгийг тодорхойлсноор эдийн засагт үзүүлж буй нөлөөг харуулахыг зорьсон.

Шинжилгээний таамаглалд засгийн газраас хамгийн их төсөв зарцуулагдаж буй салбарууд нь эргээд эдийн засагт өсөлт авчрахгүй, бүр хүндрэл учруулж байж болзошгүй гэсэн таамаглал дэвшүүлсэн юм.

Монгол Улсын төсвийг 2021 онд нийт 32 төсвийн ерөнхийлөн захирагчид хувиарлан зарцуулж байна. Нийт зардлын дүнгээр хамгийн их зарцуулалттай 9 салбар болох эрүүл мэнд нийгмийн хамгаалал, боловсрол, зам тээвэр, батлан хамгаалах, хүнс, хөдөө, аж ахуй



хөнгөн үйлдвэр, барилга, аялал жуулчлал болон уул, уурхай гэсэн салбаруудын зардал болон ДНБ-ий нөлөөг харьцуулж шинжилсэн болно.

### 3.2.4 Регрессийн шинжилгээний аргачлал, арга зүй

Олон хүчин зүйлийн регрессийг үнэлэхдээ тайлбарлагдагч хүчин зүйлээр дотоодын нийт бүтээгдэхүүнийг салбарын ангиллаар, улсын нэгдсэн төсвийн зардлыг эдийн засгийн ангиллаар тус тус авсан болно.

Регрессийн загварыг дараах байдлаар томъёолсон болно. Үүнд:

Олон хүчин зүйлийн регрессийн загварыг үнэлэхдээ тайлбарлагдагч хүчин зүйл тус бүрд нь үнэлсэн бөгөөд төсвийн зардал ба ДНБ-д 2012-2021 оны байдлаар эзэлж байгаа хувь хэмжээг харуулаад цаашид эдийн засагт голлох 5 салбарт үнэлгээ хийсэн болно.

Үүнд:

- Боловсролын салбар (4%)
- Уул уурхай олборлолтын салбар (21%)
- Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбар (12%)
- Хүний хөгжил, нийгэм хамгаалал (2%)
- Аялал жуулчлалын салбар (1%)

Лог-Лог Регрессийн шинжилгээний арга зүй:

Хувьсах үзүүлэлтүүдийн коэффициентийн тоон утгыг олон хүчин зүйлийн хамаарлын шинжилгээний хамгийн бага квадратын аргаар дараах загвараар тооцно.

Энд:

$n$  тооны үл хамааран хувьсагчид

$\log(y)$  - ДНБ-ий салбарын логарифм

$\log(x_1), \dots, \log(x_n)$  - Хувьсах үзүүлэлтүүд буюу тодорхойлж байгаа үзүүлэлтүүд

$\beta_1, \dots, \beta_n$  - Загварын коэффициентүүд буюу хувьсагч тус бүрийн жин,

$\varepsilon$  – үлдэгдэл санамсаргүй хэмжигдэхүүн

$$\log(y) = c + \beta_1 \log(x_1) + \beta_2 \log(x_2) + \beta_n \log(x_n) + \varepsilon$$

буюу регрессийн шинжилгээ дээрх байдлаар тодорхойлогдсон.

### **3.2.5 ДНБ-д эзлэх Засгийн газрын зардлын хувийг улс орнуудын орлогын түвшний ангилалаар харьцуулсан шинжилгээ, түүний аргачлал**

Улс орнуудын засгийн газрууд эдийн засгийн салбарууддаа хуваарилж буй зардлыг ДНБ-нд харьцуулан шинжилсэн. Ингэхдээ орлогын түвшингийн (Өндөр-High income, Дундаас дээш-Upper middle income, Дундаас доогуур-Lower middle income, Бага-Low income) ангилал тус бүрээр харьцуулсан. Салбаруудыг тодруулбал:

Батлан хамгаалах салбар дахь төсвийн зардлын ДНБ-д эзлэх хувь (улс орнуудын орлогын ангиллаар)

Боловсрол салбар дахь төсвийн зардлын ДНБ-д эзлэх хувь (улс орнуудын орлогын ангиллаар)

Эрүүл мэнд хамгаалах салбар дахь төсвийн зардлын ДНБ-д эзлэх хувь (улс орнуудын орлогын ангиллаар)

Хөдөө аж ахуй салбар дахь төсвийн зардлын ДНБ-д эзлэх хувь (улс орнуудын орлогын ангиллаар)

#### **Гуравдугаар бүлгийн дүгнэлт**

Энэ бүлэгт судалгааны дизайны дагуу өмнөх 1,2-р бүлгийн агуулга тус бүрийг онолын үзэл баримтлал, эрдэмтэн судлаачдын илэрхийлсэн байр суурь нь манай улсын төсөв, эдийн засгийн өсөлтийн өнөөгийн нөхцөл байдалтай хэрхэн уялдаж байгааг, төсвийн хөрөнгө оруулалтууд үр дүнтэй байгаа эсэхийг тодорхойлох зорилгоор *1. Төсвийн шалгуур үзүүлэлтийн шинжилгээний аргачлал 2. Улсын төсвийн зарлага ба нийт ДНБ, тэдгээрийн өсөлтийн хувиар хийсэн хамаарлын шинжилгээний аргачлал 3. Салбарын ДНБ, төсвийн зардлын шинжилгээний аргачлал 4. Регрессийн шинжилгээний аргачлал, арга зүй 5. ДНБ-д эзлэх Засгийн газрын зардлын хувийг улс орнуудын орлогын түвшний ангилалаар харьцуулсан шинжилгээ, 6. Алсын хараа 2050 тогтвортой хөгжлийн зорилт ба гүйцэтгэл түүний аргачлал тус бүрээр тооцооор тодорхойлж дараагийн бүлгийн эмпирик судалгаанд шилжиж байна.*

## IV БҮЛЭГ. ЭМПИРИК СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ БА ҮР ДҮН

### 4.1 Төсвийн шалгуур үзүүлэлтээр шинжлэх нь

Монгол улсын төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйл, (6.1.Төсөвт дараахь тусгай шаардлагууд нэгэн зэрэг хангагдсан байна) төсвийн тусгай шаардлагад заасны дагуу төсвийн орлогыг төлөвлөхдөө 4 шалгуур үзүүлэлтийг тавьдаг байна.

2015-2022 оны байдлаар төсвийн гүйцэтгэлийн үзүүлэлтүүд дээр төсвийн тогтвортой байдлын шалгуур үзүүлэлтүүдийг хангаж байгаа эсэхийг шинжиллээ. Үүнд:

#### 4.1.1 Шалгуур үзүүлэлт 1: Тэнцвэржүүлсэн орлого (Дэлхийн зах зээл дээрх зэсийн үнэ)

6.1.1. нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцдог байх;

Улсын нэгдсэн төсвийн орлогын төлөвлөлтийг хийхдээ дэлхийн зах зээл дээрх зэсийн үнэнд суурилдаг байна. Нийт тэнцвэржүүлсэн төсвийн тэнцлийн ашиг алдагдалын ДНБ-д эзлэх хувийг тодорхойлохдоо тухайн жилийн оны үнээрх ДНБ-ээр авч үздэг.

Хүснэгт 11. Шалгуур үзүүлэлт 1-ийн хангасан байдал

Төсвийн шалгуур үзүүлэлт 1								
(тэрбум.төг)								
Үзүүлэлт	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022
Тэнцвэржүүлсэн орлого (Дэлхийн зах зээл дээрх зэс, түүхий эдийн үнэ)	+	+	+	+	+	+	+	+

Эх сурвалж: ҮСХ, Судлаачийн тооцоолол

#### 4.1.2 Шалгуур үзүүлэлт 2: Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл

6.1.2. нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байх;

(Алдагдал/ашиг < GDP\*2%)

Хүснэгт 12. Шалгуур үзүүлэлт 2-ийн хангасан байдал

Төсвийн шалгуур үзүүлэлт 2 (тэрбум.төг)	Тайланг он	Тэнцвэржүүлсэн төсвийн тэнцэл	Тухайн жилийн оны үнээрх ДНБ	Зохистой дүн (ДНБ-ний 2%)		Тэнцвэржүүлсэн орлогоор тооцсон тэнцэл хувиар (Алдагдал/ашиг < GDP*2%)	
				Дүн	Хувь	Дүн	Хувь
				2015	(1,156.9)	23,150.4	463.0
2016	(3,660.3)	23,942.9	478.9	2%	(3,660.3)	15.3%	
2017	(1,742.5)	28,010.7	560.2	2%	(1,742.5)	6.2%	
2018	27.9	32,582.6	651.7	2%	27.9	0.1%	
2019	(756.2)	37,839.2	756.8	2%	(756.2)	2.0%	
2020	(4,440.5)	37,453.3	749.1	2%	(4,440.5)	11.9%	
2021	(2,919.0)	43,555.5	871.1	2%	(2,919.0)	6.7%	
2022	(979.3)	52,867.4	1057.3	2%	(979.3)	1.9%	

Эх сурвалж: ҮСХ, Судалгааны багийн тооцоолол

Статистикийн мэдээллийн нэгдсэн сангийн мэдээлэлд суурилан боловсруулалт хийж нэгтгэлийг Хүснэгт 12-д харуулав.

“Төсвийн тогтвортой байдлын тухай хууль”-ийн Шалгуур 2-д заасан үзүүлэлт нь 2015-2017 онууд болон 2020-2021 он тус бүрд төсвийн тогтвортой байдлын шалгуур үзүүлэлтийг хангаж чадахгүй байна. Тухайлбал 2016 онд (-15.3%), 2017 онд (-6.2%), 2020 онд (-11.9%), 2021 онд (-6.7%) болж төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн шалгуур хангагдаагүй байна.

#### 4.1.3 Шалгуур үзүүлэлт 3: Зарлагын хязгаарлалт

6.1.3. Тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь нь тухайн жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн хувь, тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн дунджийн аль ихээс хэтрэхгүй байх;

$$(g < gGDP) / \text{эрдэс баялгийн бус} / \text{эсвэл } g < gmin/gdp-12\text{year}$$

Хүснэгт 13. Шалгуур үзүүлэлт 3-ийн хангасан байдал

	Тайланг он	Төсвийн зарлага	Өсөлтийн хувь (g)	ДНБ /эрдэс баялгийн бус/	Өсөлтийн хувь(g GDP)	Зарлагын хязгаарлалт (g<gGDP or g<gmin/dgp-12 year) Хэтэрсэн дүн
Төсвийн шалгуур үзүүлэлт-3 (тэрбум.төг)	2015	7,138.0	9.0%	18,744.3	0.96%	8.0%
	2016	9,495.3	33.0%	19,108.7	1.9%	31.1%
	2017	9,017.3	-5.0%	21,002.8	9.9%	-14.9%
	2018	9,317.2	3.3%	24,211.8	15.3%	-12.0%
	2019	11,661.7	25.2%	28,249.1	16.7%	8.5%
	2020	13,904.2	19.2%	28,731.2	1.7%	17.5%
	2021	15,630.4	12.4%	32,801.8	14.2%	-1.8%
	2022	18,177.8	16.3%	39,998.1	21.9%	-5.6%

Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, 2022

Төсвийн зардлын өсөлтийн хувь нь тухайн оны эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлтийн хувиас хэтрэхгүй байгаа эсэхийг шинжиллээ. 2017, 2018 онуудад тогтвортой байдлын энэ шалгуур үзүүлэлтийг хангаж байсан бол 2016 онд (-31%) цаашлаад 2019 онд (-9%), 2020 онд (-18%), тус тус зардлын хязгаарлалтын шалгуурыг хангаж ажиллаагүй байна. 2016,2020 онууд нь сонгуулийн жил байсан бөгөөд төсвийн зардал илүү өндөр өсөлттэй байжээ. (Хүснэгт 13)

#### 4.1.4 Шалгуур үзүүлэлт 4: Засгийн газрын нийт өр, зээлийн баталгааны түвшин

6.1.4. Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 60 хувиас хэтрэхгүй байх;

$$\text{Засгийн газрын нийт өр, зээлийн баталгаа} < GDP * 60\%$$

#### Хүснэгт 14. Шалгуур үзүүлэлт 4-ийн хангасан байдал

Төсвийн шалгуур үзүүлэлт 4 (тэрбум.төг)	Тайланг он	Засгийн газрын нийт өр	Тухайн жилийн оны үнээрх ДНБ	Зохистой дүн (ДНБ-ний 60%)		Засгийн газрын нийт өр, зээлийн баталгаа<GDP*60%	
				Дүн	Хувь	Дүн	Хувь
	2015	14,400.0	23,150.4	13,890.2	60%	14,400.0	62.2%
	2016	22,280.1	23,942.9	14,365.7	60%	22,280.1	93.1%
	2017	22,751.6	28,010.7	16,806.4	60%	22,751.6	81.2%
	2018	22,367.0	32,582.6	19,549.6	60%	22,367.0	68.6%
	2019	24,199.7	37,839.2	22,703.5	60%	24,199.7	64.0%
	2020	27,898.6	37,453.3	22,472.0	60%	27,898.6	74.5%
	2021	26,918.2	43,555.5	26,133.3	60%	26,918.2	61.8%
	2022	33,149.1	52,867.4	31,720.4	60%	33,149.1	62.7%

Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, 2022

Улсын нийт өр, зээлийн ДНБ-д эзлэх хувийг тооцоолохдоо улсын засгийн газрын нийт өр, тухайн жилийн оны үнээрх ДНБ-ийг авч үзлээ. 2015 онд тогтвортой байдлын шалгуур үзүүлэлттэй ойролцоо байсан бол 2016-2022 онуудад мөн л төсвийн тусгай шаардлагыг хангаж чадахгүй байна. Учир нь Монгол Улсын Засгийн газар хөрөнгө оруулалтыг дэмжих, дэд бүтцийг хөгжүүлэх, улс орны эдийн засгийн хөгжилд түлхэц болохуйц төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх зорилгоор 20 гаруй гадаад орон, олон улсын санхүүгийн байгууллагуудаас авсан зээлийн үлдэгдэл 2022 оны эцэст 8,400.0 сая ам доллар буюу 33,149.1 тэрбум төгрөгт хүрчээ. (Хүснэгт 14)

Засгийн газрын болон нийт гадаад өрийн хэмжээ ингэж өссөн нь эдийн засгийн өсөлтийг дэмжих хэмжээнээс хэтэрсэн үзүүлэлт бөгөөд цаашилбал өрийн дарамтанд орох эрсдэлтэйг харуулж байна. (Хүснэгт 14) Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд төсвийн алдагдлын зорилтот түвшинг 4 жил тутамд шинэчлэн тогтооно гэж заасан боловч 2015-2017 онуудад хуулийн тусгай шаардлагын үзүүлэлтийн өр, төсвийн алдагдлын дээд хязгаарт 3 удаагийн өөрчлөлт оруулж өөрчилсөн (жишээ нь, 2016 онд өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн өрийн дээд хэмжээг ДНБ-ий 40 хувиас 60 хувь болгон нэмэгдүүлсэн).

Хүснэгт 15. Төсвийн тусгай шаардлагыг хангасан байдал

Он	Шалгуур 1	Шалгуур 2	Шалгуур 3	Шалгуур 4
	Тэнцвэржүүлсэн орлого	Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл	Зарлагын хязгаарлалт	Засгийн газрын нийт өр, зээлийн баталгааны түвшин
2015	✓	✗	✗	✗
2016	✓	✗	✗	✗
2017	✓	✗	✓	✗
2018	✓	✓	✓	✗
2019	✓	✓	✗	✗
2020	✓	✗	✗	✗
2021	✓	✗	✓	✗
2022	✓	✓	✓	✗
<b>Тийм</b>	8	3	4	0
<b>Үгүй</b>	0	5	4	8

Эх сурвалж: УСХ, Судалгааны багийн тооцоолол

2015-2022 оны байдлаар төсвийн гүйцэтгэлийн үзүүлэлтүүд дээр төсвийн тогтвортой байдлын тэнцвэржүүлсэн орлого, төсвийн тэнцлийн тэнцвэржүүлсэн тэнцэл, зарлагын хязгаарлалт, засгийн газрын нийт өр, зээлийн баталгааны түвшин гэсэн 4 шалгуур үзүүлэлтээр шинжлэхэд эхний буюу тэнцвэржүүлсэн орлогын шалгуурыг 2015-2022 онуудад хангасан. Харин төсвийг тэнцвэржүүлсэн тэнцлийн шалгуурыг 2018- 2019, 2022 онд хангаж, бусад онуудад хангаагүй байна. Зарлагын хязгаарлалтаар шалгуур үзүүлэлтийг 2015-2016, 2019-2020 онуудад хангаж, 2017-2018, 2021-2022 онуудад хангаж чадахгүй байна. Засгийн газрын нийт өр, зээлийн баталгааны түвшинээр шалгуур үзүүлэлтийг 2015 оноос 2022 он хүртэл хангаагүй байна. Эдгээрээс харвал төсвийн зарцуулалтын тухай хууль эрх зүйн орчны суурь бий хэдий ч хэрэгжүүлэх механизм дутуу, түүнд хөндлөнгийн хяналт тавих, үнэлгээ хийх системийг бүрдүүлэх хэрэгцээ шаардлага дутагдалтай байна.

#### 4.2 Төсвийн зарлага ба ДНБ хамаарлын шинжилгээ

Монгол улсын эдийн засгийн өсөлтийн төлөв байдлыг харахын тулд нэрлэсэн ДНБ, бодит ДНБ, ДНБ-ий өсөлтийн хувь, улсын төсвийн зарлага, төсвийн зарлагын өсөлтийн хувь түүнчлэн 2001-2022 оны хуанлийн жилүүдэд ДНБ-д эзлэх төсвийн зарлагын өсөлтийн хувь гэсэн эдийн засгийн 6 үзүүлэлтийг сонгож шинжилгээ хийсэн.


Шинжилгээний эхний хэсэгт ДНБ-ий өөрчлөлтийг авч үзнэ. (Хавсралт 5-ыг үзнэ үү.)

2001-2022 оны үзүүлэлтээр Монгол улсын төсвийн зарлагын хэмжээ 2001 онд 489.7 тэрбум төгрөг байсан бол 2022 оны эцсээр 18,177.8 тэрбум төгрөгт хүрч 37.12 дахин өсөж жилийн дундаж өсөлтийн хувь 19.9% байна.

Нэрлэсэн ДНБ-ий хэмжээ 2001 онд 1,424.7 тэр бум төгрөг байсан бол 2022 оны эцсээр 52,867.4 тэрбум төгрөгт хүрч нийт дүн мөн 37 дахин өсөж, жилийн өсөлтийн хувь дунджаар 19.0% байна. Ийнхүү төсвийн зарлага болон нэрлэсэн ДНБ-ийн хэмжээ өнгөрсөн 20 жилд адил тэнцүү өссөн ч төсвийн зарлагын жилийн өсөлтийн хувь нь ДНБ-

ий өсөлтийн хувиас давж хэтэрсэн байна. ДНБ-ийн өсөлтийн хувь уул уурхай, олборлох үйлдвэрлэлийн салбар, гадаад дотоодын хөрөнгө оруулалтын нөлөөгөөр ДНБ 2010-2011 онд өндөр өсөлт үзүүлсэн бол түүнээс хойш буурсан(Зураг15)


Зураг 15. Нэрлэсэн ДНБ болон ДНБ-ий өсөлтийн хувь



Эх сурвалж: ҮСХ, Судалгааны багийн тооцоолол

Дараагийн графикт тухайн жилийн оны үнээрх ДНБ-д тухайн оны инфляцийн нөлөөг тооцсоноор бодит ДНБ-д шилжүүлж, (Зураг 16) бодит ДНБ-ий өсөлтийн хувиар тооцон өмнөх (Зураг 15.)-тай харьцуулан дүгнэвэл дараах байдалтай байна.

Зураг 16. БДНБ болон Инфляцийн түвшин



Эх сурвалж: ҮСХ, Судалгааны багийн тооцоолол


2001 оноос хойшхи жилүүдэд инфляцийн нөлөөг тооцсоноор бодит ДНБ-ийн өсөлтийн хувь нь зарим жилд сөрөг буюу 2009 онд (-1.3%), 2020 онд (-4,6%) үзүүлэлттэй ба дунджаар жилд ердөө 6.1% болж өсөлттэй байгаа нь нэрлэсэн дүнгээс тооцсон өсөлтийн хувиас 12.9%-иар багассан үзүүлэлт юм.

Цаашлаад судлахад төсвийн зарлагын цар хүрээ (ДНБ-д эзлэх төсвийн зарлагын эзлэх хувь) тогтворгүй байгааг (Зураг 17-с) харж болно.

Ялангуяа төсвийн алдагдал 2016 онд (-3,660.3) тэрбум төгрөг, 2020 онд (-4,440.5) тэрбум төгрөгт хүрч огцом нэмэгдсэн үеүдэд, төсвийн зарлагын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 38%-д хүрсэн байна. Төсвийн цар хүрээний энэ үзүүлэлт өмнөд хөрш Хятад улсад (2001-2019) хамгийн ихдээ 16% түүнээс доош хувь хэмжээтэй байдаг(Zhang, 2022).

Зураг 17-д ДНБ-ийн өсөлтийн хувь, төсвийн зарлагын өсөлтийн хувийг зэрэгцүүлсэн байдлаар харуулсан болно. ДНБ-ий өсөлтийн хурд 2008-2009 онд буурч, 2009-2010 онд сэргэж байсан бол ДНБ-ийн өсөлт үзүүлсний дараагийн жил тутам төсвийн зарлагын өсөлтийн хурд огцом өссөн байна. Төсвийн зарлагын өсөлтийн хурд ДНБ-ийн өсөлтийн хувиас жил тутам өндөр байсан.

Зураг 17. НДНБ, төсвийн зарлагын өсөлтийн хувь



Эх сурвалж: ҮСХ, Судалгааны багийн тооцоолол


2001-2022 оны Монгол улсын нэрлэсэн ДНБ-ий өсөлтийн хурд болон төсвийн зарлагын өсөлтийн хурдаар хугацааны цувааны өгөгдлийн шинжилгээг хийсэн. Нэгтгэл диаграммыг Зураг 17-т харууллаа. (Хавсралт 5-ыг үзнэ үү)

Зураг 17-д нэрлэсэн ДНБ-ий өсөлтийн хурд 2009-2010 он хүртэл огцом өссөнөөс хойш нэг жилийн дараа төсвийн зарлагын өсөлтийн хурд 2010-2011 он хүртэл өсөх хандлагатай байсан бөгөөд энэ хоёрын хүрээ ижил байна.

2001-2022 онуудад төсвийн зарлагын өсөлтийн хурд жилд 19.9% байсан бол бодит ДНБ-ийн өсөлтийн хурд жилд 6.1% байна (Зураг 18, Хавсралт 7)




Зураг 18. БДНБ, төсвийн зарлагын өсөлтийн хувь



Эх сурвалж: ҮСХ, Судалгааны багийн тооцоолол

Зураг 17,18-с харахад Монгол улсын ДНБ-ий өсөлтийн хувь нь төсвийн зарлагын өсөлтийн хурдаас жил тутам хоцорч байгааг харж болно. Өнөөгийн нөхцөл байдлаар эдийн засгийн хөгжилд буурах дарамт байсаар байгаа бөгөөд үүний нэг шалтгаан нь төсвийн зарлагын өсөлтийн хурд буурахгүй, ДНБ-ий өсөлтийн хурд түүнээс давж нэмэгдээгүй байна.

Зураг 19. Монгол улсын нэг хүнд ногдох ДНБ(ам.доллар)



Эх сурвалж: Дэлхий банк

Зураг 19-д 2000-2021 онуудад нэг хүнд ногдох орлогыг ам.доллараар болон түүний өсөлтийн хувиар авч үзэхэд 2010 оноос хойш томоохон өөрчлөлт гараагүй байна. Энэ нь Монгол улсын эдийн засаг нэрлэсэн дүнгээрээ өсөж байгаа ч гаднаас орж ирэх валютын урсгалын дүнгээрээ сүүлийн 11 жил зогсонги байдалд орсон байгааг харуулж байна. Өсөлтийн түвшинг харвал 2009 онд (-19.5%)-ийн бууралт үзүүлсэн нь дэлхийн санхүүгийн хямралаас үүдсэн түүхий эдийн үнийн бууралттай давхцсан байна. Харин 2010 оны өсөлт нь Монгол улсад томоохон ордууд ашиглалтад орсон, гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдсэн зэргээс үүдэлтэй. Мөн энэ цаг үеэс эхлэн валютын зээл, дэлхийн зах зээл дээрх голлох түүхийн эдийн үнийн бууралт зэргээс улбаатай уналт тохиосон. Эндээс үзвэл Монгол улсын валютаар илэрхийлэгдэх бодит орлого уул уурхайн тэр дундаа голлох түүхий эдийн үнэ, гарцаас хамаардаг гэж үзэж болохоор байна.

### 4.3 Салбарын ДНБ, зарлагын шинжилгээ (төсвийн нийт зарлага ба ДНБ-д эзлэх хувиар)

Энэхүү шинжилгээгээр 2012-2021 онуудад МУ-ын засгийн газраас салбаруудад хуваарилсан зардал нь төсвийн нийт зардалд хэдэн хувийг эзэлж байгаа мөн эдгээр салбарууд нь ДНБ-ий хэдэн хувийг бүрдүүлж байна гэдгийг тодорхойлсноор эдийн засагт үзүүлж буй нөлөөг харьцуулж үзэж байна.

Эрүүл мэнд нийгмийн хамгаалал, боловсрол, зам тээвэр, батлан хамгаалах, хүнс, хөдөө, аж ахуй хөнгөн үйлдвэр, барилга, аялал жуулчлал болон уул, уурхай гэсэн салбаруудаар 2012-2021 оны Монгол улсын нийт төсвийн зардалд салбарын зардлын эзлэх хувь болон дотоодын нийт бүтээгдхүүнд эзлэх хувь хэмжээгээр эдийн засагт үзүүлж буй нөлөөг шинжилж үзэв(Хүснэгт 16).

Хүснэгт 16. Салбар тус бүрээр ДНБ ба төсвийн зарлага

САЛБАРЫН АНГИЛАЛ	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021
Хөдөө аж ахуй,днб	11.20%	13.39%	13.27%	14.00%	12.50%	11.00%	11.30%	11.50%	12.80%	13.02%
Хөдөө аж ахуй,т.зарлага	2.07%	3.24%	2.93%	2.10%	2.05%	2.17%	1.88%	1.82%	3.07%	1.47%
Уул уурхай,днб	17.80%	15.92%	17.00%	18.60%	20.70%	25.80%	26.40%	25.80%	24.10%	25.38%
Уул уурхай,т.зарлага	0.35%	0.44%	0.41%	0.34%	0.25%	0.41%	0.36%	0.40%	0.32%	0.29%
Цахилгаан,днб	1.30%	1.52%	1.58%	2.10%	2.30%	2.10%	2.00%	2.00%	2.10%	1.94%
Эрчим хүчний,т.зарлага	4.05%	3.00%	3.19%	0.71%	1.53%	1.65%	1.97%	1.18%	0.42%	0.54%
Барилга,днб	5.90%	5.83%	5.08%	4.40%	4.10%	3.60%	3.60%	4.00%	4.20%	3.70%
Барилга,т.зарлага	1.94%	1.97%	3.46%	0.79%	0.99%	1.17%	1.44%	1.75%	1.51%	1.64%
Тээвэр,днб	5.20%	4.25%	4.84%	5.20%	5.20%	4.60%	4.70%	4.40%	3.60%	3.80%
Тээвэр,т.зарлага	10.29%	11.16%	6.64%	4.93%	14.78%	9.24%	5.44%	2.65%	2.37%	2.18%
Үйлчилгээ,днб	1.20%	1.19%	0.99%	1.10%	1.20%	1.00%	1.20%	1.20%	1.00%	0.99%
Жуулчлалын,т.зарлага	1.90%	1.46%	1.16%	1.19%	0.74%	0.96%	1.19%	1.02%	1.24%	1.21%
Төрийн удирдлага,днб	4.20%	4.11%	4.08%	5.90%	5.90%	5.50%	4.90%	4.70%	5.40%	5.01%
Батлан хамгаалах,т.зарлага	3.55%	3.46%	3.71%	4.40%	3.11%	3.12%	3.15%	2.81%	2.51%	2.25%
Боловсрол,днб	4.50%	4.46%	4.48%	4.40%	4.50%	4.00%	3.80%	4.00%	4.40%	4.00%
Боловсрол,т.зарлага	20.55%	20.53%	23.11%	21.98%	18.40%	17.73%	20.56%	19.52%	14.50%	13.43%
Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд днб	1.90%	1.90%	1.88%	2.10%	2.00%	1.80%	1.80%	2.00%	2.30%	2.39%
Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд т.зарлага	25.16%	19.86%	21.64%	23.61%	20.90%	25.85%	27.87%	26.78%	30.03%	39.38%


Эх сурвалж: УСХ, Судалгааны багийн тооцоолол

### 4.3.1. Батлан хамгаалах салбарын зарлага болон ДНБ-д эзлэх хувь

Монгол улсын нийт төсвийн зардлаас Батлан хамгаалах салбарт өнгөрсөн 10 жилд 2.25-3.5 хүртэл хувийг зарцуулсан байна.

Тухайлбал 2012 онд энэ салбарын зардал нийт төсвийн зардлын 3.55 хувь байсан бол 2021 онд 2.25 хувь болж 1.3 хувиар буурсан. Харин Монгол улсын нийт ДНБ-д салбарын ДНБ-ийн эзлэх хувь өнгөрсөн 10 жилд 4.1-5.9 хүртэл хувийг эзэлж байна. Тодруулбал: 2012 онд улсын нийт ДНБ-д Батлан хамгаалахын салбарын ДНБ 4.22 хувь бүрдүүлж байсан бол 2021 онд 5.01 хувь болж өсжээ. Сүүлийн 10 жилд батлан хамгаалахын салбарын төсвийн зардал тасралтгүй буурч байсан ч салбарын ДНБ өсөлттэй байгаа нь харагдаж байна(Зураг 20).

Зураг 20. Батлан хамгаалах салбарын ДНБ ба төсвийн зарлагын үзүүлэлт




Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, 2022

### 4.3.2 Тээврийн салбарын зарлага болон ДНБ-д эзлэх хувь

2012-2021 оны гүйцэтгэлээр Монгол улсын төсвийн нийт зардлаас 2.18-14.78 хувийг тээврийн салбарт зарцуулсан байна. Тодруулбал: 2016 онд тус салбар нь төсвийн зардлын 14.78 хувийг эзэлж бусад жилүүдээс хамгийн өндөр байсан бол 2021 онд салбарын зардал тасралтгүй буурч 2021 онд 2.25 хувьд хүрсэн байна.

Харин улсын нийт ДНБ-д салбарын ДНБ-ий эзлэх хувь мөн хугацаанд 3.8-5.9 хүртэл хувь байгаа бөгөөд 2021 оны байдлаар 5.01 хувь байна. 2012-2021 онд тээврийн салбарын төсвийн зарлагад эзлэх хувь хэмжээ нь 2016 оноос хойш огцом буурсан бөгөөд салбарын ДНБ-ий эзлэх хувь мөн буурсан үзүүлэлттэй байна. (Зураг 21)

Зураг 21. Зам тээврийн салбарын ДНБ ба төсвийн зарлагын үзүүлэлт




Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, 2022

### 4.3.3 Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн салбарын зарлага болон ДНБ-д эзлэх хувь

ХХААХҮ салбарт зарцуулсан улсын нийт төсвийн зардлын хувь өнгөрсөн 10 жилд мэдэгдэхүйц огцом өөрчлөлтгүй буюу 1.47-3.24 хүртэл хувьтай байна. 2012-2021 онуудад салбарын ДНБ нь улсын нийт ДНБ-ий бүрэлдхүүнд 11-14 хүртэл хувь эзэлж байсан. Төсвийн зардлаас салбарт хуваарилсан дүн нь 2013 онд 3.24 хувь, 2020 онд 3.07 хувь тус тус байсан бол, бусад онуудад 3 хувиас бага дүнгээр зарцуулж байна. Салбарын ДНБ нь нийт ДНБ-д 11-14 хувийг тогтвортой бүрдүүлж ирсэн нь эдийн засгийн гол салбаруудын нэг мөн юм. Гэвч энэ салбарт сүүлийн 10 жилд ХХААХҮ-ийн салбарт жижиг дунд үйлдвэрт зориулсан хөнгөлттэй зээл болон буцалтгүй тусламжийн санхүүжилт зарцуулагдагдсан ч салбарын эдийн засгийг бүрдүүлж буй ДНБ-ий хувьд нөлөөлөлгүй байна. Эндээс харахад эдийн засгийг дэмжих зорилгоор салбарт зарцуулагдаж буй гадаадын зээл, тусламж нь үр ашиггүй зарцуулагддаг учир МУ-ийн эдийн засагт дарамт учруулж байна гэж дүгнэж болохоор байна. (Зураг 22)

Зураг 22. Хүнс хөдөө аж ахуйн салбарын ДНБ ба төсвийн зарлагын үзүүлэлт




Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, 2022

#### 4.3.4 Барилгын салбарын зарлага болон ДНБ-д эзлэх хувь

Монгол улсын нийт төсвийн зардалд барилгын салбарын зардлын эзлэх хувийн жин өнгөрсөн 10 жилд 0.79-3.46 хувь байв. Тодруулбал өнгөрсөн 10 жилийн хугацаанд 2013 онд төсвийн зардлын 3.46 хувиар санхүүжсэн ба бусад онуудад 0.79-1.94 хувийн хооронд, 2021 оны байдлаар 1.64 хувьтай байсан. Улсын ДНБ-д салбарын ДНБ-ий эзлэх хувь өнгөрсөн 10 жилд 3.6-5.9 хүртэл хувьтай байна. Өнгөрсөн 10 жилийн хугацаанд, 2012 онд нийт ДНБ-ий 5.9 хувийг барилгын салбар бүрдүүлж байсан бол түүнээс хойш буурч 2021 онд салбарын ДНБ 3.7 хувьтай байна. (Зураг 23)

Зураг 23. Барилгын салбарын ДНБ ба төсвийн зарлагын үзүүлэлт




Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, 2022

#### 4.3.5 Боловсролын салбарын зарлага болон ДНБ-д эзлэх хувь

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зарлагад боловсролын салбарын зарлагын эзэлж буй хувь 2012-2019 онд 18-20 хувь орчим байсан бол 2020-2021 онд 13-14 хувь болж буурсан үзүүлэлттэй байна. Салбарын ДНБ-ий хувь өнгөрсөн 10 жилийн хугацаанд салбарын зардлын хэлбэлзлээс үл хамааран 3.8-4.50 хооронд тогтонги үзүүлэлттэй байсан. Иймд салбарын төсвийн зарцуулалт нь салбарын ДНБ-д богино хугацаанд нөлөө үзүүлдэггүй гэж үзэхээр байсан. Учир нь 2012-2015 онуудад боловсролын салбарт төсвийн зарцуулалтын хувь өсөөд 2016-2017 онуудад 1-2 хувиар буурсан ч нийт ДНБ-д мэдэгдэхүйц өөрчлөлт ороогүй байна. (Зураг 24)

Зураг 24. Боловсролын салбарын ДНБ ба төсвийн зарлагын үзүүлэлт




Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, 2022

#### 4.3.6 Уул уурхайн салбарын зарлага болон ДНБ-д эзлэх хувь

Монгол улсын нийт төсвийн зардалд уул уурхайн салбарын зардлын эзлэх хувь өнгөрсөн 10 жилд хамгийн бага 0.29-0.44 хүртэл хувь буюу маш бага хувийг эзэлж байв. Энэ нь уул уурхайн салбарт гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдсэнтэй холбоотой. Мөн нийт ДНБ-д салбарын ДНБ-ий эзлэх хувь өнгөрсөн 10 жилд 15.92-26.4 хувийн үзүүлэлттэй байгаа нь манай улсын хэмжээнд ДНБ-д өсөлт үзүүлж буй салбаруудын хамгийн өндөр үзүүлэлт юм. 2012 оноос хойш уул, уурхай, олборлох үйлдвэрлэлийн тоо болон дэлхийн зах зээл дэх түүхий эдийн үнэ өссөнөөр эдийн засгийн ихэнх хувийг бүрдүүлж чухал үүрэг гүйцэтгэж байна. Гэсэн хэдий ч дан ганц уул уурхайгаас хамааралтай байх нь энэ салбарт аливаа хүчин зүйлээс шалтгаалсан хүндрэл тулгарсан үед улсын эдийн засаг бүхэлдээ огцом унах, сөрөг талтай, маш өндөр эрсдэлтэй юм. (Зураг 25)

Зураг 25. Уул уурхайн салбарын ДНБ ба төсвийн зарлагын үзүүлэлт




Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, 2022

### 4.3.7 Эрчим хүчний салбарын зарлага болон ДНБ-д эзлэх хувь

Эрчим хүчний салбарт 2012 онд төсвийн зардлын 4.05 хувийг зарцуулж байсан бол 2021 онд 0.54 хувь болж буурсан үзүүлэлттэй байна. Улсын нийт ДНБ-д салбарын ДНБ-ий эзлэх хувь өнгөрсөн 10 жилд 1.3-2.3 хүртэл хувьтай байна. Сүүлийн 10 жилд эрчим хүчний салбарын зардлын эзлэх хувь өсөөгүй бөгөөд салбарын дотоодын нийт бүтээгдэхүүний эзлэх хувь ч мөн мэдэгдэхүйц өөрчлөлтгүй байсан. (Зураг 26)

Зураг 26. Эрчим хүчний салбарын ДНБ ба төсвийн зарлагын үзүүлэлт



Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, 2022


### 4.3.8 Нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн салбарын зарлага болон ДНБ-д эзлэх хувь

Монгол Улсын төсвийн нийт зарлагад нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн салбарын зарлагын эзэлж буй хувь 2013 онд 19.86 хувь байсан бол 2021 онд 39.38 хувь хүртэл өсжээ. ДНБ-д эзлэх салбарын ДНБ-ий үзүүлэлт нь өнгөрсөн 2012 онд 1.90 хувиас 2021 онд 2.39 хувь байна.

Төсвийн нийт зардал дахь тус салбарын төсвийн зарцуулалт 10 жилийн хугацаанд тасралтгүй өсөж 39 хувь буюу нийт зардлын дийлэнхийг эзэлж байгаа ч улсын ДНБ-д эзлэх хувийн жинд маш бага хувийг бүрдүүлдэг байна.

Энэ нь манай улс сүүлийн 10 жилд нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн салбарт улсын төсвийн ихэнх хэсгийн зарцуулсаар ирсэн ч энэ нь эдийн засагт хүндрэл учруулж байна гэж дүгнэж болохоор байна (Зураг 27).

Зураг 27. Нийгмийн хамгааллын салбарын ДНБ ба төсвийн зарлагын үзүүлэлт




Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, 2022

#### 4.3.9 Аялал жуулчлалын салбарын зарлага болон ДНБ-д эзлэх хувь

Монгол улсын нийт төсвийн зардлын дүнд аялал, жуулчлалын салбарт зарцуулсан зардал өнгөрсөн 10 жилд 0.74-1.90 хүртэл хувийг эзэлж байв.

Харин энэ салбарын ДНБ-ий нийт ДНБ-д эзлэх бүрдэл хувь өнгөрсөн 10 жилд 0.96-1.20 хүртэл хувийг эзэлж, аялал жуулчлалын салбарт зарцуулсан зардал нь эдийн засгийн өсөлтөд онцгой тэмдэглэхээр нөлөө үзүүлээгүй гэж харагдаж байна. Монгол улсад энэ салбарыг ДНБ-ийг нэмэгдүүлэх, эдийн засагт өсөлт авчрахаар бодлогын түвшинд зохион байгуулах боломжтой гэж дүгнэж байна. (Зураг 28)

Зураг 28. Аялал жуулчлалын салбарын ДНБ ба төсвийн зарлагын үзүүлэлт



Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, 2022



#### 4.4 Алсын хараа 2050 тогтвортой хөгжлийн зорилт ба гүйцэтгэл /Салбараар/

УИХ-ын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор "Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг баталсан. Энэ бодлогын баримт бичгийн хавсралтад нэр бүхий 3 салбарын (Уул уурхай, Боловсруулах аж үйлдвэр, Тээвэр агуулах) үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг батлан гаргасан ба бусад салбарт бодлогын зорилтын түвшинг илэрхийлээгүй орхисон байна.


Тодорхойлсон 3 салбарын 2025, 2030, 2050 онуудад хүрэх зорилтот түвшинг ийнхүү баталсан бөгөөд одоогийн буюу 2022 оны гүйцэтгэл ямархуу түвшинд байгааг тус бүрээр харуулав. (Хүснэгт 17, Зураг 29, Зураг 30, Зураг 31)

Хүснэгт 17. “АЛСЫН ХАРАА-2050” Үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Өнөөгийн түвшин	Хүрэх түвшин			Шалгуур үзүүлэлтийн тайлбар
					2022	2025	2030	
1	Уул уурхайн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	хувь	24.30	24.30	30.6	31.4	25.3	Эдийн засгийн салбаруудын хөгжлийн түвшинг ДНБ-д эзлэх хувиар хэмжинэ.
2	Боловсруулах аж үйлдвэрийн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	хувь	10.90	7.20	12.0	14.6	27.4	Эдийн засгийн салбаруудын хөгжлийн түвшинг ДНБ-д эзлэх хувиар хэмжинэ.
3	Тээвэр агуулахын салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	хувь	4.60	4.00	5.1	4.8	11.6	Эдийн засгийн салбаруудын хөгжлийн түвшинг ДНБ-д эзлэх хувиар хэмжинэ.

Эх сурвалж: УСХ, Алсын хараа 2050

Зураг 29. Уул уурхайн салбарын ДНБ-д эзлэх хувь, зорилтот түвшин




Эх сурвалж: УСХ, Алсын хараа 2050

Уул уурхайн салбар нь өнгөрсөн 10 жилд 16.4-24.3 хүртэлх хувийн ДНБ-ийг эдийн засагт бүрдүүлж ирсэн бөгөөд 2020 онд 23%, 2021 онд 24.7%, 2022 онд 24.3% байна.

“Алсын хараа 2050”-д эдийн засгийн хүрэх түвшинд тус салбарын ДНБ-ийг 2025 онд 30.6%, 2030 онд 31.4%, 2050 онд 25.3% бүрдүүлэх зорилт тавьжээ. (Зураг 29.)


Зураг 30. Боловсруулах үйлдвэрийн салбарын ДНБ-д эзлэх хувь, зорилтот түвшин



Эх сурвалж: УСХ, Алсын хараа 2050

Улсын ДНБ-д боловсруулах үйлдвэрийн эзлэх хувь өнгөрсөн 10 жилд 6.7-7.5 хүртэл хувьтай байна. Ирэх жилүүдэд боловсруулах үйлдвэрлэлээр бий болох ДНБ-ийн хүрэх түвшинг 2025 онд 12%, 2030 онд 14.6%, 2050 онд 27.4%-ийг бүрдүүлэх зорилт тавьсан. 2022 оны байдлаар 7.2 хувь буюу хүрэх түвшингээс хоцрогдолтой түвшинд байна. (Зураг 30)

Зураг 31. Тээврийн салбарын ДНБ-д эзлэх хувь, зорилтот түвшин



Эх сурвалж: УСХ, Алсын хараа 2050

Улсын ДНБ-д тээврийн салбарын ДНБ-ий эзлэх хувь 2012-2022 он хүртэл 3.7-5.4 хүртэл хувьтай байна. 2014-2018 онуудад салбарын гүйцэтгэлийн түвшин нь 2025, 2030 оны зорилтын түвшинд ойролцоо байсан бол 2019 -2021 онуудад дэлхий нийтийг хамарсан цар тахал Ковид-19-ийн нөлөөгөөр буурч 2022 оны байдлаар 4%-ийн үзүүлэлттэй байна.

Тээврийн салбарын ДНБ-д эзлэх хувийг 11.6 хувь бүрдүүлдэг байхаар 2050 оны зорилт дэвшүүлжээ (Зураг 31).

2022 оны өнөөгийн байдлыг “Алсын хараа 2050” хөгжлийн бодлого зорилтын хүрээнд 2025, 2030, 2050 оны хүрэх түвшинтэй харьцуулан авч үзэхэд 2025 оны зорилтоос Уул уурхай (20%-иар), Боловсруулах аж үйлдвэр (40%-иар), Тээвэр агуулах (20%-иар) салбарууд тус бүр доогуур байгаа үр дүн гарсан.


#### 4.5 ДНБ-д эзлэх Засгийн газрын зардлын хувийг улс орнуудын орлогын түвшний ангилалаар харьцуулсан шинжилгээ

Энэ хэсэгт улс орнуудын засгийн газрууд эдийн засгийн салбарууддаа хуваарилж буй зардлыг тухайн улсын ДНБ-д харьцуулан шинжилсэн. Ингэхдээ дэлхийн улс орнуудын орлогын түвшний ангилал (Өндөр-High income, Дундаас дээш-Upper middle income, Дундаас доогуур-Lower middle income, Бага-Low income) тус бүрээр харьцуулсан юм.

Монгол улсын хувьд орлогын түвшний ангилалаар дундаас доогуур (Lower middle income) ангилалд багтдаг.

Батлан хамгаалах салбарт төсвийн зардлын ДНБ-д эзлэх хувь манай улсад 0.8% байгаа нь адил ангилалын орлоготой орнуудтай дунджаас 2 дахин бага байдаг байна. (Зураг 32)


Зураг 32. Батлан хамгаалахын салбар дахь төсвийн зардлын ДНБ-д эзлэх хувь (улс орнуудын орлогын ангиллаар)



Эх сурвалж: Дэлхийн банк, Судалгааны багийн тооцоолол

Хөдөө аж ахуй салбарын тухайд төсвийн зардлын ДНБ-д эзлэх хувь 12% байгаа нь адил ангилалын орлоготой орнуудаас дунджаар 5% доогуур байдаг байна. (Зураг 33)


Зураг 33. Хөдөө аж ахуй салбар дахь төсвийн зардлын ДНБ-д эзлэх хувь (улс орнуудын орлогын ангиллаар)



Эх сурвалж: Дэлхийн банк, Судалгааны багийн тооцоолол

Эрүүл мэндийн салбарт төсвийн зардлын ДНБ-д эзлэх хувь манай улсад 4.0% буюу адил ангилалын орлоготой орнуудаас 1.4%-иар бага байна. (Зураг 34)


Зураг 34. Эрүүл мэндийн салбар дахь төсвийн зардлын ДНБ-д эзлэх хувь (улс орнуудын орлогын ангиллаар)



Эх сурвалж: Судалгааны багийн тооцоолол

Боловсролын салбарт төсвийн зардлын ДНБ-д эзлэх хувь манай улсад сүүлийн 10 оны үзүүлэлтээр дунджаар 4%-5% байгаа нь адил ангилалын орлоготой орнуудаас 1.0%-1.2%-иар өндөр байна. (Зураг 35)

Зураг 35. Боловсролын салбар дахь төсвийн зардлын ДНБ-д эзлэх хувь (улс орнуудын орлогын ангиллаар)



Эх сурвалж: Судалгааны багийн тооцоолол

#### 4.6 ДНБ-салбарын ангилал ба бусад голлох хүчин зүйлсийн шинжилгээ


Монгол улсын төсвийн салбарын ангилалд хувьсагч хүчин зүйлсийн хамаарлыг шугаман регрессийн болон олон хүчин зүйлийн регрессийн шинжилгээгээр хийж үр дүнг тайлбарласан болно.

##### 4.6.1 Шугаман регрессийн шинжилгээ



1991-2021 онуудын байдлаар төсвийн нийт зарлага болон ДНБ-ний 5 салбар тус бүрээр регрессийн шинжилгээг хийж шугаман тэгшитгэлээр доорх графикаар харуулав. Ашигласан тоон мэдээллийг (Хавсралт 7-с) харна уу.

Зураг 36. Шугаман регрессийн шинжилгээ



Төсвийн нийт зарлага ДНБ- хоорондоо хүчтэй эерэг хамааралтай буюу төсвийн зардал 1 сая төгрөгөөр нэмэгдэхэд дотоодын нийт бүтээгдэхүүн 2.9 сая төгрөгөөр нэмэгддэг. Тус үзүүлэлтийн детерминацийн коэффициент 98-тай гарсан.




Төсвийн нийт зарлага барилгын салбарын ДНБ- хоорондоо хүчтэй эерэг хамааралтай буюу төсвийн зардал 1 сая төгрөгөөр нэмэгдэхэд барилгын салбарын ДНБ 0.104 сая төгрөгөөр нэмэгддэг. Тус үзүүлэлтийн детерминацийн коэффициент 94-тай гарсан.




Төсвийн нийт зарлага эрүүл мэндийн салбарын ДНБ хоорондоо хүчтэй эерэг хамааралтай буюу төсвийн зардал 1 сая төгрөгөөр нэмэгдэхэд эрүүл мэндийн салбарын ДНБ 0.06 сая төгрөгөөр нэмэгддэг. Тус үзүүлэлтийн детерминацийн коэффициент 98-тай гарсан.




Төсвийн нийт зарлага уул уурхайн салбарын ДНБ хоорондоо хүчтэй эерэг хамааралтай буюу төсвийн зардал 1 сая төгрөгөөр нэмэгдэхэд уул уурхайн салбарын ДНБ 0.68 сая төгрөгөөр нэмэгддэг. Тус үзүүлэлтийн детерминацийн коэффициент 94-тай гарсан.



Төсвийн нийт зарлага хөдөө аж ахуйн салбарын ДНБ хоорондоо хүчтэй эерэг хамааралтай буюу төсвийн зардал 1 сая төгрөгөөр нэмэгдэхэд хөдөө аж ахуйн салбарын ДНБ 0.35 сая төгрөгөөр нэмэгддэг. Тус үзүүлэлтийн детерминацийн коэффициент 97-тай гарсан.



Төсвийн нийт зарлага боловсролын салбарын ДНБ хоорондоо хүчтэй эерэг хамааралтай буюу төсвийн зардал 1 сая төгрөгөөр нэмэгдэхэд зарлага боловсролын салбарын ДНБ 0.12 сая төгрөгөөр нэмэгддэг. Тус үзүүлэлтийн детерминацийн коэффициент 98-тай гарсан.



Эх сурвалж: Судалгааны багийн тооцоолол

#### 4.6.2 Олон хүчин зүйлсийн регрессийн шинжилгээ

ДНБ-д эзлэх Хөдөө аж ахуй, Хөдөлмөр нийгмийн хамгаалал, Боловсрол, Уул уурхай салбар тус бүрд тухайн онцлогоос хамааран үл хамааран хувьсагчийг сонгон авч олон хүчин зүйлийн шинжилгээ хийсэн. Ингэхдээ регрессийн шинжилгээнд ач холбогдлыг нэмэгдүүлэх байдлаар хамааран болон үл хамааран хувьсагчдаас өсөлтийн хувиар авсан байдлаар үнэлгээ хийн гүйцэтгэсэн. Хувьсагчийн ач холбогдол \* бол 90 хувийн ач холбогдлын түвшин, \*\* бол 95 хувийн ач холбогдолтой, \*\*\* бол 99 хувийн ач холбогдолтой гэх байдлаар тэмдэглэсэн. Үнэлгээнд ашигласан салбар тус бүрд ашигласан тоон өгөгдлийг дараах байдлаар харууллаа.

Хүснэгт 18. Хөдөө аж ахуйн салбарын судалгаанд ашиглаж буй тоон өгөгдөл

№	Хувьсагч	Тэмдэглэгээ
1	Хөдөлмөрийн бүтээмж	Ybuteemj
2	ДНБ/Хөдөө аж ахуйн салбар	YAgroGDP
3	Мал аж ахуйн салбарын нийт үйлдвэрлэл	YAgroTotalProd
4	ХАА- н салбарын бүтээгдэхүүн /мах, сүү ноос, ноолуур /	Product
5	Малтай өрхийн тоо	MaltaiUrkh

Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, 2022

Уг судалгаанд Хөдөө, аж ахуйн салбарын Хөдөлмөрийн бүтээмж (1), Салбарын ДНБ (2), Мал аж ахуйн салбарын үйлдвэрлэл (3), ХАА-н салбарын бүтээгдэхүүн (4), Малтай өрхийн тоо (5) 1995 оноос 2020 он хүртэлх тоон мэдээллийг ашигласан бөгөөд хамгийн бага квадратын аргыг ашиглан хувьсагчдын хоорондын хамаарлын хүчийг шалгасан. Регрессийн загвар дараах байдлаар тодорхойлсон.



$$\text{Log}(Y_{\text{Buteemj}}) = C + \beta_1 \log(\text{Maltaiurkh})$$

Хүснэгт 19. Хөдөө аж ахуйн салбарын регрессийн үнэлгээ01

Хувьсагч	Коэффициент	Стандарт хазайлт	Магадлал	Ач холбогдол
MALTAIURKH	1.796718	0.957907	0.0724	*

Хөдөө аж ахуйн салбарын бүтээмж болон малтай өрхийн хоорондын хамаарлын коэффициент нь 1.79 буюу эерэг хамааралтай байна. Малтай өрхийг тоог 1% нэмэгдэх нь Хөдөө аж ахуйн салбарын бүтээмжийг 1.7 хувь нэмэгдүүлдэг. Өөрөөр хэлбэл малтай өрхийн тоо нэмэгдэх нь салбарын бүтээмжийг өсгөж байна (Хүснэгт19).

$$\text{Log}(Y_{\text{agroGDP}}) = C + \beta_1 \log(\text{PRODUCT})$$

Хүснэгт 20. Хөдөө аж ахуйн салбарын регрессийн үнэлгээ02

Хувьсагч	Коэффициент	Стандарт хазайлт	Магадлал	Ач холбогдол
PRODUCT	1.075373	0.35823	0.0149	***

Хөдөө аж ахуйн салбарын ДНБ болон “Product буюу малын гаралтай бүтээгдхүүний гарцын нийлбэр үнийн дүн” хоорондын хамаарлын коэффициент нь 1.07 буюу эерэг хамааралтай байна. Өөрөөр хэлбэл малын гаралтай бүтээгдхүүний гарц нэмэгдэх нь салбарын ДНБ-ийг өсгөдөг байна (Хүснэгт 20).

$$\text{Log}(Y_{\text{AGROTOTALPROD}}) = C + \beta_1 \log(\text{PRODUCT})$$

Хүснэгт 21. Хөдөө аж ахуйн салбарын регрессийн үнэлгээ03

Хувьсагч	Коэффициент	Стандарт хазайлт	Магадлал	Ач холбогдол
PRODUCT	1.033153	0.352909	0.0168	***

Мал аж ахуйн салбарын нийт үйлдвэрлэл болон “Product буюу малын гаралтай бүтээгдхүүний гарцын нийлбэр үнийн дүн” хоорондын хамаарлын коэффициент нь 1.03 буюу эерэг хамааралтай байна. Өөрөөр хэлбэл малын гаралтай бүтээгдхүүний гарц нэмэгдэх нь мал аж ахуйн салбарын нийт үйлдвэрлэлийг өсгөдөг байна (Хүснэгт 21).

$$\text{Log}(Y_{\text{Buteemj}}) = C + \beta_1 \log(\text{PRODUCT})$$

Хүснэгт 22. Хөдөө аж ахуйн салбарын регрессийн үнэлгээ04

Хувьсагч	Коэффициент	Стандарт хазайлт	Магадлал	Ач холбогдол
PRODUCT	0.537363	0.270818	0.0785	*

Хөдөө аж ахуйн салбарын бүтээмж болон “Product буюу малын гаралтай бүтээгдхүүний гарцын нийлбэр үнийн дүн” хоорондын хамаарлын коэффициент нь 0.53 буюу эерэг хамааралтай байна. Өөрөөр хэлбэл малын гаралтай бүтээгдэхүүний гарц нэмэгдэх нь мал аж ахуйн салбарын бүтээмжийг өсгөдөг байна (Хүснэгт 22).

Хүснэгт 23. Хөдөлмөр,нийгмийн хамгааллын салбарын судалгаанд ашиглаж буй тоон өгөгдөл

№	Хувьсагч	Статистик үзүүлэлт
1	Хөдөлмөр эрхлэлтийн түвшин	EmpLevel
2	Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	LaborGDP
3	Тэтгэвэр авагчид	tetgeverAvagch
4	Нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээл	TotalGov
5	Нийгмийн даатгалд даатгуулагчдын тоо	TotalDaatguulagch
6	Албан журмаар даатгуулагчдын тоо	AlbanDaatguulagch
7	Сайн дураар даатгуулагчдын тоо	SainduriinDaatguulagch

Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, 2022

Уг судалгаанд хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хөдөлмөр эрхлэлтийн түвшин (1), Салбарын ДНБ (2), Тэтгэвэр авагчдын тоо (3), Нийт зарлага ба эргэж төлөгдөх зээл (4), Даатгуулагчдын тоо (5), Албан журмаар даатгуулагчдын тоо (6), Сайн дураар даатгуулагчдын тоо (7) 1993 оноос 2021 он хүртэлх тоон мэдээллийг ашигласан бөгөөд хамгийн бага квадратын аргыг ашиглан хувьсагчдын хоорондын хамаарлын хүчийг шалгасан. Регрессийн загвар дараах байдлаар тодорхойлсон.

$$\text{Log}(\text{LaborGPD}) = C + \beta_1 \log(\text{TotalGOV})$$

Хүснэгт 24. Хөдөлмөр,нийгмийн хамгааллын салбарын регрессийн үнэлгээ

Хувьсагч	Коэффициент	Стандарт хазайлт	Магадлал	Ач холбогдол
C	0.13254	0.04934	0.0122	***
TOTALGOV	0.456084	0.06619	0	***

Хөдөлмөр нийгмийн хамгааллын салбарын ДНБ болон засгийн газрын нийт зардал хоорондын хамаарлын коэффициент нь 0.45 буюу эерэг хамааралтай байна. засгийн газрын нийт зардал 1% нэмэгдэх нь Хөдөлмөр нийгмийн хамгааллын салбарын ДНБ-г 0.45 хувь нэмэгдүүлдэг. Өөрөөр хэлбэл засгийн газрын нийт зардал нь салбарын ДНБ-г өсгөдөг байна (Хүснэгт 24).

Хүснэгт 25. Уул уурхайн салбарын судалгаанд ашиглаж буй тоон өгөгдөл

№	Хувьсагч	Статистик үзүүлэлт	Эх сурвалж
1	Бүтээмж	Productivity	ҮСХ www.1212.mn
2	Салбарын ДНБ	MiningGPD	ҮСХ www.1212.mn
3	Салбарын ажиллагсадын тоо	MiningEmp	ҮСХ www.1212.mn
4	Дотоод хөрөнгө оруулалт	inINV	ҮСХ www.1212.mn
5	Гадаад хөрөнгө оруулалт	ForeINV	ҮСХ www.1212.mn
6	Нүүрсний үнэ	Coal	<a href="https://ourworldindata.org/grapher/coal-prices">https://ourworldindata.org/grapher/coal-prices</a>
7	Зэсийн үнэ	Copper	<a href="https://www.investing.com/commodities/newcastle-coal-futures-historical-data">https://www.investing.com/commodities/newcastle-coal-futures-historical-data</a>

Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, 2022

Тус судалгаанд уул уурхайн салбарын Бүтээмж (1), Салбарын ДНБ (2), Дотоод хөрөнгө оруулалт (3), Гадаад хөрөнгө оруулалт (4), Нүүрсний үнэ (5), Зэсийн үнэ (7) 1996 оноос 2021 он хүртэлх тоон мэдээллийг ашигласан бөгөөд хамгийн бага квадратын аргыг ашиглан хувьсагчдын хоорондын хамаарлын хүчийг шалгасан.

Регрессийн загвар дараах байдлаар тодорхойлсон.

$\log(\text{MiningGPD})$

$$= C + \beta_1 \log(\text{Coal}) + \beta_2 \log(\text{Copper}) + \beta_3 \log(\text{Foreinv}) + \beta_4 \log(\text{TotalInv}) + \beta_5 \log(\text{GOVexp})$$

Хүснэгт 26. Уул уурхайн салбарын регрессийн үнэлгээ

Хувьсагч	Коэффициент	Стандарт хазайлт	Магадлал	Ач холбогдол
COAL	-0.115034	0.116996	0.3411	
COPPER	0.892324	0.161964	0.0001	***
FOREINV	1.245862	0.447024	0.0138	***
ININV	1.262276	0.361272	0.0033	***

Уул уурхайн салбарын ДНБ-ийг хамааран хувьсагчаар авсан. Дэлхийн зах зээл дээрх нүүрсний үнэ (-0.11 ач холбогдолгүй), зэсийн үнэ 1% өсөхөд салбарын ДНБ/ олборлолт 0.89% нэмэгддэг, гадаадын хөрөнгө оруулалт 1% өсөхөд тус салбарын ДНБ 1.24 хувиар өсдөг, дотоодын хөрөнгө оруулалт 1% өсөх нь салбарын ДНБ-г 1.26 өсгөдөг. (Хүснэгт 26).

Хүснэгт 27. Боловсролын салбарын судалгаанд ашиглаж буй тоон өгөгдөл

№	Хувьсагч	Статистик үзүүлэлт
1	Салбарын ДНБ	EduGDP
2	Засгийн газрын нийт зардал	GovEXP
3	Боловсролын салбарын зардал	EduExp
4	Ерөнхий боловсролын сурагчдын тоо	Student
5	Ерөнхий боловсролын сурагчдын тоо	School
6	Ерөнхий боловсролын сургуулийн тоо	EduEmp
7	Боловсролын салбарын хөрөнгө оруулалт	EduInvest

Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, 2022

Ингэхдээ судалгаанд боловсролын салбарын ДНБ (1), Засгийн газрын нийт зардал (2), Салбарын нийт зардал (3), ЕБС сурагчидын тоо (4), ЕБ сургуулийн тоо (5), Ажиллагсдын тоо (6), Хөрөнгө оруулалт (7) 2001 оноос 2021 он хүртэлх тоон мэдээллийг ашигласан бөгөөд хамгийн бага квадратын аргыг ашиглан хувьсагчдын хоорондын хамаарлын хүчийг шалгасан. Регрессийн загвар дараах байдлаар тодорхойлсон.

$$\begin{aligned}
 \text{Log}(\text{EduGDP}) &= C + \beta_1 \log(\text{EduExp}) + \beta_2 \log(\text{EDUEXPPERPerson}) \\
 &+ \beta_3 \log(\text{EDUINVEST}) + \beta_4 \log(\text{GOVEXP}) + \beta_5 \log(\text{SCHOOL}) \\
 &+ \beta_6 \log(\text{STUDENT})
 \end{aligned}$$

Хүснэгт 28. Боловсролын салбарын регрессийн үнэлгээ

Хувьсагч	Кoeffицент	Стандарт хазайлт	Магадлал	Ач холбогдол
EDUEXP	4.631577	1.654232	0.0232	**
EDUEXPPER	-5.123283	1.929415	0.029	**
EDUINVEST	0.052132	0.049435	0.3224	
GOVEXP	-3.562938	1.567987	0.0527	**
SCHOOL	9.882451	5.5225	0.1113	
STUDENT	-3.720436	1.947638	0.0925	

Боловсролын салбарын ДНБ-ийг хамааран хувьсагчаар авсан. Засгийн газраас боловсролын салбарт зориулсан төсвийн зардлыг 1% өсгөх нь боловсролын салбарын ДНБ-ийг 4.63% нэмэгдүүлдэг бол нэг сурагчид ногдох засгийн газрын зардал 1% нэмэгдэх нь тус салбарыг (-5.12%) бууруулдаг.

Түүнчлэн засгийн газрын нийт зардал 1% нэмэгдэх нь боловсролын салбарыг (-3.56%) бууруулдаг, ерөнхий боловсролын сурагчдын тоо 1% нэмэгдэх нь салбарын ДНБ-ийг (-3.72) хувь бууруулдаг гэсэн хамаарлын үр дүнгүүд гарч байна (Хүснэгт 28).

Хүснэгт 29. Аялал жуулчлалын салбарын судалгаанд ашиглаж буй тоон өгөгдөл

№	Хувьсагч	Статистик үзүүлэлт
1	ДНБ салбар (зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ)	GDPTour
2	Аялал жуулчлалын салбарт оруулсан хөрөнгө оруулалт	TourINV
3	Улсын хилээр орсон жуулчдын тоо	Tourist
4	Ажиллагсад (Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ)	TourEmp

Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, 2022

Уг судалгаанд Аялал жуулчлалын салбарын ДНБ (1), Аялал жуулчлалын салбарт оруулсан хөрөнгө оруулалт (2), Улсын хилээр орсон жуулчдын тоо (3), Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбарт ажиллагсад (4) гэсэн хувьсагч хүчин зүйлсийг тодорхойлж 1991 оноос 2021 он хүртэлх тоон мэдээллийг ашигласан бөгөөд хамгийн бага квадратын аргыг ашиглан хувьсагчдын хоорондын хамаарлын хүчийг шалгасан.

Регрессийн загвар дараах байдлаар тодорхойлсон.

$$\text{Log}(GPDTour) = C + \beta_1 \log(TourINV) + \beta_2 \log(Tourist) + \beta_3 \log(TourEmp)$$

Хүснэгт 30. Аялал жуулчлалын салбарын регрессийн үнэлгээ

Хувьсагч	Коэффициент	Стандарт хазайлт	Магадлал	Ач холбогдол
TOUREMP	0.865275	0.703168	0.2497	
TOURIST	0.050808	0.32117	0.8778	
TOURINV	0.431469	0.175065	0.0359	**

Аялал жуулчлалын салбарын ДНБ-ийг хамааран хувьсагчаар авсан. Тус салбарт оруулж буй хөрөнгө оруулалт 1% өсгөх нь салбарын ДНБ-г 0.43% нэмэгдүүлдэг бөгөөд энэ нь 95% -ийн ач холбогдолтой гарсан. Харин аялагч жуулчдын тоо, үйлчилгээний салбарын ажиллагсдын тоо зэрэг нь ач холбогдолгүй үр дүнгүүд гарч байна (Хүснэгт 30).

### Шинжилгээний үр дүнгүүд

#### Төсвийн шалгуур үзүүлэлтээр шинжилгээний үр дүн

Үр дүн 1. Улсын нэгдсэн төсвийн орлого төлөвлөлтийг дэлхийн зах зээл дээрх зэсийн үнэд суурилдаг байна. Энэ үзүүлэлт төсвийн жил бүрийн орлого төлөвлөлтөд тооцогдож байна.

Үр дүн 2. “Төсвийн тогтвортой байдлын тухай хууль”-ийн 6 дугаар зүйлд заасны дагуу 2015-2017 онууд болон 2020-2021 он тус бүрд төсвийн тогтвортой байдлын шалгуур үзүүлэлтийг хангаж чадахгүй байна. Тухайлбал 2016 онд (-15.3%), 2017 онд (-6.2%), 2020 онд (-11.9%), 2021 онд (-6.7%) болж төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл хангагдаагүй.

Үр дүн 3. Төсвийн зардлын өсөлтийн хувь нь тухайн оны ДНБ-ий (эрдэс баялгийн бус) өсөлтийн хувиас хэтрэхгүй байгаа эсэхийг шалгаж үзлээ. 2017, 2018 онуудад тогтвортой байдлын энэ шалгуур үзүүлэлтийг хангаж байсан бол 2016 онд (-31%) цаашлаад 2019 онд (-9%), 2020 онд (-18%), тус тус зардлын хязгаарлалтыг хангаж ажиллаагүй байна. 2016, 2020 онууд нь сонгуулийн жил байсан бөгөөд төсвийн зардал илүү өндөр өсөлттэй байсан байна.

Үр дүн 4. Улсын нийт өр, зээлийн ДНБ-д эзлэх хувийг тооцоолохдоо улсын засгийн газрын нийт өр, тухайн жилийн оны үнээрх ДНБ-ийг авч үзлээ. 2015 онд тогтвортой байдлыг шалгуур үзүүлэлттэй ойролцоо түвшинд байсан бол 2016-2022 онуудад мөн л төсвийн тогтвортой байдлыг хангаж чадахгүй байна.

### **Төсвийн зарлага ба ДНБ хамаарлын шинжилгээний үр дүн**

Төсвийн зарлагын цар хүрээ (ДНБ-д эзлэх төсвийн зарлагын эзлэх хувь) нэмэгдэж 2021 онд 36%, 2022 онд 34% байна. Ялангуяа төсвийн алдагдал 2016 онд (-3,660.3) тэрбум төгрөг, 2020 онд (-4,440.5) тэрбум төгрөгт хүрч огцом нэмэгдсэн үеүдэд төсвийн зарлагын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 38%-д хүрсэн байна. Төсвийн цар хүрээний энэ үзүүлэлт өмнөд хөрш Хятад улсад (2001-2019) хамгийн ихдээ 16% түүнээс доош хувь хэмжээтэй байдаг (Zhang, 2022).

Үр дүн 1. Сүүлийн 20 жилийн хугацаанд буюу 2001-2022 оны хооронд төсвийн зарлага, нэрлэсэн ДНБ-ий абсолют хэмжээ аль аль нь 37 дахин өссөн байна. Төсвийн зарлагын өсөлтийн хувь жилд дунджаар 19.9 %, энэ жилүүдэд нэрлэсэн ДНБ-ий өсөлтийн хурд жилд дунджаар 19.0%, бодит ДНБ-ий өсөлтийн хурд 6.1% байгаа нь төсвийн зарлагын өсөлтийн хурдаас бага буюу төсвийн цар хүрээ тогтворгүй үзүүлэлттэй байна. (Тухайлбал Хятад улсад төсвийн зарлагын жилийн өсөлтийн хурд 8.5%, ДНБ-ий өсөлтийн хурд 21% байдаг байна).

Үр дүн 2. Монгол улсын ДНБ-ий өсөлтийн хувь нь төсвийн зарлагын өсөлтийн хурдаас хоцрогдолтой байгааг харж болно. Өнөөгийн нөхцөл байдлаар эдийн засгийн хөгжилд буурах дарамт байсаар байгаа бөгөөд үүний нэг шалтгаан нь төсвийн зарлагын өсөлтийн хурд буурахгүй, ДНБ-ий өсөлтийн хурд түүнээс давж нэмэгдээгүй байна.

### **Салбарын ДНБ, зарлагын шинжилгээ (эзлэх хувиар) -ний үр дүн**

Үр дүн 1. Эрүүл мэнд нийгмийн хамгаалал, боловсрол, зам тээвэр, батлан хамгаалах, хүнс, хөдөө, аж ахуй хөнгөн үйлдвэр, барилга, аялал жуулчлал болон уул, уурхай гэсэн салбаруудаар 2012-2021 оны Монгол улсын нийт төсвийн зардалд салбарын зардлын эзлэх хувь болон дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээгээр эдийн засагт үзүүлж буй нөлөөг шинжилж үзэв.

Үр дүн 2. Хөдөлмөр нийгмийн хамгаалалын салбарын ДНБ нь өнгөрсөн 2012-2021 онд 1.9-2.39 хувь байна. Төсвийн нийт зардал дахь тус салбарын төсвийн зарцуулалт 10 жилийн хугацаанд тасралтгүй өсөж 39 хувь буюу нийт зардлын дийлэнхийг эзэлж байгаа

ч ДНБ эзлэх хувийн жинд маш бага хувийг бүрдүүлдэг байна. Энэ нь Монгол улс сүүлийн 10 жилд нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн салбарт улсын төсвийн ихэнх хэсгийн зарцуулсаар ирсэн ч энэ нь улсын эдийн засагт хүндрэл учруулж байна гэж дүгнэж болохоор байна. Хятад улсын нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн зардал нь 2007-2019 оны байдлаар улсын төсвийнх нь 12 орчим хувьд тогтвортой байдаг тухай судалгаанд өгүүлсэн байна(Zhang, 2022).

Үр дүн 3. “Тогтвортой хөгжлийн зорилт”-ын хүрээнд төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогод энэ салбарт төсвийн зардлаас зарцуулах хувийг 2020 онд 3%, 2025 онд 4%-д хүргэх зорилт дэвшүүлсэн байна. Шинжилгээний үр дүнгээс харахад нийт төсвийн зардалд салбарын эзлэх хувь 2020 онд 3.07% буюу зорилтын хувийг хангасан бол, 2021 онд 1.47% байгаа нь зорилтын хувиас бага үзүүлэлттэй байна.

Мөн ТХЗ-ын бодлогын хүрээнд “ХАА-н ДНБ-ий 5 жилийн дундаж өсөлтийг 2020 онд 15, 2025 онд 20 хувьд хүргэх” зорилт тавьсан ч ДНБ-ий 2021 оны эцсээр 12 хувийг бүрдүүлж зорилтын хувьд хараахан хүрээгүй байна.

### **ДНБ-д эзлэх Засгийн газрын зардлын хувийг улс орнуудын орлогын түвшний ангилалаар харьцуулсан шинжилгээний үр дүн**

Үр дүн 1. Дэлхийн улс орнуудын орлогын түвшний ангилал (Өндөр-High income, Дундаас дээш-Upper middle income, Дундаас доогуур-Lower middle income, Бага-Low income) тус бүрээр харьцуулсан. Батлан хамгаалах салбарт төсвийн зардлын ДНБ-д эзлэх хувь манай улсад 0.8% байгаа нь адил ангилалын орлоготой орнуудтай дунджаас 2 дахин бага үзүүлэлт юм.

Үр дүн 2. Хөдөө аж ахуй салбарын тухайд төсвийн зардлын ДНБ-д эзлэх хувь 12% байгаа нь адил ангилалын орлоготой орнуудаас дунджаар 5% доогуур байдаг байна.

Үр дүн 3. Эрүүл мэндийн салбарт төсвийн зардлын ДНБ-д эзлэх хувь манай улсад 4.0% буюу адил ангилалын орлоготой орнуудаас 1.4%-иар бага байна.

Үр дүн 4. Боловсролын салбарт төсвийн зардлын ДНБ-д эзлэх хувь манай улсад сүүлийн 10 жилийн үзүүлэлтийн дунджаар 4%-5% байгаа нь адил ангилалын орлоготой орнуудаас 1.0%-1.2%-иар өндөр байна.

Өмнөд хөрш Хятад улс “Боловсрол бол зуун жилийн төлөвлөгөөний үндэс юм, иргэдийн боловсролын түвшин тухайн улсын үндэсний чанарыг илэрхийлдэг. Засгийн газрын хөрөнгө оруулалт нь боловсролын сангийн гол эх үүсвэр хэвээр байна гэдгийг чухалчилсаар ирсэн. Хятад улс 2012 онд улсынхаа ДНБ-д эзлэх боловсролын зардлын хувийг 4%-д хүргэх зорилт дэвшүүлж байсан бол аль хэдийн биелж, өнөөдрийн байдлаар Хятадын боловсролын салбарын ДНБ-д эзлэх хувь 15% орчим байна. Тус улсад боловсролын салбарын хөрөнгө оруулалтын үнэмлэхүй үнэ цэнийг ДНБ-ий өсөлтийн хурдтай нийцүүлэн нэн тэргүүнд тавиж ирсэн бөгөөд тэр дундаа сүүлийн жилүүдэд суурь боловсролд зориулсан салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, цаашид үүнийг илүү оновчтой болгох шаардлагатай байна гэж тэмдэглэжээ(Zhang, 2022).

## **Регрессийн шинжилгээний үр дүн**

**Хөдөө аж ахуйн салбар:** Хөдөө аж ахуйн салбарын бүтээмж болон малтай өрхийн хоорондын хамаарлын коэффициент нь 1.79 буюу **Малтай өрхийн тоо нэмэгдэх нь салбарын ДНБ-д үр нөлөөтэй байна.**

Хөдөө аж ахуйн салбарын ДНБ болон “Product буюу малын гаралтай бүтээгдэхүүний гарцын нийлбэр үнийн дүн” хоорондын хамаарлын коэффициент нь 1.07 буюу **бүтээгдэхүүний гарц нэмэгдэх нь салбарын ДНБ-д үр нөлөөтэй.**

Мал аж ахуйн салбарын нийт үйлдвэрлэл болон “Product буюу малын гаралтай бүтээгдэхүүний гарцын нийлбэр үнийн дүн” хоорондын хамаарлын коэффициент нь 1.03 **гарц нэмэгдэх нь салбарын нийт үйлдвэрлэлд үр нөлөөтэй байна.**

Хөдөө аж ахуйн салбарын бүтээмж болон “Product буюу Малын гаралтай бүтээгдэхүүний гарцын нийлбэр үнийн дүн” хоорондын хамаарлын коэффициент нь 0.53 буюу **гарц нэмэгдэх нь салбарын бүтээмжид сул нөлөөтэй байна.**

Хөдөө аж ахуйн салбарын төсвийн зарлагад 85-аас дээш хувийг эзэлдэг хөдөө аж ахуйн түүхий эдийн урамшуулал, татаасын эдийн засгийн үр нөлөөг хэмжих үүднээс урамшуулалд олгосон төсвийн зарлагын хэмжээ нь тухайн бүтээгдэхүүн болон түүгээр хийсэн боловсруулах салбарын бүтээгдэхүүний гарцын нийлбэр үнийн дүн нь салбарын ДНБ-д хэрхэн нөлөөлдөгийг регрессийн шинжилгээгээр тооцож үзэхэд эерэг, нөлөө үзүүлж байгаа боловч тухайн түүхий эдээр боловсруулсан нийт бүтээгдэхүүний хэмжээтэй хамаарал сул, бүтээмжид багахан нөлөөтэй харагдаж байна.

### **Уул үүрхайн салбар:**

Зэсийн үнэ 1% өсөхөд салбарын ДНБ/олборлолт 0.89% нэмэгддэг, гадаадын хөрөнгө оруулалт 1% өсөхөд салбарын ДНБ 1.24 хувиар өсдөг, дотоодын хөрөнгө оруулалт 1% өсөх нь салбарын ДНБ-г 1.26 өсгөдөг. **Зэсийн үнийн өсөлт, гадаадын/дотоодын хөрөнгө оруулалт зэрэг нь салбарын ДНБ-д эерэг үр дүнтэй нөлөөлдөг.**

**Боловсролын салбар:** Засгийн газраас боловсролын салбарт зарцуулалт 1% өсөх нь боловсролын салбарын ДНБ-г 4.63% нэмэгдүүлдэг, нийт засгийн газрын зардал 1% нэмэгдэх нь тус салбарын ДНБ-г (-3.56%) бууруулдаг. **Боловсролын салбарт зарцуулж буй засгийн газрын зардал эерэг үр нөлөөтэй бол засгийн газрын нийт зардал нэмэгдэх нь салбарын ДНБ-г бууруулдаг.**

### **Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбар:**

Засгийн газрын нийт зардал 1% нэмэгдэх нь Хөдөлмөр нийгмийн хамгааллын салбарын ДНБ-г **0.45 хувь** нэмэгдүүлдэг **эерэг үр нөлөөтэй байна.**

### **Аялал жуулчлалын салбар:**

Аялал жуулчлалын салбарт оруулж буй хөрөнгө оруулалтын хэмжээг 1% өсгөх нь салбарын ДНБ-г 0.43% нэмэгдүүлдэг байна.



## ДҮГНЭЛТ

Монгол улсын төсвөөс санхүүждэг салбаруудад олон улсын байгууллагуудаас хийсэн шинжилгээний нэгтгэл дүнгээр салбарын бодлогын зорилтууд болон төсвийн зарцуулалт хооронд уялдаагүй гэсэн дүгнэлтүүд гарсан байна. Засгийн газрын урсгал зардлыг хуваарилахдаа салбаруудын бодлогын зорилго, зорилттой нь уялдуулахгүй, нийгмийн халамж зэрэгт үр ашиггүй зарцуулах төлбөрийн тэнцлийн алдагдалд оруулах, эдийн засгийн өсөлтийг сааруулах, төсвийн зарцуулалтын гол зорилго болох ажилгүйдлийг бууруулах болон ажил эрхлэлтийг дэмжихэд чиглэхгүй байна.

Төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувь нь 2018 онд 29%, 2019 онд 31%, 2020 онд 37%, 2021 онд 36%, 2022 онд 34% болж тасралтгүй өсөлттэй байгаа нь ирээдүйд эдийн засаг төсөвт үзүүлэх ачааллыг салбараар дүгнэх асуудал тулгамдаж байна. Монгол улсын өнөөгийн байдлыг Дэлхийн банкны мэдээллээс шинжилж үзэхэд Засгийн газрын зарцуулалт ДНБ-д эзлэх түвшин нь 33 хувь байгаа нь 2020 оны байдлаар орлогын түвшнээр ойролцоо орнуудаас даруй 7.5 хувиар өндөр, дундаас дээгүүр орлоготой орнуудтай харьцуулахад 2.3 хувиар өндөр буюу төсвийн зарцуулалт өндөр түвшинд байгааг харуулж байна.

Төсвийн зарлагын цар хүрээ (ДНБ-д эзлэх төсвийн зарлагын эзлэх хувь) үзүүлэлт өмнөд хөрш Хятад улсад (2001-2019) хамгийн ихдээ 16% түүнээс доош хувь хэмжээтэй байдаг тухай судалгааны ажилд өгүүлсэн байна.

Эмпирик шинжилгээний хэсэгт 1991-2022 оны макро эдийн засгийн болон төсвийн зарлага, ДНБ-ий мэдээлэлд тулгуурлан шинжилж *1. Төсвийн тусгай шаардлагын шалгуур үзүүлэлт, 2. Төсвийн зарлага ба ДНБ хамаарал, 3. Салбарын ДНБ, төсвийн зарлага, 4. Алсын хараа-2050 ба тогтвортой хөгжлийн зорилт ба салбарын гүйцэтгэл, 5. ДНБ-д эзлэх ЗГ-ын зардлын хувийг улс орнуудын орлогын түвшний ангилалаар шинжлэх, 6. Салбарын ангилалыг шугаман болон олон хүчин зүйлийн регрессийн загвараар үнэллээ.*

МУ-ын Төсвийн тогтвортой байдлын тухай хууль тогтоомжид заасан “*төсвийн шаардлагын зохистой түвшин болон тусгай шаардлагууд*” шалгуур үзүүлэлтүүдийг 2015-2022 төсөв хангаж буй эсэхэд харьцуулсан шинжилгээ хийж үзэхэд өнгөрсөн хугацаанд зорилтот түвшинээс доогуур үзүүлэлттэй байгаа үр дүн гарсан.

Сүүлийн 20 жилийн хугацаанд буюу 2001-2022 оны хооронд төсвийн зарлага болон ДНБ нэрлсэн дүнгээрээ адил тэнцүү (37 дахин) өссөн ч төсвийн зарлагын жилийн өсөлтийн хувь нь 19.9%, нэрлэсэн ДНБ-ий өсөлтийн хувь жилд 19.0%, бодит ДНБ-ий өсөлтийн хувь жилд 6.1% байгаа нь төсвийн зарлагын өсөлтийн хурдаас бага, эдийн засгийн буурах дарамт бий болсны гол шалтгаан буюу төсөвт үзүүлэх ачаалал өндөр байсныг гэрчилнэ. (Тухайлбал: Хятад улсад төсвийн зарлагын жилийн өсөлтийн хурд 8.5%, ДНБ-ий өсөлтийн хурд 21% байдаг байна)

Төсвийн зарцуулалт болон салбарын өсөлтийн хооронд сөрөг хамаарал ажиглагдсан. Энэ нь төсвийн зарлага үр ашиггүй байгааг харуулж байна.

Салбарыг үнэлсэн индикаторууд нь статистикын хувьд ач холбогдолтой гарсан ба онолын судалгааны хувьд үр дүнтэй нийцтэй байна.

МУ-ын төсвийн зардлаас салбарт хуваарилсан урсгал зардлын дүн, нийт ДНБ-д эзлэх тухайн салбарын ДНБ-ийг 2021 оны байдлаар авч үзвэл Хүнс, хөдөө аж ахуйн салбарт төсвийн зардал 1.5% ба салбарын ДНБ 13%, Боловсролын салбарт төсвийн зардал 13% ба салбарын ДНБ 4%, Нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн салбарт төсвийн зардал 39% ба салбарын ДНБ 2%, Тээврийн салбарт төсвийн зардал 2% ба салбарын ДНБ 3.8%, аялал жуулчлалын салбарт төсвийн зардал 1.2% ба салбарын ДНБ 1%-тай байна.

Эмпирик шинжилгээний голлох үр дүнгүүдийг дурдвал:

Хөдөө аж ахуйн салбарын хувьд малтай өрхийн тоо нэмэгдэх нь салбарын ДНБ-д үр нөлөөтэй, мөн малын гаралтай бүтээгдэхүүний гарц нэмэгдэх нь тухайн салбарын нийт үйлдвэрлэлд үр нөлөөтэй байна.

Хөдөө аж ахуйн урамшуулалд олгосон төсвийн зарлагын хэмжээ нь салбарын ДНБ-д хэрхэн нөлөөлдөгийг регрессийн шинжилгээгээр тооцож үзэхэд эерэг нөлөө үзүүлж байгаа боловч тухайн түүхий эдээр боловсруулсан нийт бүтээгдэхүүний гарцын нийлбэр үнийн дүн нь салбарын ДНБ-ий хэмжээтэй хамаарал сул, бүтээмжид багахан нөлөөтэй харагдаж байна.

Уул уурхайн салбарын хувьд Зэсийн үнийн өсөлт, гадаад дотоодын хөрөнгө оруулалт зэрэг нь салбарын ДНБ-д эерэгээр нөлөөлдөг. Монгол улсын ДНБ нэрлэсэн дүнгээрээ өсөж байгаа ч гаднаас орж ирэх валютын урсгалын дүнгээрээ сүүлийн 11 жил зогсонги байдалд орсон байгаа нь манай улс дан ганц уул уурхайн салбараас тэр дундаа голлох түүхий эдийн гарц болон үнээс хамаардаг эдийн засгаа дотоод эх үүсвэрээр дэмжиж солонгоруулан хөгжүүлэх бодлого баримтлах цаг хэдийн болжээ.

Засгийн газрын зардлаас Боловсролын салбарт зарцуулж буй хөрөнгө оруулалт эерэг үр нөлөөтэй бол засгийн газрын нийт зардал нэмэгдэх нь салбарын ДНБ-ийг бууруулдаг.

Боловсролын салбарт төсвийн зардлын ДНБ-д эзлэх хувь манай улсад сүүлийн 10 оны үзүүлэлтээр дунджаар 4%-5% байгаа нь адил ангилалын орлоготой орнуудын түвшинтэй ойролцоо байна. Боловсролын салбарт хичээл, сургалтад хэрэгтэй бараа, үйлчилгээний төсвийг зарцуулах **гол субъект нь багш** гэдэг концепцийг практик болгох хэрэгтэй байна хэмээн ОУ-ын судалгааны тайланд онцолжээ. Өмнөд хөрш Хятад улс 2012 онд улсынхаа ДНБ-д эзлэх боловсролын зардлын хувийг 4%-д хүргэх зорилт дэвшүүлж байсан. Өнөөдрийн байдлаар энэ зорилт аль хэдийн биелж, одоогийн байдлаар Хятадын боловсролын зардлын ДНБ-д эзлэх хувь 15% орчим байна.

Хөдөлмөр нийгмийн хамгаалалын салбарт Засгийн газрын зардлын хэмжээ 1% өсөхөд, салбарын ДНБ 0.45%-р буюу маш бага хувиар нэмэгдүүлдэг үр нөлөөтэй байна.

Монгол улсын ДНБ-д эзлэх төсвийн зардлын хувийг дэлхийн улсуудтай тодруулбал орлогын түвшнээр адил ангилалын орнуудтай харьцуулахад батлан хамгаалах салбарын

үзүүлэлт дунджаас 0.8 хувиар буюу 2 дахин бага, хөдөө аж ахуй салбарт 5 хувиар бага, эрүүл мэндийн салбарт 1.4 хувиар бага, боловсролын салбарт 1.2 хувиар өндөр байна.

УИХ-ын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор "Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг баталсан. Энэ бодлогын баримт бичгийн хавсралтад нэр бүхий 3 салбарын (Уул уурхай, Боловсруулах аж үйлдвэр, Тээвэр агуулах) үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг 2025, 2030, 2050 оноор төлөвлөн баталсан ба бусад салбарт бодлогын зорилтын түвшинг илэрхийлээгүй орхисон байна. Эдийн засгийн салбаруудын хөгжлийн түвшинг ДНБ-д эзлэх хувиар хэмжсэн бөгөөд 2022 оны гүйцэтгэл нь 2020 оны суурь түвшинээс мөн л доогуур байна.

Шинжилгээ хийхэд тохиолдсон хүндрэл нь Засгийн газрын бүтцийн өөрчлөлттэй холбоотойгоор салбарын төсөв нэг багцаас өөр яамны харьяа багцад шилжилт явагддаг асуудал байсан тул салбарын зардлын шинжилгээ хийхэд тоон мэдээллийг чиг үүргийн дагуу нарийвчлан ангилж боловсруулсан. *(Тухайлбал 2012 онд 42 төсвийн ерөнхийлөн захирагчаар төсөв хуваарилдаг байсан бол 2021 оноос 32 төсвийн ерөнхийлөн захирагчтай байгаа, зарим салбаруудын нэгдэлт гэх мэт)*

Судалгааны дизайн, үе шатыг боловсруулж судалгааны зорилгод хүрэх зорилтууд тавьж өнөөгийн байдалд тулгуурлан ажиллаж тавьсан шинжилгээний үр дүнгүүд гарсан тул зорилгодоо хүрсэн гэж дүгнэж байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулахдаа нягтлан бодох бүртгэлийн хандлагаар дүгнэлтээ тайлагнаж байгаа ч эдийн засгийн хөгжилд үзүүлэх нөлөөллийн өгөөжийн хандлагыг орхигдуулж байна.

Судалгааг нэгтгэн дүгнэвэл манай улс эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдалд хүргэсэн хүндрэлтэй хүчин зүйлсээ илрүүлж, сайжруулах арга замыг эрэлхийлэх хэрэгцээ шаардлага бий болсныг харуулж байна.

Судалгаанаас Засгийн газрын зардлын дүнг батлахдаа салбарт оруулсан зардал, салбарын ДНБ-ий харьцаа үзүүлэлтийг эдийн засгийн үр ашиг бүхий байдлаар нөлөөллийг тооцох нь тохиромжтой гэсэн үр дүн гарсан ба эндээс салбарын бодлого, төсөв уялдаатай байх нь эдийн засгийн өсөлтийг урт хугацаанд дэмжих нэн тэргүүний асуудал гэдгийг харуулж байна.

## САНАЛ ЗӨВЛӨМЖ

- Монгол Улсын эдийн засгийн ихэнх хувийг уул уурхайн салбар бүрдүүлж байгаа нь эдийн засаг нэг салбараас бүрэн хараат болох эрсдэлтэй байна. Учир төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг төлөвлөхдөө дэлхийн зах зээлийн зэс болон нүүрсний үнэд суурилж төлөвлөж байгаа нь Монгол Улсын эдийн засаг зэс нүүрсний үнээс бүрэн хамааралтай гэж үзэхээр байна. Эдийн засгаа гадаад болон дотоод эх үүсвэрээр дэмжиж солонгоруулан хөгжүүлэх бодлого баримтлах,
- Цаашид Уул уурхайн салбараас бусад ДНБ бий болгодог Боловсруулах, Хүнс Хөдөө аж ахуй, тээвэр, Аялал жуулчлал, Боловсрол зэрэг салбаруудаар эдийн засгийг бүрдүүлэхэд анхаарах, ирээдүйд үүсч болох эрсдэл эдийн засгийн хямралаас сэргийлэх,
- Манай улсын хувьд засгийн газраас төсвийг хуваарилахдаа илүү боловсронгуй болгох, салбарын бодлогын зорилтыг судалгаа шинжилгээнд үндэслэн төсөвлөх, эдийн засгийн өсөлтөө дэмжих,
- Төсвийн ерөнхийлөн захирагчид төсвийн төслийг боловсруулахдаа, эдийн засгийн хэдэн хувийг тухайн салбарын ДНБ-ээр бүрдүүлэх төлөвлөгөөг улсын төсийн саналтай хамтад нь тусгах,
- Мөн жил бүрийн төсөв боловсруулахдаа салбар тус бүрийн бодлогын зорилтын хүрэх түвшинг дүгнэж, дараагийн төсвийн жилийн зорилтуудтай уялдуулан хэлцдэг байх,
- Олон улсын байгууллагуудын хөнгөлөлттэй зээл, төсөл хөтөлбөрт төлөвлөгөөтэйгээр хамруулдаг байх, эдийн засгийн үр ашиг авчрах салбарт хөрөнгө оруулалт хийж удирдах,
- Улсын төсвөөс санхүүждэг 32-42 төсвийн ерөнхийлөн захирагчдаас Монгол улсын эдийн засагт чухал үүрэг гүйцэтгэж буй салбараас, хүндрэл учруулж буй салбар хүртэл эрэмбэлэх, багасгах, үнэлгээ өгөх түүнчлэн үр ашиггүй салбарыг татан буулгах, өөрчлөн зохион байгуулах арга хэмжээ авах нь зүйтэй гэсэн санал зөвлөмжийг судалгааны багаас гаргасан болно.

## НОМ ЗҮЙ

### Монгол хэл дээрх эх сурвалж

- А.Батпүрэв. (2013). Төсвийн бодлогын макро эдийн засгийн нөлөөллийн шинжилгээ.
- Б.Ганболд. (2021). Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн салбарын төсвийн зарлагын шинжилгээ.
- Г.Цэвээндорж. (2021). Хөдөлмөрийн салбарын төсвийн зарлагын шинжилгээ.
- Л.Даваажаргал, О. (2019). ТӨСВИЙН БОДЛОГО ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ. Монгол улсын засгийн газар. (2012). Сангийн яамны төсвийн гүйцэтгэл.
- МонголБанк. (2018). *Сургалт судалгааны хүрээлэн*.
- Паркин. (2006). *Макроэкономикс*.
- Пүрэв-Очир, Л. Д. (2006). МОНГОЛ УЛСЫН 2005 ОНЫ ТӨСВИЙН.
- С.Эрдэмчимэг, А. (2021). Боловсролын салбарын төсвийн зарлагын шинжилгээ.
- Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. (2022). *1212.mn*. 1212.mn: [https://www.1212.mn/tables.aspx?tbl\\_id=DT\\_NSO\\_1300\\_015V1&SOUM\\_select\\_all=0&SOUMSingleSelect=\\_0&01\\_select\\_all=0&01SingleSelect=\\_1&YearQ\\_select\\_all=0&YearQSingleSelect=&YearY\\_select\\_all=0&YearYSingleSelect=\\_2020\\_2019\\_2018\\_2017\\_2016\\_2015\\_2014\\_2013\\_2012&vieww-ээс](https://www.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_1300_015V1&SOUM_select_all=0&SOUMSingleSelect=_0&01_select_all=0&01SingleSelect=_1&YearQ_select_all=0&YearQSingleSelect=&YearY_select_all=0&YearYSingleSelect=_2020_2019_2018_2017_2016_2015_2014_2013_2012&vieww-ээс) Гаргасан
- Тогтвортойхөгжил2030. (2021). Байгаль орчин аялал жуулчлалын тогтвортой хөгжлийн зорилгыг хангахад чиглэсэн төсвийн шинжилгээ.
- Төсөв ба боловсрол, шинжлэх ухааны салбарын тулгамдсан. (2018). *Төсөв, төсвийн бодлого гэж юу вэ?* , 28-39.
- УИХ. (2010 оны 6 24). *ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТУХАЙ* хууль. Эрх зүйн мэдээллийн систем: <https://legalinfo.mn/mn/detail/503-ээс> Гаргасан
- ҮСХ. (2022).
- Ч.Наранчимэг. (2018). Монгол улсын, хөдөө аж ахуйн тулгамдсан асуудлын уялдаа болон төсвийн орлого зарлагын төлөвлөлт. *Төсөв, төсвийн бодлого гэж юу вэ?*, 18-26.

## **Англи болон бусад хэл дээрх эх сурвалж**

- Agung Suwandar, T. A. (2021). Empirical Analysis on Public Expenditure for Education and Economic Growth: Evidence from Indonesia. *Economies* 2021, 146.
- Aksoy, L., Buoye, A., Aksoy, P., Larivière, B., & Keiningham, T. L. (2013). A cross-national investigation of the satisfaction and loyalty linkage for mobile telecommunications services across eight countries. *Journal of Interactive Marketing*, 27(1), 74-82.
- Alberto Alesina, S. A. (2008). Large Changes in Fiscal Policy: Taxes versus Spending.
- Alberto F. Alesina, S. A. (2009). LARGE CHANGES IN FISCAL POLICY:. *NATIONAL BUREAU OF ECONOMIC RESEARCH*.
- Çakır, V. (2001). Geleceğe Bir Dokunuş. *Mediacat Yayınları:Ankara*.
- Chen, J. (2018). Research on the Relationship between Government Size and Economic Growth. *College of Economics, Jinan University, Guangzhou, China*.
- Fouladi, M. (2010). The Impact of Government Expenditure on GDP,. *Iranian Economic Review, Vol.15, No.27, Fall 2010* .
- France, C., Merrilees, B., & Miller, D. (2016). An integrated model of customer-brand engagement: drivers and consequences. *Journal of Brand Management, Vol. 23 No. 2*, pp. 119-213.
- Gábor Kutasi, A. M. (2020). The long-term impact of public expenditures on GDP-growth. *Society and Economy*, 403-419.
- Gambetti, R., Biraghi, S., Schultz, D. E., & Graffigna, G. (2015). Brand wars: Consumer-brand engagement beyond client-agency fights. *Journal of Strategic Marketing*, 1-14.
- Gustafsson, A., Johnson, M. D., & Roos, I. (2005). The effects of customer satisfaction, relationship commitment dimensions, and triggers on customer retention. *Journal of Marketing*, 69(4), 210-218.
- heritage.org. (2023). <https://www.heritage.org/index/about>.  
<https://www.heritage.org/index/about>: <https://www.heritage.org/index/about-ᠭᠠᠮᠠᠨᠠᠭᠠᠨ>
- Ilzetzki, E. (2012). How big (small?) are fiscal multipliers? *Journal of Monetary Economics*.
- Jianhui, Z. (2022). Data Analysis of Fiscal Expenditure and GDP Based on Financial Budget Performance Evaluation Indicators. *Open Access Volume 2022* .
- Klemm, M. G. (2014). THE GROWTH IMPACT OF DISCRETIONARY FISCAL POLICY MEASURES. *WORKING PAPER SERIES*.

- Liu, Y. (2020). Research on Fiscal Expenditure Structure and High-Quality Economic Development: An Empirical Study Based on Panel Data from Chinese Provinces from 2007 to 2017. *American Journal of Industrial and Business Management* 10(02):232-249, 232-249.
- Michael Parkinson. (2006). *Macroeconomics*.
- Roberto, P. (2004). Estimating the effects of fiscal policy. <https://www.frbsf.org/economic-research/wp-content/uploads/sites/4/fpoecd.pdf>.-ээс Гаргасан
- Sabin, M., Adriana, M., & Cristina, T. R. (2015). Buildings brand identity. *Procedia Economics and Finance* 20, 3, 5-6.
- Schultz, D. E. (2007). Focus on brand changes rules of engagement. *Marketing news*, 15, 7-8.
- Symoom, T. (2018). The Impact of Fiscal Policy on Economic Growth:.
- Taiwo, M. (2011). <https://core.ac.uk/download/pdf/234624111.pdf>.-ээс Гаргасан
- Wan, C. G. (2022 оны 6 22). *A Study of Fiscal Expenditure Structure and Green Economic Growth Effects: A Sample from Asian Economies*. <https://www.ncbi.nlm.nih.gov/>: <https://www.ncbi.nlm.nih.gov/pmc/articles/PMC9526565/>-ээс Гаргасан
- Wan, C. G. (2022). A Study of Fiscal Expenditure Structure and Green Economic Growth Effects: A Sample from Asian Economies. *J Environ Public Health*.
- Wang, M. (2021). Fiscal policy and economic growth: some evidence from China. *Review of World Economics volume*.
- WorldBank.org. (2021). <https://data.worldbank.org/indicator/NY.GDP.MKTP.CD>. <https://databank.worldbank.org/home.aspx>: <https://data.worldbank.org/indicator/NY.GDP.MKTP.CD>-ээс Гаргасан
- Yuchen Song, J. M. (2023). Fiscal Decentralization, Regional Innovation and Industrial Structure Distortions in China. *Towards Sustainable Public Finances: Public Policy and Good Governance*.
- Zhang, J. (2022). Data Analysis of Fiscal Expenditure and GDP Based on Financial Budget Performance Evaluation Indicators. *Research Article | Open Access*.

## ХАВСРАЛТ

### Хавсралт 1. Хөдөө аж ахуйн салбарын үнэлгээ

Dependent Variable: LABORGDP

Method: Least Squares

Date: 04/21/23 Time: 21:17

Sample: 1993 2021

Included observations: 29

Variable	Coefficient	Std. Error	t-Statistic	Prob.
C	0.132540	0.049340	2.686287	0.0122
TOTALGOV	0.456084	0.066190	6.890571	0.0000
R-squared	0.637486	Mean dependent var		0.295127
Adjusted R-squared	0.624060	S.D. dependent var		0.380581
S.E. of regression	0.233349	Akaike info criterion		-0.006090
Sum squared resid	1.470199	Schwarz criterion		0.088207
Log likelihood	2.088300	Hannan-Quinn criter.		0.023443
F-statistic	47.47997	Durbin-Watson stat		1.655069
Prob(F-statistic)	0.000000			

### Хавсралт 2. Хөдөлмөр нийгмийн хамгааллын салбарын үнэлгээ

Dependent Variable: LABORGDP

Method: Least Squares

Date: 04/21/23 Time: 21:17

Sample: 1993 2021

Included observations: 29

Variable	Coefficient	Std. Error	t-Statistic	Prob.
C	0.132540	0.049340	2.686287	0.0122
TOTALGOV	0.456084	0.066190	6.890571	0.0000
R-squared	0.637486	Mean dependent var		0.295127
Adjusted R-squared	0.624060	S.D. dependent var		0.380581
S.E. of regression	0.233349	Akaike info criterion		-0.006090
Sum squared resid	1.470199	Schwarz criterion		0.088207
Log likelihood	2.088300	Hannan-Quinn criter.		0.023443
F-statistic	47.47997	Durbin-Watson stat		1.655069
Prob(F-statistic)	0.000000			



### Хавсралт 3. Уул уурхайн салбарын үнэлгээ

Dependent Variable: MININGPDY  
 Method: Least Squares  
 Date: 04/21/23 Time: 21:10  
 Sample (adjusted): 2002 2021  
 Included observations: 20 after adjustments

Variable	Coefficient	Std. Error	t-Statistic	Prob.
COAL	-0.115034	0.116996	-0.983226	0.3411
COPPER	0.892324	0.161964	5.509388	0.0001
FOREINV	1.245862	0.447024	2.787017	0.0138
ININV	1.262276	0.361272	3.493980	0.0033
TOTALINV	-2.130062	0.775757	-2.745786	0.0150
R-squared	0.664067	Mean dependent var		0.279000
Adjusted R-squared	0.574485	S.D. dependent var		0.274876
S.E. of regression	0.179306	Akaike info criterion		-0.387130
Sum squared resid	0.482259	Schwarz criterion		-0.138197
Log likelihood	8.871302	Hannan-Quinn criter.		-0.338536
Durbin-Watson stat	1.225340			

### Хавсралт 4. Боловсролын салбарын үнэлгээ

Dependent Variable: EDUGDP  
 Method: Least Squares  
 Date: 04/21/23 Time: 20:58  
 Sample (adjusted): 2008 2021  
 Included observations: 14 after adjustments

Variable	Coefficient	Std. Error	t-Statistic	Prob.
EDUEXP	4.631577	1.654232	2.799836	0.0232
EDUEXPPERC	-5.123283	1.929415	-2.655356	0.0290
EDUINVEST	0.052132	0.049435	1.054559	0.3224
GOVEXP	-3.562938	1.567987	-2.272301	0.0527
SCHOOL	9.882451	5.522500	1.789489	0.1113
STUDENT	-3.720436	1.947638	-1.910230	0.0925
R-squared	0.666809	Mean dependent var		0.191000
Adjusted R-squared	0.458565	S.D. dependent var		0.172351
S.E. of regression	0.126820	Akaike info criterion		-0.994571
Sum squared resid	0.128666	Schwarz criterion		-0.720689
Log likelihood	12.96199	Hannan-Quinn criter.		-1.019923
Durbin-Watson stat	2.167161			

Хавсралт 5. Монгол улсын ДНБ, Төсвийн зарлагын дүн 2001-2022он (тэрбум төг)

Он	НДНБ /тэрбум төгрөг/	ДНБ-ний өсөлтийн хувь	Төсвийн зарлага	Төсвийн зарлагын өсөлтийн хувь	Бодит ДНБ /тэрбум төгрөг/	Бодит ДНБ- ний өсөлтийн хувь	Инфляцийн түвшин
2001	1,424.7	10.3%	489.7	12.8%	1,310.8	3.0%	8.0%
2002	1,563.3	9.7%	548.6	12.0%	1,538.3	4.7%	1.6%
2003	1,848.0	18.2%	615.8	12.2%	1,761.1	7.0%	4.7%
2004	2,378.7	28.7%	752.5	22.2%	2,117.0	10.6%	11.0%
2005	3,041.4	27.9%	764.6	1.6%	2,752.5	7.3%	9.5%
2006	4,060.9	33.5%	1,237.0	61.8%	3,809.1	8.6%	6.2%
2007	5,042.5	24.2%	1,747.3	41.3%	4,144.9	10.2%	17.8%
2008	6,639.3	31.7%	2,466.8	41.2%	5,172.0	8.9%	22.1%
2009	6,568.4	-1.1%	2,336.6	-5.3%	6,292.5	-1.3%	4.2%
2010	9,756.6	48.5%	3,080.7	31.8%	8,488.2	6.4%	13.0%
2011	13,173.8	35.0%	4,997.0	62.2%	12,001.3	17.3%	8.9%
2012	16,688.4	26.7%	6,017.8	20.4%	14,352.0	12.3%	14.0%
2013	19,174.2	14.9%	6,164.7	2.4%	16,777.5	11.6%	12.5%
2014	22,227.1	15.9%	7,144.6	15.9%	19,915.4	7.9%	10.4%
2015	23,150.4	4.2%	7,138.0	-0.1%	22,710.5	2.4%	1.9%
2016	23,942.9	3.4%	9,495.3	33.0%	23,631.6	1.5%	1.3%
2017	28,010.7	17.0%	9,017.3	-5.0%	26,218.0	5.6%	6.4%
2018	32,582.6	16.3%	9,317.2	3.3%	29,943.4	7.7%	8.1%
2019	37,839.2	16.1%	11,661.7	25.2%	35,871.6	5.6%	5.2%
2020	37,453.3	-1.0%	13,904.2	19.2%	36,591.9	-4.6%	2.3%
2021	43,555.5	16.3%	15,630.4	12.4%	37,544.8	1.6%	13.8%
2022	52,867.4	21.4%	18,177.8	16.3%	45,888.9	4.8%	13.2%

Хавсралт 6. Төсвийн нийт зарлага болон ДНБ-д эзлэх хувь (салбараар)

САЛБАРЫН АНГИЛАЛ	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021
Хөдөө аж ахуй, днб	11.20%	13.39%	13.27%	14.00%	12.50%	11.00%	11.30%	11.50%	12.80%	13.02%
Хөдөө аж ахуй, т. зарлага	2.07%	3.24%	2.93%	2.10%	2.05%	2.17%	1.88%	1.82%	3.07%	1.47%
Уул уурхай, днб	17.80%	15.92%	17.00%	18.60%	20.70%	25.80%	26.40%	25.80%	24.10%	25.38%
Уул уурхай, т. зарлага	0.35%	0.44%	0.41%	0.34%	0.25%	0.41%	0.36%	0.40%	0.32%	0.29%
Цахилгаан, днб	1.30%	1.52%	1.58%	2.10%	2.30%	2.10%	2.00%	2.00%	2.10%	1.94%
Эрчим хүчний, т. зарлага	4.05%	3.00%	3.19%	0.71%	1.53%	1.65%	1.97%	1.18%	0.42%	0.54%
Барилга, днб	5.90%	5.83%	5.08%	4.40%	4.10%	3.60%	3.60%	4.00%	4.20%	3.70%
Барилга, т. зарлага	1.94%	1.97%	3.46%	0.79%	0.99%	1.17%	1.44%	1.75%	1.51%	1.64%
Тээвэр, днб	5.20%	4.25%	4.84%	5.20%	5.20%	4.60%	4.70%	4.40%	3.60%	3.80%
Тээвэр, т. зарлага	10.29%	11.16%	6.64%	4.93%	14.78%	9.24%	5.44%	2.65%	2.37%	2.18%
Үйлчилгээ, днб	1.20%	1.19%	0.99%	1.10%	1.20%	1.00%	1.20%	1.20%	1.00%	0.99%
Жуулчлалын, т. зарлага	1.90%	1.46%	1.16%	1.19%	0.74%	0.96%	1.19%	1.02%	1.24%	1.21%
Төрийн удирдлага, днб	4.20%	4.11%	4.08%	5.90%	5.90%	5.50%	4.90%	4.70%	5.40%	5.01%
Батлан хамгаалах, т. зарлага	3.55%	3.46%	3.71%	4.40%	3.11%	3.12%	3.15%	2.81%	2.51%	2.25%
Боловсрол, днб	4.50%	4.46%	4.48%	4.40%	4.50%	4.00%	3.80%	4.00%	4.40%	4.00%
Боловсрол, т. зарлага	20.55%	20.53%	23.11%	21.98%	18.40%	17.73%	20.56%	19.52%	14.50%	13.43%
Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд днб	1.90%	1.90%	1.88%	2.10%	2.00%	1.80%	1.80%	2.00%	2.30%	2.39%
Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд т. зарлага	25.16%	19.86%	21.64%	23.61%	20.90%	25.85%	27.87%	26.78%	30.03%	39.38%

Хавсралт 7. Бодит ДНБ-ий дүн, БДНБ-ий өсөлтийн хувь, Инфляцийн нөлөө (2000-2022)

Он	Бодит ДНБ /тэрбум төгрөг/	Бодит ДНБ-ний өсөлтийн хувь	Инфляцийн түвшин
2000	1,187	1.1%	8.1%
2001	1,311	3.0%	8.0%
2002	1,538	4.7%	1.6%
2003	1,761	7.0%	4.7%
2004	2,117	10.6%	11.0%
2005	2,752	7.3%	9.5%
2006	3,809	8.6%	6.2%
2007	4,145	10.2%	17.8%
2008	5,172	8.9%	22.1%
2009	6,293	-1.3%	4.2%
2010	8,488	6.4%	13.0%
2011	12,001	17.3%	8.9%
2012	14,352	12.3%	14.0%
2013	16,777	11.6%	12.5%
2014	19,915	7.9%	10.4%
2015	22,711	2.4%	1.9%
2016	23,632	1.5%	1.3%
2017	26,218	5.6%	6.4%
2018	29,943	7.7%	8.1%
2019	35,872	5.6%	5.2%
2020	36,592	-4.6%	2.3%
2021	37,545	1.6%	13.8%
2022	45,889	4.8%	13.2%

Хавсралт 8. Төсвийн зарлага болон ДНБ-салбарын өсөлтийн хувь 2010-2021

Он	Уул уурхай, олборлолт	Барилга	Боловсрол	Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	Төсвийн нийт зарцуулалт
2010	63%	190%	22%	36%	32%
2011	21%	61%	32%	16%	62%
2012	8%	108%	48%	64%	20%
2013	4%	17%	15%	13%	2%
2014	28%	1%	17%	15%	16%
2015	13%	-7%	0%	13%	0%
2016	16%	-2%	7%	4%	33%
2017	45%	0%	5%	5%	-5%
2018	19%	9%	9%	12%	2%
2019	15%	35%	24%	29%	26%
2020	-9%	3%	8%	14%	19%
2021	23%	0%	6%	23%	12%